

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

*Монгол Улсын Гавьяат хуульч, доктор (Sc.D), профессор,
цагдаагийн хурандаа Суурийн Жанцан агсаны нэрэмжит
эрдэм шинжилгээний хуралд зориулсан тусгай дугаар*



**ГЭМТ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ
АСУУДАЛ**

ОНОЛ, АРГА ЗҮЙН УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

**2023 №04 (87)
21 дэх жилдээ**

СЭТГҮҮЛИЙН БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Пүрэвдорж БАТБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бөхчулуун БАТ-ЭРДЭНЭ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Бадам БАТЗОРИГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Жигжидсүрэн БОЛДБААТАР

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Баатар БОЛДБААТАР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Галбат ГАНТӨМӨР

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Жамсран ДОЛГОРСҮРЭН

ДОКТОР (Sc.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Думбурай МЯГМАРЦЭРЭН

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Наваанпэрэнлэй ЖАНЦАН

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ХУУЛЬЧ, ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Очирхуяг ЗОРИГТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Чойжил НЯМСҮРЭН

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

Тамжид ОЮУНЧИМЭГ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Заяатхүү ТӨРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ХВАН И ГАБ

ДОКТОР, ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ ПРОФЕССОР

Батзэвэг ЭНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

ДУГААРЫГ ЭРХЛЭН ГАРГАСАН

Батзэвэг БАЯРБОЛД

МАГИСТР (LL.M)

Улсын бүртгэлийн дугаар 237

СЭТГҮҮЛИЙН РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Дорждамба ЗҮМБЭРЭЛЛХАМ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР, ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ХҮНДЭТ
ПРОФЕССОР

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Вандан-Иш АМАРСАНАА

ДОКТОР (Ph.D)

ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД

Баясгалан АЛТАНГЭРЭЛ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Батсүх АЛТАНСҮХ

ДОКТОР (Ph.D)

Шаравдорж АРИУНБИЛЭГ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Лувсан БАТ-ОЧИР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Рагчаасүрэн БАЯРМАГНАЙ

ДОКТОР (Ph.D), ПРОФЕССОР

Сэнгээ ГАНТУЛГА

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Энхсайхан ДАШГААДАН

ДОКТОР (Ph.D)

Буриад ЛХАГВАРАГЧАА

ДОКТОР (Ph.D)

Жаргалсайхан МӨНХБОЛД

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Намжилдорж МӨНХЗУЛ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бат-Ерөөл МӨНХДОРЖ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Бадарч НАРМАНДАХ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Доржсүрэнгийн НЯМДОРЖ

ДОКТОР (Ph.D)

Жутьяа НЯМДУЛАМ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Шархүү ЧУЛУУНБАТ

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Магмадорж ЭРДЭНЭБАЯР

ДОКТОР (Ph.D), ДЭД ПРОФЕССОР

Дорж ЭНХТӨР

ДОКТОР (Ph.D)

ГАРЧИГ

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, түүний эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал	<i>Х.Эрдэм-Ундрах Д.Хулан</i>	5
Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага, зарим улсын жишиг	<i>Б.Досжан</i>	15
ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Мөрдөн тогтоох чиг үүргийн агуулга, мөн чанар	<i>Н.Сайнбаяр</i>	22
Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад анхаарах зарим асуудал	<i>Д.Бат-Эрдэнэ</i>	35
Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг нотлох ажиллагаанд учирч буй хүндрэл, түүнээс гарах арга замын талаар явуулсан судалгааны үр дүн	<i>Б.Ганхуяг</i>	44
Money laundering through cryptocurrencies	<i>Lkhagvatsend Tserensuren</i>	47
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Хорихоос өөр төрлийн ялаас зайлсхийсэн ялтанд хүлээлгэх хариуцлага	<i>Я.Батгэрэл</i>	50
Шүүхээс өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалтын шинэчлэл	<i>С.Бямба-Эрдэнэ</i>	66
ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ		
Цагдаагийн алба хаагчийг албан үүргээ биелүүлэхтэй холбогдуулан халдаж байгаа үйлдэлд хүлээлгэж буй хариуцлага ба олон нийтийн хандлага	<i>Б.Баянмөнх</i>	81
Цагдаагийн байгууллагын Хар тамхитай тэмцэх газрын хүний нөөцийн зохион байгуулалтын өнөөгийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээ	<i>Ц.Хишигбаяр Б.Эрдэнэдалай</i>	90

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЭМНЭЛГИЙН ЧАНАРТАЙ АЛБАДЛАГЫН АРГА ХЭМЖЭЭ, ТҮҮНИЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

MEDICAL QUALITY COMPULSORY MEASURES, ITS REGULATION AND CHALLENGING PROBLEMS

*Х.Эрдэм-Ундрах
Хууль зүйн доктор (Ph.D)*

*Д.Хулан
МУИС-ийн Хууль зүйн сургуулийн магистрант,
БГД-ийн Прокурорын газрын прокурорын
чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах ажилтан*

Товч агуулга: Монгол Улсын шүүхийн практикт хэргийг шийдвэрлэхдээ хуулийг гол эх сурвалж болгодог. Энэхүү шинжээрээ манай улс Ром-Германы эрх зүйн бүлд хамаарч байдаг. Иймд нэг эрх зүйн бүлд багтах улсуудын эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний талаарх эрх зүйн зохицуулалтын нийтлэг болон ялгаатай талыг илрүүлэх замаар тэдгээр улсуудын сайн туршлагаас судлахыг зорилоо.

Abstract: In Mongolian court practice, the law is the main source when deciding cases. Due to this feature, our country is dependent on the Roman-German legal system. Therefore, we aim to study the good practices of those countries by identifying the common and different aspects of the legal regulation of the coercive medical measures of the countries that belong to the same legal system.

Түлхүүр үгс: Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, эрүүгийн хууль, эх газрын эрх зүйн бүл.

Keywords: Medical Coercive Measures, Criminal Law, Mainland Law Group.

Нэг.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, түүний эрх зүйн зохицуулалт, түүхэн уламжлал

1.1.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний ойлголт, ач холбогдол
Эрүүгийн хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хуульчилснаар эрүүгийн хариуцлагыг ял болон ялын бус бусад арга хэмжээ буюу албадлагын арга хэмжээ хэмээн ангилан авч үзсэн. Эрүүгийн хариуцлагын ялын бус, бусад арга хэмжээнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ болон үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ, хөрөнгө, орлогыг хураах арга хэмжээ багтдаг¹.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь шүүхээс гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан, гэмт хэрэг үйлдсэний дараа хэрэг хариуцах чадваргүй болсон нөхцөлд оногдуулдаг ялын бус эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ бөгөөд эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чухал үүрэг бүхий томоохон үр нөлөөтэй.

Эрүүгийн хууль нь хүн, төр, нийгэм, байгууллага, аж ахуйн нэгжүүдийн амин чухал эрх ашгийг гэмт халдлагаас хамгаалах зорилтыг удирдлага болгон хэрэгжүүлж байгаагаараа хүнлэг, энэрэнгүй зарчмыг хэрэгжүүлэх хэрэгсэл болдог.² Энэрэнгүй ёсны зарчим гэдэг нь юуны өмнө Монгол Улсын Эрүүгийн хууль хүний аюулгүй байдлыг

¹ Эрүүгийн хууль, §7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, УБ, 2015 он.

² Ханнс Зайделийн сан, Ж.Бямбаа нар, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, 47 дэх тал, УБ, 2013 он.

хангах байдлаар илэрнэ.³ Энэрэнгүй ёсны зарчим нь нэг талаас, нийгмийн гишүүдийн аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах зорилтыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, нөгөө талаас, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай болон энэ тухайд сэжиглэгдэн яллагдаж мөн шүүгдэж байгаа хүний эрхийг хангах гэсэн хоёр агуулгыг нэгэн зэрэг илэрхийлж байдаг өвөрмөц онцлогтой.⁴

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний зорилго нь нэг талаас нийгмийг тухайн этгээдийн дахин үйлдэж болзошгүй гэмт үйлдлээс хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх боловч үүнээс гадна нөгөө талаас эмчлүүлэгч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийгэмд ашигтай ажиллагаанд дасгах, өөртөө аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгыг агуулж байдаг буюу эмчлүүлэгчид илүүтэй чиглэгдсэн байдгаараа онцлогтой. Иймд эрүүгийн хуулийн энэрэнгүй ёсны зарчмын илрэл зайлшгүй мөн гэж үзнэ.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх гол үндэслэл нь “хэрэг хариуцах чадвар” байдаг. Хэрэг хариуцах чадвар нь хүний өөрийн үйлдлийг хариуцаж буюу жолоодож чадах чадвар юм. Ийм чадвар нь тодорхой насанд хүрсэн, байгал, нийгмийн хөгжлийн хуулийн талаар тодорхой мэдлэг, туршлага олж хуримтлуулсан үед бүрэлдэж буй болно.⁵ Хэрэг хариуцах чадваргүй байдлыг эмнэлгийн болон хууль зүйн

Академич С.Нарангэрэл “Хэрэг хариуцах чадваргүйн хоёр шалгуур харилцан уялдаатай бөгөөд заавал байх ёстой байдаг. Аль нэг нь байхгүй тохиолдолд хэрэг хариуцах чадваргүй байдал үгүйсгэгдэнэ.”⁶ гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, дээрх хоёр шалгуурын аль нэгийг нь хангаагүй тохиолдолд хэрэг хариуцах чадваргүй байдал үгүйсгэгдэж хэрэг хариуцах чадвартайд тооцно гэсэн үг юм.

Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй⁷ гэх боловч согтуурсан, мансуурсан үеийн хэрэг хариуцах чадварын тухай зайлшгүй авч үзэх хэрэгцээ шаардлага үүсдэг. Үүнийг “Actio libera in causa” гэх ба аливаа гэмт үйлдлийг хийх шийдвэр нь субъектын ухаан санаа эрүүл байхад бий болсон байх бөгөөд харин хожим яг гэмт үйлдэл хийх үед оюун ухаанаа алдсан байх утгыг агуулна. Энэхүү агуулгын дагуу гэмт санаа нь согтуурал болон мансуурлаас өмнө үүссэн байх учиртай бөгөөд өөрийгөө зориуд мансууруулан, согтууруулж гэмт хэрэг үйлдсэн, ухаан санаа эрүүл үедээ гэмт хэрэг үйлдэх магадлалтай гэдгээ мэдсэн субъектийг хэрэг хариуцах чадвартай хэмээн үзэж эрүүгийн хариуцлага оногдуулах⁸ явдал мөн.

Монгол Улсын эрүүгийн эрх зүйн түүхэн хөгжлийн хүрээнд 1921 оноос хойших эх сурвалжуудад дүгнэлт хийж үзэхэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэг хариуцах чадвартай голчлон холбож, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх шалгуурыг хэрэг хариуцах чадвараар тодорхойлж авч үзэж байсан.

1.2. Харьцуулсан судалгаа

Гадаад улсын эрдэмтэн, судлаачдын харьцангуй олонх нь үзэж байгаагаар эрх зүйн системийн загвар, бүлийн талаарх дараах хандлагыг сүүлийн үед хүлээн зөвшөөрөх болжээ⁹. Гэвч дийлэнх тохиолдолд эрх зүйн эх сурвалжаар нь дараах байдлаар ангилж авч үздэг хандлага өнөө ч зонхилж буй. Үүнд:

- Эх газрын эрх зүйн бүл буюу Ром-Германы эрх зүйн бүл

³ С.Нарангэрэл, Ж.Эрдэнэбулган, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж”, 22 дахь тал, УБ, 2019 он.

⁴ Ханнс Зайделийн сан, Ж.Бямбаа нар, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, 47 дахь тал, УБ, 2013 он.

⁵ С. Нарангэрэл, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги”, 157 дахь тал, УБ, 1999 он

⁶ С. Нарангэрэл, Ж. Эрдэнэбулган, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Үзэл баримтлал, уламжлал, сургамж”, 139 дахь тал, УБ, 2019 он

⁷ Эрүүгийн хууль, §6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, УБ, 2015 он.

⁸ Т.Золбоо, Эрүүгийн эрх зүй, ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц, 135 дахь тал, УБ, 2018 он.

⁹ Д.Баярсайхан, “Гадаад орнуудын эрүүгийн процессын эрх зүй”, 32 дахь тал, УБ, 2015 он.

- Жишгийн эрх зүйн бүл буюу Англи-Америкийн эрх зүйн бүл багтана.

Эх газрын эрх зүйн системд эрх зүйн үндсэн эх сурвалж нь төрөлжсөн хуулиуд байдгаас үүдэн шүүх нь эрх зүйг бүтээхгүй харин хэрэглэж, тайлбарлах эрх хэмжээтэй.¹⁰ Монгол Улсын шүүхийн практикт хэргийг шийдвэрлэхдээ хуулийг гол эх сурвалж болгодог. Энэхүү шинжээрээ манай улс Ром-Германы эрх зүйн бүлд хамаарч байдаг.¹¹ Иймд нэг эрх зүйн бүлд багтах улсуудын эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний талаарх эрх зүйн зохицуулалтын нийтлэг болон ялгаатай талыг илрүүлэх замаар тэдгээр улсуудын сайн туршлагаас судлахыг зорилоо.

Оросын Холбооны Улсын туршлага, харьцуулсан судалгаа

Оросын Холбооны Улс (цаашид “ОХУ” гэх) нь нэг талаас эх газрын системийн зүүн чиглэлийн тогтолцоонд хамаарах төрөлжсөн эрүүгийн хууль тогтоомж бүхий улс боловч нөгөө талаас хосолсон институци бүхий постсоциалист орны ангилалд багтахын дээр өөрийн эрх зүйн үнэт зүйл, нөлөөлөл, байр сууриа харьцангуй тогтвортой хадгалсаар ирсэн.¹² Түүнчлэн газар нутгийн хувьд хөрш орон болохын хувьд ОХУ-ыг харьцуулсан судалгаа хийхээр сонгон авсан болно.

ОХУ-ын Эрүүгийн хууль нь 1996 оны 06 дугаар сарын 13-ны өдөр батлагдан, 1997 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж буй бөгөөд 12 хэсэг, 34 бүлэг, 361 зүйлээс бүрдэнэ.

ОХУ-ын Эрүүгийн хуулийн Зургадугаар хэсэг буюу 97 дугаар зүйлээс 104 дүгээр зүйл хүртэл “Эрүүгийн эрх зүйн шинжтэй бусад арга хэмжээ”-г хуульчилсан байдаг. ОХУ-д эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг Эрүүгийн хуулийн 97 дугаар зүйлд заасны дагуу шүүх дараах этгээдүүдэд оногдуулдаг. Үүнд:

- Гэмт хэрэг үйлдсэн, хэрэг хариуцах чадваргүй этгээд,
- Гэмт хэрэг үйлдсэний дараа ял оногдуулах буюу гүйцэтгэх боломжгүй болохуйц байдалд сэтгэцийн эмгэгтэй болсон этгээд,
- Гэмт хэрэг үйлдэж, хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй болсон этгээд
- Хэрэг хариуцах чадвартай, арван найман наснаас дээш насны этгээд арван дөрвөн нас хүрээгүй хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн бөгөөд бэлгийн чиг хандлагын (педофиль) өвчин эмгэгтэй этгээд¹³ багтана.

Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулж авч үзэхэд гэмт хэрэг үйлдсэн, хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй болсон этгээд болон бага насны хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн, педофиль буюу бэлгийн дурыг төрүүлэхийн тулд бэлгийн бойжилтод нас нь хүрээгүй хүүхдүүдийг бэлгийн цорын ганц хэрэгсэл болгон ашигладаг¹⁴ донтой этгээдүүдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг “заавал” гэх нөхцөлтэйгөөр хэрэглэдгээрээ ялгагдаж байв. Үүн дундаа бага насны хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн, педофиль хүмүүст хэрэглэгддэг эмнэлгийн арга хэмжээ ихээхэн онцлог зохицуулалт байлаа. Хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй болсон этгээдэд шүүхээс ял шийтгэл оногдуулахдаа хорих ял эдэлж байгаа тохиолдолд хорих ангид, бусад төрлийн ял оногдуулсан бол амбулаториор сэтгэцийн эмгэг судлалын тусламж үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхээр хуульдаа мөн тусгажээ.

¹⁰ Д.Баярсайхан, “Эрх зүйн онол”, 114 дэх тал, УБ, 2010 он.

¹¹ Т.Золбоо, “Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги (Гэмт хэргийн бүтээц)”, 4 дахь тал, УБ, 2018 он.

¹² Д.Баярсайхан, “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”, 262 дахь тал, УБ, 2012 он.

¹³ Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир нар, “Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль”, 132 дахь, УБ, 2021 он.

¹⁴ С.Бямбасүрэн, “Сэтгэцийн эмгэг судлал”, 661 дэх тал, УБ, 2007 он.

Харин гэмт хэрэг үйлдсэн, хэрэг хариуцах чадваргүй этгээд, гэмт хэрэг үйлдсэний дараа ял оногдуулах буюу гүйцэтгэх боломжгүй болохуйц байдалд сэтгэцийн эмгэгтэй болсон этгээд, гэмт хэрэг үйлдэж, хэрэг хариуцах чадвартай боловч сэтгэцийн эмгэг өөрчлөлттэй болсон этгээдүүдийн сэтгэцийн байдлыг нийгэмд аюулгүй гэж үзвэл албадан эмчлэх бус сэтгэцийн эмчийн тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлгийн байгууллагад эмчлүүлэх, эмчилгээ, туслалцаа үзүүлэхээр шийдвэрлэх тухай ОХУ-ын Эрүүгийн хуулийн 97 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тусгасан.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний дэглэм, энэхүү дэглэмд хамаарах этгээдэд тавигдах шаардлагыг Эрүүгийн хуулийн 99 дүгээр зүйл болон 100 дугаар зүйлд хуульчилсан. Ингэхдээ:

- Сэтгэцийн байдал нь нийгэмд аюул учруулахааргүй, сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт хэвтүүлэх шаардлагагүй тохиолдолд албадан ажиглалт, амбулаториор сэтгэц мэдрэлийн эмнэлэгт албадан хамруулах,
- Сэтгэцийн байдал нь эрчимт ажиглалт шаардлагагүй тохиолдолд сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн “ердийн тасагт” албадан эмчлэх,
- Сэтгэцийн байдал нь байнгын ажиглалт шаардахуйц байгаа тохиолдолд сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн “тусгай тасагт” албадан эмчлэх,
- Сэтгэцийн байдал нь өөрт нь буюу бусад этгээдэд онцгой аюул учруулж байгаа ба байнгын эрчимт ажиглалт шаардахаар байгаа тохиолдолд сэтгэцийн эмгэг судлалын эмнэлгийн “тусгай тасагт эрчимт хяналттай” албадан эмчлэх¹⁵ гэх хөнгөнөөс хүндэд шилжих 4 төрлийн дэглэмийг тогтоосон байна.

ОХУ нь эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах хугацааг сунгах, өөрчлөх, зогсоох журмыг Эрүүгийн хуулийн 102 дугаар зүйлд хуульчилсан байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох үндэслэл байгаа эсэхийг тодорхойлохын тулд зургаан сард нэгээс доошгүй удаа эмчлүүлэгчийг сэтгэцийн эмгэг судлалын эмч нарын магадлан тогтоох комиссын үзлэгт оруулж, хэрэв үндэслэл байна гэж үзвэл магадлан тогтоох комиссоос дүгнэлт гарган, албадан эмчилгээ хийж байгаа байгууллагын захиргааны саналаар шүүх хэрэгжүүлдэг. Харин үндэслэл тогтоогдоогүй гэж үзвэл албадан эмчилгээ хийж байгаа байгууллагын захиргаа шүүхэд албадан эмчилгээг сунгах тухай дүгнэлт гаргадаг.¹⁶

ОХУ-ын Эрүүгийн хуулийн Дөрөвдүгээр бүлэгт эрүүгийн хариуцлага хүлээх этгээдийн талаар хуульчилсан байдаг. Ингэхдээ 23 дугаар зүйлд согтуурсан болон мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар заажээ.

ОХУ-ын эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зохицуулсан эрх зүйн орчин нь Монгол улсын эрх зүйн орчинтой харьцуулж үзэхэд маш тодорхой, хоёрдмол утгагүй байхаас гадна эргэлзээтэй байдал үүсгэхгүй байна. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх субъектийн шалгуурыг хуулиар дэлгэрэнгүй тогтоосон бөгөөд гагцхүү хэрэг хариуцах чадварт тулгуурлахгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн асуудалтай, сэтгэцийн эмч, эмнэлгийн байгууллагын хэрэгцээ шаардлага бодитоор үүссэн тохиолдлууд болон бэлгийн чиг хандлагын өвчтэй этгээдийг тухайлан хуульчилж өгснөөрөө давуу байна. Түүнчлэн эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх дэглэм, тэдгээрт хамаарах эмчлүүлэгчдэд тавигдах шаардлагыг хуульчилж өгснөөр эргэлзээ үүсэхгүй, хуулийг нэг мөр хэрэгжүүлэх боломж илүүтэй олдож байгаагаараа Монгол Улсаас ялгаатай байна.

¹⁵ Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир нар, “Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль”, 132 -133 дахь тал, УБ, 2021 он.

¹⁶ Ж.Эрдэнэбулган, М.Уянга, Б.Тамир нар, “Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль”, 133 дахь тал, УБ, 2021 он.

Швед Улсын туршлага, харьцуулсан судалгаа

Швед Улс нь Скандиновын орон бөгөөд эрх зүйн тогтолцооны хувьд хосолсон буюу холимог тогтолцоонд хамаардаг боловч сонгодог Ромын эрх зүйд үндэслэн, Герман загвараар хөгжсөн онцлогтой тул харьцуулсан судалгаа хийхээр сонгон авсан болно.

Швед Улсын Эрүүгийн хууль нь 1962 онд батлагдан, 1965 оноос хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бөгөөд өдгөө 3 хэсэг, 38 бүлгээс бүрддэг.

Энэхүү хуулийн 26 дугаар бүлгийн 16 дугаар зүйлд “Гэмт хэрэг үйлдэн хоригдож буй этгээдийн дахин гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах, нийгэмд дасан зохицоход нь туслах зорилгоор Шведийн хорих байгууллага болон хянан шалгах алба нь заавал дагаж мөрдөх тусгай арга хэмжээг нэг удаад, дээд тал нь нэг жилийн хугацаагаар авч болно. Үүнд: Мансуурах донгийн эсрэг эмчилгээ, сэтгэцийн эмчилгээ, бусад эмчилгээ”¹⁷ багтана.

Мөн хуулийн 31 дүгээр зүйлд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх үндэслэлийг дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

31 дүгээр бүлгийн 2 дугаар зүйл

Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэг үйлдсэн этгээдийг Шүүх сэтгэцийн тусламж үйлчилгээний тухай хуулийн дагуу шүүхээс нийгмийн халамжийн хэлтэст хариуцуулж болох бөгөөд хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд гэртээ байхаар сонгосон бол гэрт нь хяналт тавьж, хэрэгцээт зүйлсээр хангана. Шүүх хэргийг хянан шийдвэрлэхэд нийгмийн халамжийн хэлтэс эсхүл гэрийн хяналтыг хэрэгжүүлж буй этгээд заавал оролцоно.

Швед Улсын Эрүүгийн хуулийн 31 дүгээр бүлгийн 2 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээд “гэртээ байх” сонголт хийх боломжийг бий болгож, хэрэв сонгосон тохиолдолд хяналт тавьж, эмчлүүлэгчийг болон гэр бүлийн гишүүдийг хамгаалалт, хэрэгцээт зүйлсээр хангахаар зохицуулсан нь онцлог зохицуулалт юм.

31 дүгээр бүлгийн 3 дугаар зүйл

Хэрэв гэмт хэрэг үйлдсэн этгээд сэтгэцийн хүнд өвчтэй бол шүүхээс тухайн хүний сэтгэцийн байдал, хувийн байдал, гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал зэргийг харгалзан сэтгэцийн тусламж, үйлчилгээнд хамруулж болно. Ингэхдээ цагдан хорих болон бусад албадлагын арга хэмжээг хавсран хэрэгжүүлж болно. Сэтгэцийн өвчний улмаас гэмт хэрэг үйлдсэн бөгөөд шүүхийн сэтгэцийн эмчилгээний тухай хуулийн дагуу эрх бүхий байгууллагад хэрэг хариуцах чадвартай эсэхийг тодорхойлуулахаар онцгой хүсэлт гаргаж болно.¹⁸

Швед Улс нь “Шүүх сэтгэцийн тусламж үйлчилгээний тухай”¹⁹ хуулийг 1991 оны 06 дугаар сарын 20-ны өдөр баталсан бөгөөд тухайн хууль нь 30 зүйлээс бүрдэнэ. Тус хуулийн 3 дугаар зүйлд зааснаар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь хаалттай болон нээлттэй гэх төрлүүдтэй. Хаалттай эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэх бол нээлттэй эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь бусад арга хэмжээг хамааруулж авч үздэг. Тус хуулиар эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах байгууллагад тавигдах шаардлага, хяналт шалгалт, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах үндэслэл, сунгах үйл ажиллагааны үе шат, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг

¹⁷ Швед Улсын Засгийн газрын албан ёсны цахим хаяг, Швед улсын эрүүгийн хууль, <https://www.government.se/4b0103/contentassets/7a2dcae0787e465e9a2431554b5eab03/the-swedish-criminal-code.pdf>

¹⁸ Швед Улсын Засгийн газрын албан ёсны цахим хаяг, Швед улсын эрүүгийн хууль, <https://www.government.se/4b0103/contentassets/7a2dcae0787e465e9a2431554b5eab03/the-swedish-criminal-code.pdf>

¹⁹ Швед улсын парламентийн албан ёсны цахим хаяг, Шүүх сэтгэцийн тусламж үйлчилгээний тухай хууль, https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-19911129-om-rattsspsykiatrisk-vard_sfs-1991-1129#:~:text=Chefs%C3%B6rverl%C3%A4karen%20ska%20genast%20anm%C3%A4la%20en,%C3%B6ppen%20eller%20sluten%20r%C3%A4ttsspsykiatrisk%20v%C3%A5rd.

зогсоох, түүнд тавигдах шаардлага, эмчлүүлэгчийг шинжлэх тестийн арга зэргийг нарийвчлан хуульчилсан.

Швед Улсад эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг гагцхүү ийнхүү хязгаарлах бус олон янзаар төрөлжүүлсэн. Тухайлбал, бэлгийн хүчирхийлэгчид авах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид авах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, согтуурах болон мансуурах донтой этгээдэд авах эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ гэх мэтчилэн субъектийн шинж чанараар төрөлжүүлсэн.²⁰ Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг гагцхүү шүүх оногдуулах бөгөөд тухайн арга хэмжээг хэрэглэх хугацааг урьдчилан шүүхээс тогтоодоггүйгээрээ онцлогтой.²¹

30 дугаар бүлгийн 6 дугаар зүйлд хэрэг хариуцах чадваргүй байдлын талаар дараах байдлаар тусгажээ.

30 дугаар бүлгийн 6 дугаар зүйл

Сэтгэцийн өвчин, ноцтой хямралын нөлөөгөөр гэмт хэрэг үйлдсэн этгээдэд аль болох хорихоос бусад төрлийн ял оногдуулах бөгөөд заавал хорих ял оногдуулахаар бол шүүхээс дараах зүйлсийг харгалзан үзнэ. Үүнд:

3. Гэмт хэрэг үйлдэхийн тулд согтуурсан эсхүл мансуурсан эсэх,

Сэтгэцийн өвчин, ноцтой хямралын нөлөөгөөр үйлдлийнхээ үр дагаврыг ухамсарлах, удирдан жолоодох боломжгүй байсан буюу хэрэг хариуцах чадваргүй байсан бол шүүхээс ял оногдуулж болохгүй. Харин 3-т заасан нөхцөл буюу тухайн нөхцөл байдлыг зориудаар бий болгосон бол дээрх заалт хамаарахгүй.

Дээрх зохицуулалт нь хэрэг хариуцах чадвартай холбоотой бөгөөд шүүхээс хэрэг хариуцах чадварыг үнэлэхдээ юуг шалгуур болгох талаар дэлгэрэнгүй тусгасан. Монгол Улсын Эрүүгийн хуулийн 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй” гэж заасан бөгөөд бүх тохиолдолд хэрэг хариуцах чадвартай гэж үздэг. Харин Швед Улсын Эрүүгийн хуулийн онцлог нь “Actio libera in causa” буюу согтуурсан, мансуурсан үедээ үйлдсэн гэмт хэргийн үеэрх хэрэг хариуцах чадварын тухай дэлгэрэнгүй тусгасан явдал юм. Энэхүү зарчмыг Швед Улсын Эрүүгийн хуулийн 30 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт тусгасан ба ингэхдээ гэмт хэрэг үйлдэхийн тулд согтуурсан эсхүл мансуурсан бол хэрэг хариуцах чадвартайд тооцохоор зохицуулжээ.

Хоёр.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ, тулгамдаж буй асуудал, боловсронгуй болгох арга зам

2.1.Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал

Одоогоор Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дараах хууль тогтоомжоор эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зохицуулж байна. Үүнд: Эрүүгийн хууль, 2015 он, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, 2013 он зэрэг болно. Түүнчлэн, дээрх хууль тогтоомжоос гадна дараах журмууд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Үүнд: Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А/369 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”, Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/59 тоот тушаалаар баталсан “Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх журам”, Хууль зүй, дотоод хэргийн

²⁰ Council of Europe, “The Use of Quasi Compulsory Measures as alternatives to Imprisonment in Europe”, page 3, Strasbourg, 2014.

²¹ Council of Europe, “The Use of Quasi Compulsory Measures as alternatives to Imprisonment in Europe”, page 6, Strasbourg, 2014.

сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/155 тоот тушаалаар баталсан “Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтын журам” зэрэг болно.

Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын хамтарсан 2006 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 107, А/58 тушаалаар батлагдсан “Албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газрын нөхцөл, дэглэмийн журам” хэрэгжиж байсан боловч Монгол Улсын ерөнхий прокурор, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын хамтарсан 2021 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/149, А/137 дугаартай тушаалаар тус журмыг хүчингүй болсонд тооцсон. Ингэснээр ямар нэгэн дэглэм тогтоосон хэм хэмжээ байхгүй болсон.

2015 оны Эрүүгийн хуулийн 6.3 дугаар зүйлд “Хэрэг хариуцах чадвар”, 6.4 дүгээр зүйлд “Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулах”, 7.4 дүгээр зүйлд “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ”-г тус тус хуульчилсан.

2015 оны Эрүүгийн хууль нь урьд өмнө батлагдан, мөрдөгдөж байсан эрүүгийн эрх зүйн эх сурвалжуудтай харьцуулан авч үзэхэд:

- “Өөртөө, бусдад аюул учруулж болзошгүй нөхцөлд” гэж шинээр нэмсэн нь Эрүүгийн хуулийн энэрэнгүй ёсны зарчмыг илэрхийлж, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний зорилгыг тодорхой болгосон;
- Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан хүн эмчлэгдсэн, хэрэг хариуцах чадваргүй байдал нь арилсан тохиолдол тус бүрд хэрхэн хэрэглэгдэх талаар тусгасан;
- Гэмт хэрэг үйлдсэн хүн согтуурах, мансуурах донтой болох нь тогтоогдсон тохиолдолд донтох зуршлын эсрэг эмчилгээнээс гадна сэтгэл заслын эмчилгээ хийлгэх тухай дурдсан;
- Хэрэг хариуцах чадвартай байхдаа ял шийтгүүлсэн ялтны сэтгэцийн эмгэгийг эмчлэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болохоор хуульчилсан байна.

Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй²² хэмээн хуульчилсан ба “actio libera in causa”-ийн талаарх ойлголтыг хуульчлаагүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (цаашид ЭХХШтХ гэх) Арван есдүгээр бүлэгт эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх журмыг тогтоосон. Прокурор, яллагдагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь яллагдагчийн сэтгэцийн эрүүл мэндэд эргэлзэх үндэслэл байвал хэрэг хариуцах чадвартай эсэхийг тогтоолгохоор шинжээч томилох хүсэлтийг шүүхэд гаргаж²³, шүүх хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл шинжээч томилж²⁴, сэтгэцийн эмгэг судлалын шинжилгээ хийлгэдэг. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд прокурор хяналт тавьж ажилладаг.²⁵

2.2 Эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудал

Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм, хугацааг шинжээчийн дүгнэлтийг харгалзан шүүх тогтооно”, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 190 дүгээр зүйлийн 190.1-т “Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол шүүх албадлагын арга хэмжээг ямар төрлийн эмнэлэгт хэрэгжүүлэхийг тогтоолдоо заана” хэмээн тус тус хуульчилсан. Түүнчлэн, Ж.Авхиа нарын хамтран бэлтгэсэн БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбарт “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрлийг өөрчилнө гэдэг нь сэтгэц мэдрэлийн нэг больницоос нөгөөд (эмнэлгийн нэг дэглэмээс нөгөөд) шилжүүлэхийг хэлнэ”²⁶ хэмээн тайлбарлажээ. Академич С.Нарангэрэл нь өөрийн бүтээлдээ

²² Эрүүгийн хууль, §6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, УБ, 2015 он.

²³ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, §19.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, УБ, 2017 он.

²⁴ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, §19.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, УБ, 2017 он.

²⁵ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, §19.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, УБ, 2017 он.

²⁶ Дурдсан бүтээл, 81 дэх тал, УБ, 1989 он.

“Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл нь а/ сэтгэл мэдрэлийн ердийн эмнэлэгт эмчлүүлэх, б/ сэтгэл мэдрэлийн тусгай эмнэлэгт эмчлүүлэх, в/ эмчийн хяналтад байлгах, г/ төрөл саданд нь шилжүүлэх, д/ асран хамгаалагч, харгалзан дэмжигчид шилжүүлэх зэрэг болно”²⁷ хэмээн тодорхойлсон байна. Иймд Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн түүхэн уламжлалаас авч үзвэл эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэм хэмээх ойлголтыг нэгтгэн авч үзэж байжээ.

2015 оны Эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг тухайлан хуульчлаагүй. Мөн өмнө дурдсанчлан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний талаар ямар нэгэн төрөл, дэглэм тогтоосон хэм хэмжээ байхгүй болсон.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник нь 1971 оноос хойш Монгол Улсын Эрүүгийн хууль болон бусад холбогдох хууль, журамд заасны дагуу эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлж ирсэн.²⁸ Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн харьяа “Шүүхийн сэтгэцийн эмгэг судлалын клиник”-ийн үйл ажиллагаатай танилцахад 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар 42 эмчлүүлэгчтэй, нэг дэглэмтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байв.

Тухайн хууль үйлчилж эхэлсэн цаг хугацаа буюу 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэлх 49 шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийхэд гарсан үр дүнг хүснэгтээр харуулав. Үүнд:

	Дэглэм					Төрөл		
	Тусгай /хуулийн/	Ердийн	Хуулийн тасгийн энгийн зэрэглэл	Донтох эмгэгийн клиник	Заагаагүй	Сэтгэл заслын	Донтох зуршлын эсрэг	Заагаагүй
Тоон үзүүлэлт	17	17	6	1	8	9	4	36

Хүснэгт 2. Шүүхийн шийтгэх тогтоолд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг дурдсан байдал

Үүнд дүгнэлт хийж үзвэл, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний төрөл, дэглэмийг шүүхээс тогтоохоор хуульчилсан боловч, төрөл, дэглэмийг тухайлан хуульчлах эсхүл журамлах зэргээр тогтоогоогүйгээс шүүхийн шийдвэр бүрд янз бүрээр нэрлэгдэн хэрэглэгдэж, хууль нэг мөр хэрэгжих боломж үгүйсгэгдэж, хууль ёсны зарчим, тэр дундаа эрүүгийн хууль тодорхой байх зарчим алдагдах нөхцөл үүссэн байна.

Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг донтох зуршлын эсрэг болон сэтгэл заслын хэмээн төрөлжүүлэн хэрэглэж буй нь дэвшилттэй боловч төрлийг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байна гэж судлаач дүгнэлээ.

Түүнчлэн Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасны дагуу шүүхээс эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний хугацааг тогтоохоор хуульчилжээ. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ нь сэтгэц мэдрэлийн өвчнийг эмчлэн эдгэрүүлэхэд чиглэгддэг.²⁹ Сэтгэц мэдрэлийн өвчин эдгэрнэ гэдэгт сэтгэцийн байдал тогтвортой сайжирч, өөрийн үйл ажиллагааг жолоодох, үйлдлийг ухамсарлан хариуцах чадвартай болохыг ойлгох нь зүйтэй.³⁰ Гэтэл сэтгэцийн эмгэг

²⁷ С.Нарангэрэл, “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги”, 364 дэх тал, УБ, 1999 он.

²⁸ С.Байгальмаа нар, “Гэмт явдалтай тэмцэх асуудал - 79”, “Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдсан зарим асуудал”, 27 дахь тал, УБ, 2021 он.

²⁹ Ж.Авхиа, Н.Туяа нар, “БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, 80 дахь тал, УБ, 1989 он.

³⁰ Ж.Авхиа, Н.Туяа нар, “БНМАУ-ын Эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, 81 дэх тал, УБ, 1989 он.

хэзээ засарч сайжрахыг шинжээчийн дүгнэлтээр урьдчилан тогтоох боломжгүй³¹ байдаг. Ийнхүү урьдчилан хугацаа тогтоож буй нь эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний гол зорилго буюу эмчлүүлэгчийг эдгээж, эмчлүүлэгч этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах, нийгэмд ашигтай ажиллагаанд дасгах, өөртөө аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгыг хангахгүй байна.

Согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн нь эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй³² хэмээн хуульчилсан. Амьдралд гарч байгаа хэргийн нөхцөл байдал, субъектийн хувийн шинж байдал болгон харилцан адилгүй байхад тэдгээрийг автоматаар нэг ижил хэмээн үзэж, согтуурсан болон мансуурсан хэрэг болгонд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь зарим нэг тохиолдолд субъектийн гэм буруугийн байдалд таарахгүйг анхаарах хэрэгтэй.³³

Санал

1. Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт тусгасан “төрөл” ба “дэглэм”-ийн ялгааг тодорхой болгон хуульчлан эргэлзээтэй байдлыг арилгах, хууль нэг мөр хэрэгжих боломжийг бүрдүүлэх,
2. Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан “төрөл”-ийг нарийвчлан, субъектийн болон бусад шинжээр төрөлжүүлэн журамлаж, тэдгээрт тохирох эмчилгээний хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх. Тухайлбал, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг ХБНГУ болон Швед Улсын туршлагын нэгэн адил бага насны хүүхдийн бэлгийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн этгээдэд, бэлгийн хүчирхийлэгчид, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгчид гэх мэтээр төрөлжүүлэх,
3. Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт заасан “дэглэм”-ийг дэлгэрүүлэн хуульчилж, тухайн дэглэмд хамаарах өвчтөнд тавигдах шаардлага, дэглэмийн орчин, нөхцөл бүрийг ОХУ-ын хууль тогтоомжид тусгасны нэгэн адил тодорхой байдлаар тухайлан журмаар зохицуулах,
4. Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэх хугацааг шүүхээс урьдчилан тогтоох жишгийг халж, ОХУ, Швед улсуудын нэгэн адил тодорхой хугацаанд эмчлүүлэгчийн сэтгэцийн байдлыг тодорхойлж, дүгнэлт гарган, тухайн арга хэмжээг хэрхэх шийдвэрийг шүүх гаргадаг жишгийг нэвтрүүлэх, Эрүүгийн хуулийн 7.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт тусгасан “хугацаа” гэх үгийг хасах, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг сунгах, өөрчлөх, зогсоох журмыг тухайлан батлах,
5. Actio libera in causa буюу согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн тохиолдол бүрийн хэрэг хариуцах чадварыг харьцангуй ялгамжтай авч үзэх тухай тусгуулах. Тухайлбал гэмт хэрэг үйлдэхийн тулд согтуурсан эсхүл мансуурсан бол хэрэг хариуцах чадвартайд тооцох, гэмт үйлдэл хийх шийдвэр нь оюун ухаанаа алдсан буюу өөрийн ухамсарт шинж байдлаа алдсан үед хэрэг хариуцах чадваргүйд тооцох зэргээр Эрүүгийн хуулийн 6.4 дүгээр зүйлд тусгуулах зэрэг болно.

Ашигласан материал

Монгол Улсын хууль, дүрэм, журам

- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хууль, 2013 он
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017 он
- Эрүүгийн хууль, 2015 он
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, 2017 он

³¹ Н.Одонтуул нар, “Гэмт явдалтай тэмцэх асуудал – 79”, “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн судалгаа”, 16 дахь тал, УБ, 2021 он.

³² Эрүүгийн хууль, §6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, УБ, 2015 он.

³³ Т.Золбоо, Эрүүгийн эрх зүй, ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц, 136 дахь тал, УБ, 2018 он.

- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн А-240/А/369 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, түүнд хяналт тавих журам”
- Эрүүл мэндийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн А/59 тоот тушаалаар баталсан “Согтуурах, мансуурах донтой этгээдийг албадан эмчлэх журам”,
- Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2019 оны 08 сарын 01-ний өдрийн А/155 тоот тушаалаар баталсан “Албадан эмчлэх эмнэлгийн харуул хамгаалалтын журам”

Хэвлэмэл эх сурвалж

- Авхиа Ж. нар БНМАУ-ын эрүүгийн хуулийн дэлгэрэнгүй тайлбар”, УБ, 1989 он
- Баатаржав О. нар, “Гэмт явдалтай тэмцэх асуудал – 79”, “Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний өнөөгийн байдал, тулгамдсан асуудлууд”, УБ, 2021 он
- Байгальмаа С. нар, “Гэмт явдалтай тэмцэх асуудал - 79”, “Сэтгэцийн эрүүл мэндийн байгууллагаас эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд тулгамдсан зарим асуудал”, УБ, 2021 он
- Баярсайхан Д., “Гадаад орнуудын эрүүгийн процессын эрх зүй”, УБ, 2015 он
- Баярсайхан Д., “Эрх зүйн онол”, УБ, 2010 он
- Баярсайхан Д., “Харьцуулсан эрүүгийн эрх зүй”, УБ, 2012 он
- БНМАУ-ын Эрүүгийн хууль, УБ, 1949 он
- БНМАУ-ын Эрүүгийн хуулийн тайлбар, УБ, 1982 он
- Бямбасүрэн С., “Сэтгэцийн эмгэг судлал”, УБ, 2007 он
- Гантөмөр Г., “Гэмт хэргийн бүрэлдэхүүний ерөнхий онол”, УБ, 2011 он
- Золбоо Т. нар, “Монгол, Орос, Хятад, Герман улсын эрүүгийн хууль”, УБ, 2021 он
- Золбоо Т., Эрүүгийн эрх зүй, ерөнхий анги: Гэмт хэргийн бүтээц, УБ, 2018 он
- Нарангэрэл С., “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги”, УБ, 1999 он
- Нарангэрэл. С., Эрдэнэбулган Ж., “Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, сургамж”, УБ, 2019 он
- Одонтуул Н. нар, “Гэмт явдалтай тэмцэх асуудал. №79”, “Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээний эрх зүйн зохицуулалт, хэрэгжилтэд хийсэн судалгаа” , УБ, 2021 он
- Үндэсний статистикийн хороо, “Согтууруулах ундааны хэрэглээ, үйлдвэрлэлийн өнөөгийн байдал”, УБ, 2019 он
- Ханнс Зайделийн сан, Бямбаа Ж. нар, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, УБ, 2013 он

Цахим эх сурвалж

- Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын албан ёсны цахим хаяг, <https://www.who.int>
- WHO, “Global status report on alcohol and health”, Switzerland, 2018, <https://www.who.int/publications/i/item/9789241565639>
- Council of Europe, “The Use of Quasi Compulsory Measures as alternatives to Imprisonment in Europe”, Strasbourg, 2014, <https://rm.coe.int/16806fb1ea>
- Швед Улсын Засгийн газрын албан ёсны цахим хаяг, Швед улсын эрүүгийн хууль, <https://www.government.se/4b0103/contentassets/7a2dcae0787e465e9a2431554b5eab03/the-swedish-criminal-code.pdf>
- Швед улсын парламентын албан ёсны цахим хаяг, Шүүх сэтгэцийн тусламж үйлчилгээний тухай хууль, <https://www.riksdagen.se/sv/dokument-lagar/dokument/svensk-forfattningssamling/lag-19911129-om-rattsspsykiatrisk-varld-sfs-1991-1129#:~:text=Chefs%C3%B6ver%C3%A4karen%20ska%20genast%20anm%C3%A4la%20en,%C3%B6ppen%20eller%20sluten%20r%C3%A4ttsspsykiatrisk%20v%C3%A5rd.>

ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХҮЛЭЭЛГЭХ ЭРҮҮГИЙН ХАРИУЦЛАГА, ЗАРИМ УЛСЫН ЖИШИГ

CRIMINAL RESPONSIBILITY FOR JUVENILE PERSONS AND PRACTICES IN SOME COUNTRIES

Б.Досжан

*Отгонтэнгэр их сургуулийн Хууль зүйн сургуулийн багш,
БНТУ-ын Косаели их сургуулийн докторант*

Товч агуулга: Монгол Улсын Эрүүгийн хуульд өсвөр насны хүн, түүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг хуульчилсан байдал, олон улсын гэрээ, хэлэлцээрүүд болон гадаадын зарим улсын эрүүгийн хууль тогтоомжид дээрх ойлголтыг тодорхойлсон байдлыг харьцуулан судаллаа. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын асуудал нь эрүүгийн болон эрүүгийн процессын эрх зүйн шинжлэх ухааны ухагдахуун боловч гол төлөв эрүүгийн эрх зүйн талаас асуудлыг шинжлэн судлах юм.

Abstract: This report consists of three main parts, and it will study the criminal liability of a teenager in the criminal law of Mongolia, and compare the definition of the concept in international agreements and the criminal laws of some countries. The concept of criminal responsibility for a teenager is a scientific concept of criminal law and criminal proceedings, but it is mainly analyzed from the point of view of criminal law.

Түлхүүр үгс: Өсвөр насны хүн, Эрүүгийн хууль, олон улсын гэрээ.

Keywords: Adolescent, criminal law, international agreement.

Удиртгал

Улс орны ирээдүй болсон өсвөр насны хүний нийгмийн харилцаанд оролцох явц хууль зүйн хүрээнд явагдах нь тухайн улс орны хөгжил, ирээдүйд шууд нөлөөлнө. Хууль тогтоогч, судлаачдын зүгээс гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзахаас гадна нийгмийн ирээдүйн нөхцөл байдлыг төсөөлөх нь зүйтэй.

Өсвөр насны хүнд хүлээлгэх ял, албадлагын арга хэмжээ нь цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирол нөхөн төлүүлэх зэргээс илүүтэйгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тухайн хүнийг нийгэмшүүлэх зорилготой байх ёстой.

Өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг шалган тухайн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх явдал нь тухайн этгээд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн бодит мөн чанар болон нийгэмд учруулах аюулыг ухамсарлах, эсхүл үйл ажиллагаагаа удирдан жолоодох боломжтой байсан эсэхийг тогтоох өвөрмөц нөхцөл байдал бий болгодог учир энэхүү ойлголтыг олон улсын жишигтэй харьцуулан авч үзэхээр боллоо.

Монгол хэлний их тайлбар тольд “Өсвөр нас” гэдгийг ид өсөн торниж буй хүүхэд үеийг³⁴ хэлнэ гэж тайлбарласан байдаг бол Монгол Улсын Эрүүгийн хуульд өсвөр насны хүний насыг нарийвчлан заасан байдаг.

Үндсэн хэсэг

Хүн төрөлхтөний түүхэн дэх эрх зүйн хөгжил түүгээр дамжиж ирсэн хуулийн тогтолцоо бүр “тодорхой гэмт этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд зарим шалгуур, шаардлага буюу нас болоод биеийн хөгжил тэгширсэн” байх гэсэн үзэл давамгайлж ирсэн.

Ромын эрх зүйд “12 хүснэгтийн хууль” хэрэгжиж эхэлснээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөл байдал нь тухайн этгээд бие болоод сэтгэцийн хувьд тодорхой хэмжээнд өсөж бойжсон байхыг шаарддаг.

³⁴ Монгол хэлний их тайлбар толь, <https://mongoltoli.mn/dictionary/detail/73318>.

Шашны эрх зүйд 7 насанд хүрээгүй этгээд санаатай үйлдэл хийх боломжгүй сэтгэцийн хувьд эрүүл бус хүний адил хүлээн зөвшөөрөгддөг байсан бөгөөд шүүгчид хэрэг маргааныг хянан хэлэлцэхдээ 7 насанд хүрсэн хэдий ч тухайн үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн хор аюулын шинж чанарыг ухамсарлаж байгаа эсэхийг нарийвчлан тогтоох үүрэгтэй байсан³⁵.

Германы эрх зүйн хөгжлийн эхэн үед гэмт этгээдийн насны байдалд төдийлөн анхаарал хандуулдаггүй байсан боловч хожим нь гэмт этгээд 12 насанд хүрсэн байхаар хуульчилсан. Улмаар 12 насанд хүрээгүй этгээд хүнийг санаатайгаар алсан тохиолдолд ч эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй бөгөөд зөвхөн тухайн этгээдийн ар гэрийнхнийг хохирогчийн ар гэрийнхэнд нөхөн төлбөр төлөх байдлаар уг асуудлыг шийдвэрлэж байв.³⁶

Исламын эрх зүйд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насыг хүйсээр ялгамжтай ангилж байсан бөгөөд эмэгтэй 9 нас, эрэгтэй 12 нас гэж тодорхойлсон. Энэхүү эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны талаарх ойлголтод Исламын хуульчид санал зөрөлдөх явдал их байсан учир уг нас, хүйс үл харгалзан 15 нас болсон.³⁷

Орчин цагийн хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг тодорхойлон зааж уг насанд хүрээгүй этгээдийг хэрэг хариуцах чадваргүй гэж үзсэн³⁸ бөгөөд цаашид эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг тогтоохдоо өсвөр насны хүн өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн шинж чанарыг ухамсарлах хэмжээний сэтгэл зүй, сэтгэхүйн болон бие махбодын хөгжилд хангалттай хүрсэн эсэхийг нарийвчлан тогтоох шаардлагатай³⁹ хэмээн томъёолсон.

Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг Монгол Улсын Эрүүгийн хуульд томъёолсон байдлыг үндсэн 3 хэсэгт ангилж болно. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой төрлийн гэмт хэргүүд буюу 10.1/Хүнийг алах/, 11.1/Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1/Хүчиндэх/, 17.1/Хулгайлах/, 17.2/Дээрэмдэх/, 17.8/Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 20.7/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.16/Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 26.1/Цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2/Цахим мэдээллийн сүлжээнд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3/Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8/Террор үйлдэх/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол 14 насанд хүрсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

14 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй дээр дурдсан гэмт хэргүүдийг үйлдсэн өсвөр насны хүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангид заасан үндэслэл, журмыг баримтлан хариуцлага хүлээлгэх бөгөөд хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан тусгай үндэслэл, журмыг баримтална. 14 насанд хүрээгүй хүн өөрийн үйлдлийн хор уршиг, үр дагаврыг хангалттай гадарлаж, өөрийгөө удирдан жолоодох боломжтой болсон байдаг ч хуульд 14 насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй гэж үзсэн.

2. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг хийсэн хүн 16 насанд хүрсэн байх ёстой бөгөөд уг хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх бүрэн боломжтой гэж Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгасан. Учир нь Эрүүгийн хуулиар тогтоосон

³⁵ Şahin Akıncı. Roma Hukuku Dersleri, Sayram yayınları. 2019 он. 150 дахь тал.

³⁶ Naci Şensoy. Çocuk suçluluğu – küçüklük – çocuk mahkemeleri ve infaz müesseseleri. 1990 он. 579 дэх тал.

³⁷ Mücahit Çolak. İslam hukukunda ceza ehliyeti açısından yaş küçüklüğü, Atatürk üniversitesi ilahiyet fakültesi dergisi, sayı: 35, Erzurum 2011 он. 118 дахь тал.

³⁸ НҮБ- Хүүхдийн эрхийн тухай конвенц 40.3-р зүйл. www.legalinfo.mn/law/details/1276.

³⁹ The Beijing Rules 4 дүгээр зүйл. Бээжингийн дүрэмд тодорхой насыг нарийвчлан заахаас зайлсхийсэн нь улс орон бүр ёс заншил хөгжлийн түвшин түүх соёлын хувьд ялгаатайг илтгэж байгаагийн илрэл юм.

насанд хүрсэн байх нь эрүүгийн хариуцлага хүлээх этгээдэд заавал байх хууль зүйн шинж юм⁴⁰.

Хууль тогтоогчийн зүгээс эрүүгийн хуулиар хариуцлага хүлээлгэх насны хязгаар тогтоохдоо тухайн гэмт хэргийн нийгмийн хор аюулын хэр хэмжээг бус харин тэрхүү этгээд үйлдсэн гэмт хэргийнхээ нийгмийн аюулын шинж чанар, учир холбогдол, мөн чанарыг хэрхэн ухамсарлан ойлгох чадвартай эсэх сэтгэхүйн шинжийг нь шалгуур болгон авч үздэг.

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 16.7 дугаар зүйлд заасан хүүхэдтэй хэрцгий харьцах гэмт хэргийн үндсэн шинжид заасан гэмт хэргийг үйлдэх боломжтой этгээд нь заавал 18 насанд хүрсэн байхыг шаардана. Хууль тогтоогчийн зүгээс 16 нас зарим тохиолдолд 14 насанд хүрсэн тодорхой төрлийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Гэвч дээрх гэмт хэргийг үйлдэх этгээд заавал 18 насанд хүрсэн байх ёстой гэж тухайн зүйлийн диспозицид заасан явдал нь эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны талаарх нийт 3 төрлийн ойлголт байх боломжтой гэх үндэслэлийг нотолж байна.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд тухайн этгээд үйлдэл, эс үйлдэхүйн хор аюулын шинж чанарыг ухамсарлах чадвартай байхыг шаарддаг боловч өсвөр насны хүний тухайд дээрх шинж чанарыг бүрэн ухамсарлах, удирдан жолоодох чадвар нь насанд хүрсэн хүнтэй харьцуулахад сул гэж үзэн хариуцлага хүлээлгэхдээ тухайн хүнийг нийгмээс бүхэлд нь тусгаарлах байдлаас зайлсхийж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор оногдуулах ялыг тодорхой хэмжээгээр түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун болон сэтгэцийн хөгжилд харшлахгүй байдлаар багасгаж оногдуулдаг.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенцид 18 насанд хүрээгүй өсвөр насны хүн буюу хүүхдийн эрхийг улс төрийн бодлого, үйл ажиллагаа зэргээс ямагт нэгт тавих тэдний эрх чөлөөг хязгаарлах явдал нь хэрэглэж болох хамгийн сүүлийн арга хэмжээ хэмээн үзэж, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг нийгэмшүүлэх арга хэмжээг зохион байгуулах нь шүүх хууль тогтоох тогтолцооны бүхий л шатанд баримталбал зохих ач холбогдолтой зарчим гэж үздэг.⁴¹

Иймд Монгол Улсын Эрүүгийн хууль дээрх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд: Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд /гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн, 18 насанд хүрээгүй байсан хүн/ нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих зэрэг ял, бусад албадлагын арга хэмжээг хэрэглэнэ. Өсвөр насны хүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн хөгжилд нь харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ба энэхүү ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт зуун хориос гурван зуун жаран цаг байхаар, эрүүгийн хуульд хорих ял оногдуулахаар заасан.

Эрүүгийн хуулийн 5.6 дугаар зүйлд заасан журмаар хорих ялыг хоёр дахин багасгаж, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ.

Олон улсын гэрээ хэлэлцээрт зааснаар өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь

Хүүхдийг хамгаалах тухай олон улсын эрх зүйн зохицуулалт дэлхийн I дайны дараа бий болсон гэж үздэг.

League of Nations (Үндэстнүүдийн Лиг) буюу одоогийн НҮБ-ын үндэс суурь нь 1924 онд анх “Хүүхдийн эрхийн тухай” тунхаглалыг Женев хотод баталсан энэ цаг үеэс хүүхдийн эрх, түүнийг хамгаалах тухай ойлголт бий болж, тусгайлан авч үзэх болсон. Үүний дараагаар буюу 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр НҮБ-ын Ерөнхий Ассамблей “Хүүхдийн эрхийн тунхаглал”-ыг баталсан.

⁴⁰ Б.Ганболд, Монгол улсын эрүүгийн эрх зүйн тойм, Улаанбаатар, 2003 он, 39-р тал.

⁴¹ Sevük Handan Yokuş, Uluslararası Sözleşmelerdeki İlkeleri Açısından Çocuk Sorumluluğu ile Mücadelede Kurumsal Yaklaşım, İstanbul 1998, ХЭК-н 31-р зүйлийг тайлбарлах нь, 185-р тал.

Энэхүү тунхаглал хууль эрх зүйн тодорхой хариуцлагын хэм хэмжээ бус гол төлөв ерөнхий үзэл баримтлал зарчим зэргийг өөрт агуулсан байдаг⁴².

Олон улсын эрх зүйд хүүхдийн эрхийг хамгаалах ерөнхий зохицуулалт нь НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцыг 1989 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр баталж⁴³, 1990 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр уг гэрээг үзэглэж эхэлсэн бөгөөд нийт 20 улс хүлээн зөвшөөрснөөр 1990 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Монгол Улсын хувьд Хүүхдийн эрхийн конвенцид 1990 онд 5 дахь орон болон нэгдэн орж, тус конвенцыг үндэслэн “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийн төслийг боловсруулж, УИХ-аас 1996 оны 5 дугаар сарын 8-ны өдөр батлан гаргаж 6 дугаар сарын 1-ний өдөр мөрдөж эхэлсэн бөгөөд энэ хууль нь 2016 оны 2 дугаар сарын 5-ны өдөр “Хүүхдийн эрхийн тухай” хууль батлагдсанаар хүчин төгөлдөр бус болсон.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1985 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр “Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрэм/”⁴⁴, 1990 оны 12 дугаар сарын 14-ний өдөр “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар НҮБ-ын үндсэн зарчим буюу Эр-Риядын зарчим”⁴⁵ мөн онд “Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүйчүүдийг хамгаалах талаарх НҮБ-ын дүрмүүдийг /Хаванагийн дүрэм/”⁴⁶ баталсан.

Дээрх олон улсын эрх зүйн хэм хэмжээнүүдийн агуулгыг дэлгэрүүлэн авч үзвэл:

1. Хүүхдийн эрхийн тухай тунхаглал

Уг тунхаглалд насанд хүрээгүй хүнтэй холбоотойгоор тодорхой хууль, журам баталж эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг нарийвчлан тогтоож тогтоосон насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх. Гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг тогтоон дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх. Насанд хүрээгүй хүний хүмүүжил болон хөгжилд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ буюу албадлагын арга хэмжээг хэрэглэх. Эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдолд эрүүдэн шүүлтийн золиос болгохоос сэргийлэх, 18 насанд хүрээгүй хүнд бүх насаар нь хорих ял оноохгүй байхыг санал болгосон.⁴⁷

2. Насанд хүрээгүй хүмүүсийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын наад захын жишиг дүрэм /Бээжингийн дүрэм/

Бээжингийн дүрэмд улс орнууд үндсэн ашиг сонирхолдоо нийцүүлэн насанд хүрээгүйчүүдэд эерэг нөлөө үзүүлэхүйц амьдралын хэв маяг бий болгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор насанд хүрээгүйчүүдийн амьдралын нөхцөлийг сайжруулах. Гэмт хэрэг зөрчил үйлдсэн насанд хүрээгүй хүнд оногдуулах хариуцлага нь хууль зүйн хувьд хөнгөн хэлбэртэй байх бөгөөд тэдэнтэй хүнлэг байдлаар харилцах нөхцөлийг бүрдүүлэх. Насанд хүрээгүй хүний хөгжилд анхаарч тэдгээрийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг тодорхой тогтолцооны дагуу сайжруулах. Гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүст тэдний эрх чөлөөг бүрэн хязгаарласан буюу хорих ял оногдуулахаас зайлсхийхийг санал болгосон агуулгатай.⁴⁸

⁴² Yusuf Solmaz, Çocuk Ceza Hukuku, Ankara 2003, 45-46-p тал.

⁴³ 1959 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүчин төгөлдөр болсон Хүүхдийн эрхийн тунхаглалтай адил хугацаанд батлагдсан учир жил бүрийн 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүүхдийн эрхийг хамгаалах өдөр гэж үздэг болсон. www.un.org/en/events/childrenday

⁴⁴ www.un.org/en/events/pastevents/pdfs/Beijing_Declaration_and_Platfrom_for_Action.pdf

⁴⁵ www.ohchr.org/EN/ProfessionalInterest/Pages/PreventionOfJuvenileDelinquency.aspx

⁴⁶ www.unodc.org/pdf/criminal_justice/United_Nations_Rules_for_the_Protection_of_Juveniles_Deprived_of_their_Liberty.pdf

⁴⁷ Öztürk Bahri, Erdem M.Ruhan, Uygulamalı Ceza Muhakemesi Hukuku, Ankara 2006, 378-379-p тал.

⁴⁸ Bağcı Olca, Çocuk Yargılaması, İstanbul Barosu Yayınları, Cep kitapları 6, 8-p тал.

3. Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх талаар НҮБ-ын үндсэн зарчим буюу Эр-Риядын зарчим

Насанд хүрээгүй хүний хөгжилд анхаарч тэдгээрээс гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан нөхцөлийг тогтоон дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх тэдгээрийн эрхийг хамгаалах үйл ажиллагааг идэвхжүүлэх тал дээр зарим улсуудад улс төрийн тодорхой бодлогын өөрчлөлт оруулахыг зөвлөмжилсөн.

4. “Эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүйчүүдийг хамгаалах талаарх НҮБ-ын дүрмүүд /Хаванагийн дүрэм/

Насанд хүрээгүй хүнийг тодорхой хугацаагаар тодорхой нэг байгууллагад байршуулах нь гол төлөв хэрэглэж болох хамгийн сүүлийн арга хэмжээ байх шаардлагатай хэмээн үзэж, эрх чөлөөгөө хязгаарлуулсан насанд хүрээгүйчүүдэд бусдын хамгаалалт, дэмжлэг шаардагдаж байдгийг дурдан насанд хүрээгүйчүүдийн эрхийг бүрэн хамгаалсан тохиолдолд л хүмүүжүүлэх арга хэмжээ авах ёстой гэж үзсэн. Хэрэв насанд хүрээгүй хүнд хорих ял оноосон бол тухайн этгээдүүдийг хорих байр зарим тусгай шаардлагыг хангаж тэднийг гадаад ертөнцөөс бүрэн тусгаарлах бус сурч боловсрох, бие бялдрын хэвийн хөгжил зэрэгт анхаарах тус ял эдэлж дууссан тохиолдолд амьдралаа хэвийн авч явахад нь анхаарах зэрэг агуулгатай.

Олон улсын эрх зүйн хэм хэмжээгээр өсвөр насны хүн гэж хэн болохыг тодорхойлох, тэдэнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэлбэр зэргийн талаарх ерөнхий ойлголт зөвлөмжийг өгч байна. Монгол улсын хувьд нэгдэн орсон олон улсын хэм хэмжээг ердийн хууль тогтоомжид тусгасан боловч тухайн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явдал хангалтгүй байгаагаас насанд хүрээгүйчүүдийг хүмүүжүүлэх тэдгээрт оноосон ялыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хүрээнд зарим тохиолдолд тэдний эрх нь зөрчигдөх байдал ажиглагддаг.

Дээрх гэрээ хэлцэлд нэгдэн орсон бусад улс орнууд дотоодын хууль тогтоомж, хуульчилсан акт зэрэгтээ хэрхэн өөрчлөлт, шинэчлэл оруулсан байгааг судлах шаардлага урган гарч байна. Улс орнууд олон улсын гэрээ хэлцэлд үндэслэн дараах байдлаар өсвөр насны хүнтэй холбогдох зохицуулалтыг томъёолсон.

Гадаад улсуудын туршлага, эрх зүйн зохицуулалт

1. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХБНГУ 0-14, 14-18 болон 18-21 зэрэг насны ангиллыг Насанд хүрээгүй иргэдийн асуудал шийдвэрлэх шүүхийн тухай хуульд заасан.

ХБНГУ-ын Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн этгээд 14 насанд хүрээгүй бол тухайн этгээдийг өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хор уршиг, нийгмийн аюулын шинж чанарыг ухамсарлах чадваргүй гэж үзэн гэм буруугийд тооцож эдгээр этгээдэд эрүүгийн хариуцлага болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ хэрэглэхээс татгалздаг⁴⁹.

Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй байгаа этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ үйлдэл, эс үйлдэхүйнхээ хор уршиг, нийгмийн аюулын шинж чанарыг хэрхэн ухамсарлаж байгааг харгалзан оногдуулах хариуцлагын төрөл, хэлбэр⁵⁰ хэлбэлздэг. 18-21 насныхныг мөн тодорхой ангилал болгон тусгасан шалтгаан нь дээр дурдсан ангилал бүрийн хоорондох шилжилтийн үед ямар нэгэн гэнэтийн өөрчлөлт гарахгүй бөгөөд нас нь хэдийгээр нэмэгдэх ч тухайн этгээдийн сэтгэхүйн хөгжил байдал насанд хүрээгүй хүнийхтэй адил төстэй байх магадлалтай учир ялгамжтай хариуцлага хүлээлгэх ёстой гэж тусгасан⁵¹.

2. Итали Улс

⁴⁹ Aksay Bekir, Ceza Hukukunda Yaş Küçüklüğü, İstanbul 1990, 44-р тал.

⁵⁰ Тухайн этгээдийн гэмт хэрэгт хандаж буй сэтгэхүйн хандлагыг нарийн тогтоож эрүүгийн хариуцлага, албадлагын арга хэмжээ зэргийг ялгамжтай хэрэглэнэ.

⁵¹ germanlawarchive.iuscomp.org/?p=756

Итали Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг 14, 14-18 нас гэж заасан. Гэмт хэрэг үйлдэх үедээ 14 насанд хүрсэн боловч 18 насанд хүрээгүй байгаа этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхдээ үйлдэл, эс үйлдэхүйнхээ хор уршиг, нийгмийн аюулын шинж чанарыг хэрхэн ухамсарлаж байгааг харгалзан үзэж, үйлдэл, эс үйлдэхүйн үр дүнд бий болох нөхцөл байдлыг бүрэн дүүрэн мэдэж байгаа тохиолд л эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

Зарим тохиолдолд үйлдсэн гэмт хэргээ хүлээн зөвшөөрсөн өсвөр насны хүнийг хариуцлагаас чөлөөлөх, хариуцлага хүлээлгэхийг хойшлуулах боломжтой мөн насанд хүрээгүй хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийг шалган шийдвэрлэхдээ тусгай журам баримтална⁵².

3. Франц Улс

Франц Улсын Эрүүгийн хууль эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг 0-13, 13-16, 16-18, 18-аас дээш гэх байдлаар 4 төрлийн ангилал бий болгосон. 13 насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. 13-16 болон 16-18 насны гэмт хэрэг үйлдсэн этгээдүүдийг адил төстэй журмаар шалгах боловч 13-16 насны этгээдүүдэд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл тэдний наснаас нь шалтгаалан хөнгөрдөг бол 16-18 насны этгээдүүдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тохиолдолд шүүх тухайн хариуцлагын хөнгөрүүлэхээс татгалзаж болдог⁵³.

13 насанд хүрээгүй гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ буюу албадлагын арга хэмжээг хэрэглэх бөгөөд тухайн этгээд 13 насанд хүрсэн тохиолдолд түүнд авч буй арга хэмжээ тодорхой үр дүнд хүрээгүй гэж үзвэл түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэж болохоор хуульчилсан⁵⁴.

Эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаар нь улс орон бүрд тэдний нийгэм, эдийн засаг, ёс заншил, соёл иргэншил, улс төрийн болон эрх зүйн тогтолцооноос нь хамаарч харилцан адилгүй байна. Тухайлбал, Малайз 10⁵⁵, Румын 12⁵⁶, Турк 12⁵⁷, Швед 12⁵⁸, Болгар 14⁵⁹, Их Британи 14⁶⁰, Аргентин 14⁶¹, Финланд 15⁶², Куба 16⁶³ гэх ба эдгээр насанд хүрээгүй хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар хуульчилсан. Гэвч гэмт хэрэг үйлдэхдээ дээрх насанд хүрсэн ба 18 насанд хүрээгүй бол тэдэнтэй холбоотой мөрдөн шалгах, шүүх ажиллагааг тусгай журмаар явуулахаар нийтлэг байдлаар хуульчилсан.

Дүгнэлт

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх тэр дундаа хорих ял оноох нь тухайн хүнийг хүмүүжүүлэх бус дахин гэмт хэрэг үйлдэх нөхцөл байдал руу түлхэх боломжтой гэж олон улсын гэрээ хэлэлцээрт дурдсан байна.

Монгол Улсын Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэх насны хязгаарыг 16 нас, зарим төрлийн гэмт хэрэгт 14 нас гэж хуульчилсан нь нийгэм, эрх зүйн хөгжилтэй харьцуулан үзэхэд тохиромжгүй байна. Учир нь сүүлийн жилүүдэд хийсэн судалгааны тайлангаас үзэхэд, гэмт хэрэг үйлдэх нас харьцангуй залуужсан

⁵² Patrizia Meringolo, *Juvenile Justice System in Italy: Researches and interventions*, 2011, www.researchgate.net/publication/262515461_Juvenile_Justice_System_in_Italy_Research_and_interventions

⁵³ Anne Wyvenkens, *The French Juvenile Justice System*, 2017, halshs.archives-ouvertes.fr/halshs-00458770/document

⁵⁴ 1 жилээс бага хугацаа үлдсэн тохиолдолд цагдан хорих байранд хорино, 1 жилээс их бол насанд хүрээгүй хүнийг тодорхой мэргэжил эзэмшүүлэх зорилгоор сургалтын хорих байгууллагад хорино, halshs.archives-ouvertes.fr/halshs-00458770/document

⁵⁵ www.agc.gov.my/agcportal/uploads/files/Publications/LOM/EN/Penal%20Code%20%5BAct%20574%5D2.pdf

⁵⁶ www.vertic.org/media/National%20Legislation/Romania/RO_Criminal_Code.pdf

⁵⁷ www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf

⁵⁸ www.government.se/contentassets/5315d27076c942019828d6c36521696e/swedish-penal-code.pdf

⁵⁹ prostitution.procon.org/sourcefiles/BulgariaCriminalCode.pdf

⁶⁰ agc.gov.ms/wp-content/uploads/2010/02/penal_code.pdf

⁶¹ www.loc.gov/law/help/child-rights/argentina.php

⁶² www.finlex.fi/en/laki/kaannokset/1889/en18890039_19951010.pdf

⁶³ www.warnathgroup.com/wp-content/uploads/2015/03/Cuba-Penal-Code-Lawyers-Without-Borders-2009.pdf

байх бөгөөд энэ нь техник, технологийн хөгжлөөс шалтгаалан хүүхдийн сэтгэн бодох, танин мэдэхүй, эргэцүүлэл нь маш хурдацтай төлөвшсөнтэй холбон тайлбарлаж болно.

Өсвөр насны хүнтэй холбогдох ихэнх гэмт хэргүүдийн шалтгаан, нөхцөл нь тэдний асран хамгаалах, харгалзан дэмжих үүрэг бүхий этгээдүүдээс өсвөр насны хүний хүмүүжилд тавих анхаарал хяналт суларсан тохиолдолд гэмт хэрэг, зөрчил үйлдэх явдал идэвхжиж байдаг.

Иймд бусад улсын жишгээр асран хамгаалагч, харгалзан дэмжигч этгээдүүдэд мөн үүрэг хүлээлгэж хариуцлага тооцох арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай. Хэдийгээр энэ нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангид тусгалаа олсон шударга ёсны зарчимтай зөрчилдөх боловч дээр дурдсан ойлголт нь эрүүгийн хариуцлагыг халдаан хэрэглэх бус асран хамгаалах харгалзан, дэмжих үүргээ үл биелүүлсэнд нь л хариуцлага хүлээлгэж буй явдал юм.

Олон улсын гэрээ хэлэлцээрт өсвөр насны хүнтэй холбогдох гэмт хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэх этгээд нь тухайн чиглэлээр мэргэшсэн байх, зөвхөн уг асуудлыг шийдвэрлэх бүтцийн байгууллага шинээр байгуулахыг шаардаж зөвлөдөг бол манай улсын хувьд энэ ойлголт хэрэг бүртгэх, мөрдөн шалгах ажиллагааны явцад л хэрэгждэг.

Цаашид өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийг шалган шийдвэрлэхэд дагнасан прокурор, шүүх байгуулах шаардлагатай байна.

Ашигласан материал

Нэг.Сурах бичиг, нэг сэдэвт бүтээл

1. Б.Ганболд, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн тойм, Улаанбаатар, 2003 он.
2. Монгол хэлний их тайлбар толь.

Хоёр.Эрх зүйн баримт бичиг

3. НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенц

Гурав.Гадаад эх сурвалж

4. Aksay Bekir, Ceza Hukukunda Yaş Küçüklüğü, İstanbul 1990 он.
5. Anne Wyvenkens, The French Juvenile Justice System, 2017 он.
6. Bağcı Olcay, Çocuk Yargılaması, İstanbul Barosu Yayınları, Cep kitapları.
7. Mücadelede Kurumsal Yaklaşım, İstanbul 1998 он.
8. Mûcahit Çolak, İslam hukukunda ceza ehliyeti açısından yaş küçüklüğü,
9. Atatürk üniversitesi ilahiyet fakültesi dergisi, sayı: 35, Erzurum 2011 он.
10. Naci Şensoy, Çocuk suçluluğu – küçüklük – çocuk mahkemeleri ve infaz müesseseleri. 1990 он.
11. Şahin Akıncı. Roma Hukuku Dersleri, Sayram yayınları. 2019 он
12. Öztürk Bahri, Erdem M.Ruhan, Uygulamalı Ceza Muhakemesi Hukuku, Ankara 2006 он
13. Patrizia Meringolo, Juvenile Justice System in Italy: Researches and interventions, 2011 он
14. Yusuf Solmaz, Çocuk Ceza Hukuku, Ankara 2003 он.
15. www.mevzuat.gov.tr/MevzuatMetin/1.5.5237.pdf
16. www.government.se/contentassets/5315d27076c942019828d6c36521696e/swedish-penal-code.pdf
17. www.loc.gov/law/help/child-rights/argentina.php
18. www.finlex.fi/en/laki/kaannokset/1889/en18890039_19951010.pdf
19. www.warnathgroup.com/wp-content/uploads/2015/03/Cuba-Penal-Code-Lawyers-Without-Borders-2009.pdf
20. prostitution.procon.org/sourcefiles/BulgariaCriminalCode.pdf
21. agc.gov.ms/wp-content/uploads/2010/02/penal_code.pdf
22. germanlawarchive.iuscomp.org/?p=756halshs.archives-ouvertes.fr/halshs-00458770/document

ЭРҮҮГИЙН ПРОЦЕССЫН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

МӨРДӨН ТОГТООХ ЧИГ ҮҮРГИЙН АГУУЛГА, МӨН ЧАНАР CONTENT AND NATURE OF INVESTIGATIVE FUNCTIONS

Н.Сайнбаяр

*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D), цагдаагийн хошууч*

Товч агуулга: Гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны салшгүй нэгэн шинж нь чиг үүргийн оновчтой хуваарилалтын асуудал яах аргагүй мөн. Чиг үүргийн оновчтой хуваарилалт нь хүний эрхийг баталгаатай хангах чухал арга хэрэгсэл болдог. Шүүх эрх мэдэл нь мөрдөн тогтоох, яллах (өмгөөлөх), хянан шийдвэрлэх зэрэг үндсэн чиг үүргийн тусламжтайгаар хэрэгждэг болох нь олон улсын болоод үндэсний эрх зүйн тогтолцоонд хийсэн судалгааны үр дүнд бий болсон. Гүйцэтгэж буй чиг үүргийн мөн чанарыг танин мэдэж, түүнийг оновчтой тодорхойлсноор хүний эрхийг хангах механизмыг бүрдүүлж чадна.

Энэхүү өгүүллээр мөрдөгчийн хэргийн бодит байдлыг тогтоох үндсэн үүргийн хүрээнд гүйцэтгэдэг мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанарыг эрх зүйн философийн үүднээс тайлбарлаж, тодорхойлохыг зорилго.

Abstract: One of the integral features of crime fighting activities is the problem of optimal distribution of functions. The rational distribution of functions is an important means of guaranteeing human rights. The fact that the judicial power is implemented with the help of basic functions such as investigation, prosecution (defense), and review was established as a result of research in the international and national legal systems. By recognizing the nature of the function being performed and defining it rationally, a mechanism for ensuring human rights can be formed.

This report aims to explain and define the nature of the investigative function performed by the detective within the framework of the main task of establishing the facts of the case from the point of view of legal philosophy.

Түлхүүр үгс: Мөрдөх, мөрдөх ажиллагаа, чиг үүрэг, шүүх эрх мэдэл, мөрдөн тогтоох, мөрдөн тогтоох чиг үүрэг.

Keywords: Investigate, investigation, function, jurisdiction, investigative functions.

Хүн төрөлхтөн бий болсон цагаас эхлэн аюулгүй орчинд амьдрах зорилгоор тодорхой хэсэг бүлгээр даган баримтлах хэм хэмжээг бий болгож мөрдөх болжээ. Дан ганц бүгд хүлээн зөвшөөрч мөрдөөд хангалтгүй байв. Нийгмийн дагаж мөрдөж буй аливаа зарлиг, хуулийг зөрчих явдлаас сэргийлэх, зөрчсөн хүнд шийтгэл оногдуулах харилцаа улам боловсронгуй болсоор одоогийн эрүүгийн эрх зүйн шинжлэх ухааныг бий болгожээ. Үүний зэрэгцээ зөрчигч хүнийг илрүүлэх, үйлдлийг нь шалгаж тогтоох, гэм буруугийн асуудлыг оновчтой тодорхойлох агуулга бүхий үйл ажиллагааг системчилсэн эрүүгийн процессын эрх зүй мөн даган хөгжжээ.

Криминологич Ч.Бекариа: “гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ял нь ил тод, хойшлуулшгүй, гарцаагүй, тухайн нөхцөлд хамгийн боломжтой хэмжээгээр бага буюу үйлдсэн гэмт хэрэгт нь тохирсон байх ёстой”⁶⁴ гэж үзэж байсан нь одоогийн хууль тогтоомжид тусгалаа олсон байдаг. Энэхүү ялын тухай онолын хэрэгжилтийг хангахад мөрдөгчийн гүйцэтгэх үүрэг чухал байр суурь эзэлнэ. Өөрөөр хэлбэл, ялыг

⁶⁴ Бекариа, Ч. Гэмт хэрэг ба ялын тухай. Орч. Эрдэнэбат, Г. -УБ., 2021. 119 дэх тал.

хойшлуулшгүй, гарцаагүй байх зарчмыг хангах эсэх нь мөрдөгчийн чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэхээс шууд хамаарна гэсэн үг.

Гэмт хэрэг гэж томъёолсон үзэгдэл байгаа тохиолдолд түүнийг илрүүлж нийгэмд шударга ёсыг тогтоох эрмэлзэл ямагт оршоор байх нь ойлгомжтой. Тэгвэл гэмт хэрэг өдүүлсэн хүнийг олж илрүүлэх үйл ажиллагааны мөн чанарыг тодорхойлохын тулд урьдаар эрх зүйн тогтолцооны онцлог шинжийг харгалзаж үзэх нь зайлшгүй. Газар нутаг, амьдралын хэв маяг, нийгмийн ахуйн онцлогоос хамаарч эрх зүйн хэм хэмжээний шинж чанар бий болно. Тодруулбал, аливаа улсын хувьд эрх зүй бүтэх үйл явц, шүүх эрх мэдлийн эзлэх байр суурь, эрх зүйн эх сурвалж хэрэглэх, харилцаа хамаарал зэргээс шалтгаалж эрх зүйн тогтолцоо тодорхойлогдоно.

Эрх зүйн тогтолцоо (бүл)-ний талаар Германы эрдэмтэн Готфрид Лейбниц “Nova Methodus Discendae Docendaeque Iurisprudentiae”⁶⁵ (1667) бүтээлдээ анх удаа: “Улс орнуудын нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйг ижил төстэй байдлаар нь нэгтгэн авч үзэж болох юм” гэсэн санааг дэвшүүлснээр хууль зүйн шинжлэх ухааны судлагдахуун болжээ. Харин хожим Францын эрдэмтэн Рене Давид, Лейбницийн эрх зүйн тогтолцооны талаарх санааг өргөжүүлэн өнөө үед түгээмэл хэрэглэгдэх болсон ангиллыг бий болгожээ⁶⁶.

Эрх зүйн бүлийн онцлогоос үл хамаарч дэлхий нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрүүгийн процессын суурь зарчмууд хэдийн бий болжээ. Эдгээрт:

1. Шүүхээр нотлогдоогүй үед ямар ч нөхцөлд гэм буруугүйд тооцох (Produce innocence);
2. Нотолгооны цогц шинжийг хангах, тэнцвэртэй бөгөөд харилцан шалгах зарчим (Cross-examination);
3. Хэргийг зөвхөн шүүх шийдвэрлэх (Ratione temporis);
4. Мөрдөн тогтоох ба яллах чиг үүргийг ялган зааглах зарчим;
5. Эрүүдэн шүүхээс ангид байх эрхийг хангах;
6. Шүүх хэргийг хараат бусаар, бие даан шийдвэрлэх зарчим;
7. Баривчлах, цагдан хорих арга хэмжээг шүүхийн хэлэлцүүлгийн үндсэн дээр шүүгчийн тогтоолоор онцгой тохиолдолд хэрэглэх зарчим;
8. Гэмт хэргийн талаарх баримт сэлтийг шүүх хуралдаанаас өмнө урьдчилан үнэлэхгүй байх зарчим⁶⁷ г.м-ийг дурдаж болно.

Эдгээр зарчмууд нь НҮБ-ын гэрээ, конвенцод шууд тусгагдсан байхаас гадна ихэнх улс, орнуудын Үндсэн хуулиудаар хамгаалагдсан байдаг. Мөн эрүүгийн процессын хэрэгжилтийн явцад хүний халдашгүй эрхийг хамгаалах, ЭХХША-д олон улсын эрх зүйн нийтлэг хэм хэмжээг дагаж мөрдөх, түүнчлэн мөрдөгч, прокурор, өмгөөлөгч, шүүгчийн ёс зүй, сахилга, хариуцлагыг өндөржүүлэхэд чухал түлхэц үзүүлж байгаагаараа ач холбогдолтой.

Дэлхийн улсуудад аль эрх зүйн бүлд хамаарахаас үл шалтгаалж хэргийг мөрдөн тогтоож, шүүхээр шийдвэрлэж буй олон арга хэлбэрийг ижилсүүлж эрүүгийн процессын дараах загвар хэдийн бий болжээ. Үүнд:

- 1) Аккусаци систем (Accusatory process);
- 2) Инквизици систем (Inquisitorial process);
- 3) Хосолсон систем⁶⁸ (Mixed process).

Аккусацийн систем нь илүү нээлттэй уян хатан, чөлөөт мэтгэлцээний процесс болдог бол инквизицийн систем нь харьцангуй хаалттай хязгаарлалт бүхий мэтгэлцээний бус процесс юм. Энэ нь мэтгэлцэх тогтолцоо бөгөөд шүүгдэгчийг буруутгасны дараа түүний мэдэгдлийг эсрэг талын процессоор нотлох ёстой гэсэн үг юм. Онцлог нь тал бүр (яллах тал, өмгөөлөх тал) шүүгч эсвэл тангарагтны

⁶⁵ “Эрх зүйд суралцах, заах шинэ арга” (Латин)

⁶⁶ Rene David. Les grands systèmes de droit contemporains. Основные правовые системы современности. Перевод с французского языка д.ю.н. Туманов, В.А. - М.,1988. С.8.

⁶⁷ Yale Kamisar., Wayne R.Lafave, Nancy J.King. Modern criminal procedure. -W.,2005. P.118.

⁶⁸ “Эрх зүй” сэтгүүл. -Уб.,2014. №3.(39). 76 дахь тал., Баярсайхан, Д. Эрүүгийн процессын эрх зүй. - Уб.,2020.13 дахь тал.

бүрэлдэхүүнд хамгийн үнэмшилтэй аргументыг гаргаж ирдэг процесс юм. Тухайлбал, яллагдагч талаас өөрийн хэргийн талаар нотлох баримтуудыг гаргаж тавихад түүний үндэслэлийн сул талуудыг гаргаж тавих байдлаар шүүн таслах ажиллагаа явуулдаг. Энэ үед шүүхээс өмнө хэргийг мөрдөхгүй гэсэн үг огтоос биш бөгөөд шаардлагатай гэж үзвэл, эрх бүхий байгууллагаас мөрдөх ажиллагааг явуулж үр дүнг шүүхэд хүргүүлдэг.

Нотлох баримтыг хэн ч урьдаар үнэлдэггүй бөгөөд зөвхөн шүүгч эсвэл тангарагтны шүүх ирүүлсэн нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэнэ. Яллах систем нь өрсөлдөгчийн системтэй адил юм. Хэн хамгийн оновчтой логик, зүй тогтлыг тайлбарлаж чадна тэр тал ялалтыг авах боломжтой.

Аккусаци процесс нь олон улс оронд хэрэглэгдэж байгаа бөгөөд гэм буруугүй гэсэн таамаглал дээр үндэслэх бөгөөд хүнийг гэм буруутай нь нотлогдох хүртэл гэм буруугийд тооцдог, нотлох үүрэг нь яллах тал (прокурор) дээр ирдэг. Яллах үйл явц нь яллагдагчийг улсын яллагч, хохирогчоос албан ёсоор буруутгаж, яллах, улмаар яллагдагчийг шүүхэд өөрийгөө хамгаалах боломжийг олгоно. Шударга шүүхээр шийдвэрлүүлэхэд чиглэгдсэн хүний эрхийг хангахад энэ тогтолцоо олон чухал баталгааг хангаж өгдөг.

Инквизици нь "Inquisition adhere process"⁶⁹ буюу шүүхээр шийдэх хэргийг заавал урьдаар мөрдөж, тодорхой нөхцөл байдлыг тогтоох гэсэн чиг хандлага юм. Инквизици процесс нь нэг талаас хэргийг бүх талаас бүрэн бодиттойгоор тогтоох нөхцөлийг хангах зорилготой бөгөөд гэм бурууг зөвхөн шүүх тогтоох шаардлагад нийцүүлэн төрийн хуульд захирагдах зарчимтай салшгүй холбоотой⁷⁰.

Инквизицийн хэв загвар нь мөрдөн шалгах ажиллагааг ямар ч хэргийн хувьд заавал явуулах гэсэн уламжлалт хандлага өөрчлөгдөж, хүнд биш зарим хэргийн хувьд гэм буруугаа хүлээсэн, хохирлоо төлсөн тохиолдолд шүүхэд шилжүүлэхгүй буюу түргэвчилсэн, хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжийг шинээр хуульчлах болжээ⁷¹. Энэ процесс нь шүүхийн чөлөөт мэтгэлцээн, ял тохиролцох зэрэг процедурыг үгүйсгэдэг. Хэргийн хувь заяа мөрдөн байцаалтын үр дүнгээс ихээхэн хамаарах ба прокуророос шилжүүлсэн хавтаст хэргийн хэмжээнд шүүн таслан ажиллагаа явагддаг нь уг процессын гол онцлог юм⁷².

Инквизици хэв загварын онцлогийг дараах байдлаар тодорхойлж болох юм. Үүнд:

- Эрүүгийн процессын эх сурвалж нь хууль тогтоомжоор зохицуулагдсан бөгөөд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх журмын тухай ерөнхий ба зэрэгцсэн хуулиудаар тодорхойлогдсон байна. Зарим тохиолдолд эрүүгийн процессын хэсэгчилсэн хуулиуд, хуульчилсан актуудыг гаргасан байдаг. Тухайлбал, УДШ-ийн тогтоол, тайлбар, прокурорын аргачилсан заавар г.м;

- Эрүүгийн процесс нь мөрдөн байцаалтын буюу шүүхийн өмнөх үе, шүүн таслах ажиллагааны буюу шүүхийн шатны гэсэн хатуу зааглагдсан хоёр үе шаттай байдаг. Түүнчлэн шүүхийн өмнөх шат нь хойшлуулшгүй мөрдөн мөшгөх болон шалгах, яллах ажиллагааны гэсэн тус тусдаа процесс үеийг хамардаг бол шүүхийн шат нь урьдчилсан хэлэлцүүлгийн, шүүх хуралдааны болон шүүхийн тогтоол гаргах, гүйцэтгэх зэрэг ажиллагааны дэс дараалал бүхий үе шаттай;

- Шүүхийн өмнөх шатны процесст прокурор хяналт тавьдаг бөгөөд мөрдөн байцаалтын ажиллагааг мэргэжлийн үүднээс чиглүүлэн удирдаж, яллах чиг үүргийг хэрэгжүүлнэ;

- Зарим тохиолдолд "Judical investigation" буюу шүүхийн мөрдөн байцаалтын ажиллагааг хэрэгжүүлэх субъект шүүгчийн статустай (Франц, Испани улсуудад мөрдөгч-шүүгчийн статустай байдаг);

⁶⁹ Мөрдөн байцаалт гарцаагүй байх.

⁷⁰ Criminal procedure. A worldwide study. Carolina. 2007. P.21.

⁷¹ Головки, Л.В. Альтернативы уголовному преследованию в современном праве. -СПб., 2008. С.23.

⁷² Баярсайхан, Д. Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага // Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь сэдэвт илтгэлийн эмхтгэл. -Уб.,2019. 10 дахь тал.

- Шүүхийн өмнөх шатны процессын ажиллагаанд прокурор харьцангуй давуу эрхтэй байх ба өмгөөлөгчийн оролцоо зарим талаар хязгаарлагдмал шинжтэй байдаг;
- Мөрдөн байцаалт явуулах эрх бүхий субъектийн хэргийн харьяалал болон эрүүгийн хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх хугацааг хуулийн нарийвчилсан тодорхой нөхцөл журмын дагуу зохицуулсан;
- Шүүх хуралдаан нь мөрдөн байцаалтын шатанд авагдсан мэдүүлгийн тэмдэглэлийг нотлох баримт болгон ашигладаг ба яллах зарчимд тулгуурласан мэтгэлцээний хязгаарлалт бүхий процессын хэлбэртэй;
- Мөрдөн байцаалтын үр дүнд цугларсан нотлох баримтыг нягтлан шалгасны үндсэн дээр прокурор яллах акт үйлдэн хэргийг шүүхэд шилжүүлэх бөгөөд энэхүү хавтаст хэргийн хэмжээнд шүүх хуралдаан явагдана;
- Нотлох ажиллагааны бүрэн цогц байдлын бодит шаардлагыг хангахын тулд бүх төрлийн хэрэгт мөрдөн байцаалтыг заавал явуулах бөгөөд аливаа эрүүгийн хэрэг зөвхөн шүүхээр эцэслэн шийдвэрлэх ёстой⁷³ зэрэг нь манай улсын эрүүгийн процессын эрх зүйн тогтолцоонд хадгалагдан үлдсэн байна. Дээрх бүгдээс үзэхэд, шүүхийн өмнөх шатанд бэхжүүлж, баримтжуулсан нотлох баримтын үндсэн дээр хэргийн хувь заяа шүүхээр эцэслэн шийдвэрлэгддэг агуулга харагдаж байна.

Хосолсон хэв маягийн процесс ажиллагаанд инквизиц, аккусагийн шинжүүд харилцан бий болж буй байдлыг ойлгоно. Энэ нь орчин үед шинээр бий болж эхэлсэн хандлага бөгөөд мэтгэлцээний болон мэтгэлцээний бүс хэлбэрийн аль алиныг хослуулсан зохистойгоор уялдуулан зохицуулахад чиглэгдсэн систем юм.

Монгол Улсын хууль тогтоомжийн шинжийг авч үзэхэд, хосолсон эрүүгийн процессын загвар бүхий тогтолцоонд хамаарахаар байна. Энэ талаар ч зарим судлаачид⁷⁴ санал нэгдсэн байдаг. Учир нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар бүхий л гэмт хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа гарцаагүй явагдаж, түүний үр дүнд бий болсон нотлох баримтыг үндэслэн прокурор, шүүх шийдвэр гаргана. Зарим төрлийн хэрэгт яллагдагч өөрт холбогдох хэргийг хялбаршуулан шийдвэрлүүлэх эрхтэй байдаг зэрэг нь аккусац болон инквизицийн аль алиных нь шинжийг агуулдаг.

Эрүүгийн процессын аккусац, инквизиц, хосолсон тогтолцооны аль нь ч бай шүүх эцсийн шийдвэр гаргадаг. Шүүхийн шийдвэрийг бүрэн бодитой, шударга ёсонд нийцэх эсэх нь гэмт хэрэг үйлдэгдсэн даруйд хийгдсэн шалгалтын ажиллагааны үр дүнгээс хамаарч байна. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдэгдсэн даруйд эрх бүхий байгууллагаас холбогдох гарцаагүй, нэн шаардлагатай урьдах мөрдөх ажиллагааг гүйцэтгэж, үр дүнг шүүх харгалзан үздэг ерөнхий агуулга илэрхийлэгдэнэ. Дэлхийн нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн эрүүгийн процессын аккусац, инквизиц, холимог тогтолцоо бүрд мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилт гарцаагүй байх аж.

Нийгмийн ашиг сонирхолд тулгуурлан эрх зүйн шинэ үзэгдлүүдийг зохицуулахын тулд түүнийг танин мэдэх буюу мөн чанарыг нь тодорхойлох хэрэгцээ шаардлага зүй ёсоор үүснэ. Энэ тохиолдолд эрх зүйн гүн ухаан (философи)-ны зүгээс тухайн харилцаанд тохирсон эрх зүйг боловсруулахын тулд түүхэн хөгжил, тулгуур зарчимд нийцүүлэн эрх зүйн хэм хэмжээг бий болгодог зүй тогтолтой.

“Эрх зүйн философи нь эрх зүйн утга, түүний мөн чанар, ойлголт, үндэслэл, ертөнцөд эзлэх байр суурь, түүний үнэлгээ, ач холбогдол, хүний амьдрал, нийгэм төрд гүйцэтгэх үүрэг зэрэг асуудлыг судалдаг”⁷⁵, “Эрх зүйн тухай философийн шинжлэх ухааны судлах зүйл нь эрх зүйн санаа болох эрх зүйн ойлголт, түүний хэрэгжилт”⁷⁶ гэж

⁷³ Баярсайхан, Д. Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага // Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь сэдэвт илтгэлийн эмхэтгэл. -Уб.,2019. 10-11 дахь тал.

⁷⁴ Цогтбаатар, Б. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийг нотлох ажиллагаа. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл. - Уб.,2021. 15 дахь тал., Эрхэсхулан, Ж. Шүүхийн мэтгэлцээн ба шүүмжлэлт рационализм.// Эрх зүй сэтгүүл. -Уб.,2011. №1. 120 дахь тал.

⁷⁵ Нерсесянц, В.С. Эрх зүйн гүн ухаан. –М.,1999. 7 дахь тал//орч. Батаа, Д. Бүрнээ, Т.

⁷⁶ Гегель, Г. Философия права. –М.,1990. С.59-60.

үзэж байсан бол Италийн эрх зүйн философич Н.Боббио “Шударга ёс бол эрх зүйн философийн үндсэн асуудал, түүний судлах зүйл” гэж явцуу утгаар авч үзжээ. Харин Югославын эрх зүйн онолын төлөөлөгч Р.Лукич: “Эрх зүйн философи нь салбар философи учир нийгэм, бүх байгаа зүйлийн бүхэлд бус, нийгмийн нэг хэсэг болох эрх зүйг л зөвхөн судална. Гэвч эрх зүйн философи нь гүн ухаан учраас түүнд ерөнхий философийн бүхий л шинжүүд зүй ёсоор байдаг. Энэ түүний судлагдахуун нь философийн судлагдахуунтай адил гэсэн үг юм”⁷⁷ гэжээ.

Энэ бүгдээс эрх зүйн философийн судлах зүйл нь эрх зүйтэй холбогдох бүхий л ойлголтууд, онолын үзэл баримтлал, эрх зүйн илрэн гарах гадаад хэлбэр, хэрэгжилт зэрэг хамаарч байна. Үүнээс, мөрдөгчийн мөрдөн тогтоох чиг үүрэг, түүний эрх зүйн зохицуулалт нь эрх зүйн философийн салбар хэсгийн нэгэн судлагдахуун болох нь тодорхой юм.

Эрүүгийн мөрдөн тогтоох ажиллагаа нь яллах, өмгөөлөх, шүүн шийдвэрлэх гол тулгуур чиг үүргүүдийн эхлэл үндсийг тавигч хэмээн нэрлэгдэж улам бүр шийдвэрлэх ач холбогдолтой болсоор байна. Ер нь эрүүгийн процессын чиг үүргүүд, түүний дотор “мөрдөх” нь нотлох баримт бүрийг бодит шинжээр нь илрүүлэхийг зорилгоо болгосоор ирсэн. Тиймдээ ч яллаж зэмлэхээс гадна өмгөөлөн хамгаалах процесс ажиллагаа мөрдөн тогтоох үед явагдсаар байдаг нь эргэлзээгүй үнэн⁷⁸ гэдэгтэй санал нийлэхгүй байхын аргагүй. Мөрдөн тогтоох чиг үүрэг нь хэргийн бодит байдлыг тогтоох гэсэн мөрдөгчийн үндсэн үүргээс урган гарах бөгөөд хуульд заасан үүргийн хэрэгжилтийг хангахын тулд авч хэрэгжүүлж буй бүхий л дэс дараалал, зохион байгуулалттай үйл ажиллагааг “мөрдөн тогтоох” гэж хэлж болох юм.

Мөрдөн тогтоох үйл ажиллагааны зорилго нь ямагт үнэнийг тогтоох гэсэн мөрдөгчийн эрмэлзэлтэй уялдаж, хууль зүйн хүрээнд хэрэгждэгээрээ онцлогтой. Мөрдөгчийн үнэнийг олох гэсэн эрмэлзэл, хүчин чармайлт түүний үүрэг гүйцэтгэх орчинтой салшгүй холбоотой.

Мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанарыг танин мэдэх, зохицуулалтын хэм хэмжээг оновчтой боловсруулахад эрх зүйн герменевтик⁷⁹ онол- арга зүйг хэрэглэх нь оновчтой юм гэж үзсэн. Герменевтик философийг эрх зүйн шинжлэх ухааны хүрээнд хөгжүүлсэн гол төлөөлөгчид нь А.Кауфман, В.Хассемер нар бөгөөд энэхүү онол нь эрх зүйг агуулга талаас нь судалдаг ч зөвхөн байгаа зүйлийн хүрээнд бус, мөн байх ёстой зүйлийн хүрээнд судалдагараа онцлог юм⁸⁰. Герменевтик арга зүйгээр аливаа юмсыг ойлгоход гурван харилцаа үүсдэг бөгөөд үүнийг герменевтикийн гурвалжин⁸¹ гэж тодорхойлдог байна.

Эдгээр нь танин мэдэхүйн объект (гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал), тухайн объектыг бий болгогч субъект (гэмт хэрэг үйлдсэн хүн), танин мэдэхүйн процесс (мөрдөн тогтоох чиг үүрэг) хооронд харилцаа үүсэх ба танин мэдэхүй нь объектыг бий болгогч субъектийг зөв танин мэдсэнээр объектыг зөв тодорхойлно гэсэн үг. Өөрөөр хэлбэл, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг танин мэдсэнээр гэмт хэрэг үйлдсэн хүнийг тодорхойлж чадна.

“Байгаа зүйлд үндэслэн байх ёстой зүйл бий болдог”⁸² зүй тогтолтой. Байгаа зүйл болох “гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал”-д тулгуурлан “байх ёстой зүйл” (гэмт хэрэг үйлдсэн хүн)-ийг илрүүлнэ. Тодруулбал, нэгэнт гэмт хэрэг үйлдэгдэх нийгмийн үзэгдэл байгаа бол түүнийг илрүүлэх, бодит байдлыг тогтоох эрмэлзэл бүхий

⁷⁷ Лукич, Р. Методология права. –М.,1981.С.69.

⁷⁸ Бямбаа, Ж., Эрхэсхулан, Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. -УБ.,2018. 206-207 дахь тал.

⁷⁹ Герменевтик (*hermeneia*) гэдэг нь тайлбарлах, тайлбар гэсэн утгатай грек гаралтай үг аж. Анхлан Аристотелийн үеэс хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд тухайн үедээ Зевс бурхны үгийг хүмүүст тайлбарлан өгдөг Гермению бурхны нэрнээс үүсэлтэй байжээ. Харитонов, Л. А. Герменевтический подход к толкованию правовых норм//КриминалистЪ. 2011. №1. С.113-117.

⁸⁰ Сэлэнгэ, Х. Эрх зүйн философи: онол, арга зүйн асуудал. -УБ.,2018. 41 дэх тал.

⁸¹ Новая философская энциклопедия.(Философийн шинэ лавлах). <https://ru.wikipedia.org> Татаж үзсэн: 10.01.2023.

⁸² Сэлэнгэ, Х. Эрх зүйн философи: онол, арга зүйн асуудал. -УБ.,2018. 43 дахь тал.

зохион байгуулалттай үйл ажиллагаа буюу мөрдөх тогтоох ажиллагаа зайлшгүй. Герменевтикийн онолоор аливаа “байгаа зүйл”-ээс “байх ёстой” хэм хэмжээ урган гарах зүй тогтолтой тул, “байгаа зүйл”-ийг танин мэдэх хэрэгцээ үүснэ. Иймээс “гэмт хэрэг” гэсэн ойлголт байгаа тохиолдолд түүнийг илрүүлэн, шалгаж, зөрчигдсөн эрхийг сэргээхэд чиглэсэн “мөрдөн тогтоох” чиг үүрэг зайлшгүй байх ёстой юм.

Зураг №3. Мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилт.



Гэмт хэрэг үйлдсэн хүнийг зөв тодорхойлохын тулд түүний үүсгэсэн шалтгаан буюу нөхцөл байдал (ул мөр, эд мөрийн баримт г.м)-г танин мэдэх, мөрдөн тогтоох нь зайлшгүй болохыг харж болно.

Герменевтикийн онолын үүднээс мөрдөн тогтоох чиг үүрэг байх ёстой болохыг харуулж чадсан ч энэ нь хангалтгүй юм. Эрх зүйн философи нь философийн категориудын тусламжтайгаар эрх зүйн бодит агуулга, мөн чанар, түүний хууль зүйн илрэх хэлбэр, үндсийг танин мэдэхүйн сэтгэлгээний түвшинд судалж, гносеологи, онтологи, аксеологийн асуудлыг хөндөж, хууль зүйн шинжлэх ухааны тулгуур асуудлыг шийдвэрлэх явдал юм⁸³ гэдэгтэй санал нийлж байна.

Ийм учраас бид мөрдөгчийн үндсэн чиг үүрэг болох мөрдөн тогтоох чиг үүргийг оршихуй (онтологи), үнэт зүйл (аксеологи), танин мэдэхүй (гносеологи) гэсэн эрх зүйн философийн үндсэн асуудлын хүрээнд авч үзэх нь зайлшгүй. Ингэснээр мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанарыг бүрэн бодитой тодорхойлох боломжтой.

Мөрдөн тогтоох чиг үүргийн онтологи. Онтологи гэдэг нь хууль зүйн бус, философийн ойлголт бөгөөд хүн байгаль, нийгмийн үзэгдлүүдийн үүсэл, мөхлийг ажиглах явцад орших, эс оршихуйн асуудал, бодит ахуйн тухай асуудал байнга үүсэж байсны үр дүнд философийн ахуйн тухай сургаал бий болжээ.

Аливаа хүн хүрээлэн буй орчныг баримжаалахдаа тухайн орчны бодит байдлыг мэдэрдэг. Энэ мэдрэмж нь тухайн орчныг онолын үүднээс тодорхойлох болон практик туршлагаар дамжин мэдрэгдэх бөгөөд энэ нь юу хийх хэрэгтэй, тухайн объекттой юу болоод байгааг ойлгох, ухамсарлахад тусалдаг. Эрх зүйн бодит байдал нь өргөн утгаар эрх зүйн үзэл баримтлал, эрх зүйн харилцаа, институтууд, эрх зүйн хэм хэмжээ гэх мэт эрх зүйн үзэгдлүүдийн нийлбэр цогц юм⁸⁴. Өөрөөр хэлбэл, мөрдөн тогтоох чиг үүрэг хэрэгжүүлэх явцад түүнд үүсэж буй аливаа хүндрэл, бэрхшээл, мөрдөх ажиллагааг шуурхай явуулах эрмэлзэл бүхий шийдэл нь тодорхой зохицуулалтыг шаардаж, энэхүү хэрэгцээ шаардлага нь шинээр хэм хэмжээний акт бий болох үндэс болно. Мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилтэд зохицуулалт шаардлагатай болох нь түүний бодит оршихуй байгааг илэрхийлнэ. Жишээлбэл, хүний өмчтэй байх эрхэд дураараа халдахыг хориглодог бөгөөд зөвхөн мөрдөх ажиллагааны хүрээнд зохих журмын дагуу үзлэг, нэгжлэг хийх, хураан авах ажиллагааг хэрэгжүүлэх боломжтой.


Эрх зүйн онтологийн үүднээс мөрдөх үйл ажиллагааны хэм хэмжээ тодорхой түвшинд оршин байсаар ирсэн бөгөөд түүний мөн чанар нь салбарын хууль

⁸³ Агар-Эрдэнэ, Г., Банзрагч, Л. Эрх зүйн философи. –Уб., 2013. 44 дэх тал., Сэлэнгэ, Х. Эрх зүйн философи. –Уб., 2013. 55-71 дэх тал.

⁸⁴ Агар-Эрдэнэ, Г., Банзрагч, Л. Эрх зүйн философи. –Уб., 2013. 53 дахь тал.

тогтоомжуудад тусгалаа олсон. Эрх зүйн ахуйн илрэх хэлбэр нь эрх зүйн танин мэдэхүйн үр дүн юм. Ийнхүү эрх зүй нь субъектийн эрх зүйн танин мэдэхүйн хүрээнд бүрэлдэн тогтож, нийгмийн амьдралд хэрэгжиж байдаг.

Зураг №4. Мөрдөн тогтоох чиг үүргийн онтологи.



Мөрдөн тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал нь эрх зүйн зохицуулалттайгаа салшгүй холбоотой бөгөөд тулгамдаж буй асуудал нь эрх зүйн зохицуулалтын хэм хэмжээг боловсронгуй болгох шаардлагыг бий болгоно. Тухайлбал, ковид 19 цар тахлын хязгаарлалтын үед МША хэрэгжүүлэх хүндрэл бэрхшээл үүсэж байсан тул цахимаар МША явуулах хэрэгцээ шаардлага үүсэж байсан.

Хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай мөрдөн тогтоох чиг үүргийн эрх зүйн зохицуулалт бодитой оршин байна уу, хэрэв байвал ямар хэлбэрээр оршиж байна вэ гэсэн асуудал эрх зүйн ахуйн тухай сургаалын хүрээнд тайлбарлагдана. Энэ нь зөвхөн эрүүгийн процессын хэм хэмжээ байгаа эсэх тухай яригдаагүй нь ойлгомжтой.

Гэмт хэрэгтэй тэмцэх, түүнийг илрүүлэх, шалгаж, гэм буруутай этгээдэд тохирсон хариуцлага хүлээлгэх үйл явц нийгэм үүссэн цагаас эхлэн байсан тул хэрэг шалгаж, шийдвэрлэхүйц чадамжийн асуудал ямагт оршино. Тэгэхээр, эрх зүйн онтологи сургаал дээр тулгуурлан нэг талаас хэргийн бодит байдлыг тогтоохыг зорьсон мөрдөгчийн хүсэл, эрмэлзэл, нөгөө талаас тухайн хэрэгт МША явуулах, шийдвэрлэх боломж, нөхцөл хоорондын хамаарал нь гэмт хэрэгтэй тэмцэх үйл хэрэгт байсаар ирсэн, цаашид ч байх нь ойлгомжтой тул энэ нь мөрдөн тогтоох чиг үүргийн оршихуй мөн.

Үүнтэй холбогдуулж мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилтэд үүсэж буй бодит бэрхшээлүүдийн талаар авч үзэв. Мөрдөгч хуульд заасан хэргийн бодит байдлыг тогтоох үүргээ хэрэгжүүлэх явцдаа гэрч, сэжигтэн, яллагдагч, хохирогчийг дуудан ирүүлж мэдүүлэг авах шаардлага үүсдэг. Гэтэл мөрдөгчийн дуудсанаар хүрэлцэн ирээгүй нь процессын оролцогчид ямар нэгэн хууль зүйн үр дагавар үүсгэдэггүй хуулийн зохицуулалт нь мөрдөгчийн хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд хүндрэл дагуулсаар байна. Мөрдөн тогтоох чиг үүргийг хэрэгжүүлэгчийн байр сууринаас авч үзэхэд, “нэг этгээдийн эрх нь өөр нэг этгээдийн хувьд үүргийг бий болгоно”⁸⁵ императив шинжгүй байгаа нь зөрчилдөөнтэй байна. Энэ нь хууль тогтоомжийн зүйл заалт ба мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилтийн зөрчилтэй байдлын илэрхийлэл бөгөөд хууль зүйн хүрээнд зайлшгүй зохицуулалт шаардах нь мөрдөн тогтоох чиг үүргийн оршин буйг илтгэнэ.

Мөрдөгчийн мөрдөн тогтоох чиг үүргийн оршихуйг Гегелийн диалектик тусламжтайгаар мөн тодорхойлох боломжтой. Энэ талаар доктор Т.Очирбат: Гегелийн диалектикийн гол санаа нь “Аливаа ойлголт нь эсрэг ойлголтыг өөртөө авч явна. Энэ хоёрын зөрчил нь анхдагч ойлголтоос цоо шинэ, баялаг ойлголт үүссэнээр шийдвэрлэгдэнэ”⁸⁶ гэсэн логикоор тайлбарлагдана гэжээ. Энэ нь нэг оршин буйгаас

⁸⁵ Ханс Кельзен. Хэм хэмжээний ерөнхий онол. Орч. Хатанбаатар, М., ред. Амарсанаа, Ж. -УБ., 2013. 138 дахь тал.

⁸⁶ Очирбат, Т. Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй, зохион байгуулалтын асуудал. Нэг сэдэвт бүтээл. - УБ., 2019. 103 дахь тал., Философи. -ДК/Монсудар хэвлэлийн газар, 2012.182 дахь тал.

нөгөө нэг нь үүсдэг бөгөөд тасралтгүй шинжтэй байх агуулгаар илэрхийлэгдэж байгаа нь бидний дээрх дүгнэлтийг баталж байна.

Мөрдөн тогтоох чиг үүргийн аксеологи. Эрх зүйн үнэт зүйл, тэдгээрийн агуулга, философийн үндсийг илрүүлэн, улмаар орчин үеийн эрх зүйн үнэт зүйлийн онол-арга зүйн чиг хандлагыг танин мэдэхэд аксеологийн зорилго оршино⁸⁷. Мөрдөгч хуульд заасан хэргийн бодит байдлыг тогтоох үүрэгтэй тул мөрдөн тогтоох чиг үүрэг нь зөвхөн” бодит үнэнийг тогтоох” гэсэн үнэт зүйлийг агуулсан байх ёстой. Өөрөөр хэлбэл, хэргийн бодит байдлыг тогтоох гэсэн боломжит нөхцөл, хүсэл эрмэлзэл, зорилго нь мөрдөн тогтоох чиг үүргийн үнэт зүйл нь болох учиртай.

Эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн явцад эртнээс өнөөг хүртэл эрх зүйн санаа, эрх зүйн хэм хэмжээ, бодгалийн эрх зүйн ухамсрын аль ч түвшинд эрх зүйн үнэт зүйл нь дараах үндсэн зарчмууд болохыг хүлээн зөвшөөрсөн байна. Үүнд: эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс болно⁸⁸. Эдгээр зарчмууд нь ямагт нэг нэгэнтэйгээ уялдаа, холбоотой оршино. Энэ утгаараа эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс нь аливаа эрх зүйн үзэдлийн үнэт зүйлийг тодорхойлох аж. Өөрөөр хэлбэл, эрх чөлөөгүй тэгш байдал гэж үгүй, тэгш байдалгүй шударга ёс оршин тогтнох боломжгүй юм.

Эрх чөлөөний талаар Жон Локк, И. Кант, Р.Г. Лотце, Г.В.Гегель, Ш.Монтескье, И.Берлин, Жан-Поль Сартр зэрэг сэтгэгчийн дэвшүүлсэн үзэл санаа эрх зүйн философид чухал үүрэг гүйцэтгэжээ. Эдгээр сэтгэгчийн үзэл санаанаас нэгтгэн дүгнэж үзвэл “эрх чөлөө гэдэг нь бусдын оролцоогүйгээр үйлдэл хийх боломж” юм. Гэхдээ эрх чөлөө нь дур зорго бус, эрх зүйт эрх чөлөө байж гэмээ нь жинхэнэ эрх чөлөө болно гэдгийг дээрх сэтгэгчид онцолжээ⁸⁹. Тэгэхээр, эрх чөлөө бол бие даан шийдвэр гаргах боломж, нөгөө талаар гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээн үүргийг мөн давхар агуулах онцлогтой аж.

Энэ шинжээрээ эрх чөлөөний тухай үнэт зүйл нь мөрдөн тогтоох чиг үүрэгт зайлшгүй тусгалаа олсон байх учиртай. Гэтэл одоогийн хуулиар мөрдөгч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад цугларсан нотлох баримтын үндсэн дээр дотоод итгэл үнэмшилдээ тулгуурлан хэргийг шийдвэрлэх ямар ч боломжгүй буюу эрх чөлөөгүй байгаа нь мөрдөн тогтоох чиг үүргийн үнэт зүйлийн үндсэн шинж болох эрх чөлөөний зарчим алдагдсан болохыг харуулж байна. Жишээлбэл, мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилтийн үр дүнд хэн нэгэн сэжиглэгдсэн хүнийг буруугүй гэж үзэн хэрэг бүртгэлтийн хэргийг хаах санал үйлдэж, хэргийг прокурорын хяналтад шилжүүлэхэд, прокурор хэргийг хаах үндэслэл тогтоогдоогүй гэж нэмэлт хэрэг бүртгэлтэд буцаасан тохиолдолд мөрдөгч нь прокурорын уг шийдвэрт дээд шатны прокурорт санал гаргахгүй эрхгүй, хэргийг хүлээн авч шалгахаас өөр сонголтгүй байдаг нь эрх чөлөөний зарчим алдагдсаныг харуулж буй юм.

Мөрдөгчийн хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд хараат бусаар шийдвэр гарган, үүсэх хариуцлагыг хүлээх боломж нөхцөл нь эрх чөлөөг илтгэнэ. Дээрхээс үндэслэн, эрх чөлөө нь эрх зүйн хэм хэмжээний агуулгыг тодорхойлж байдаг. Джон Локк: “Эрх чөлөө хаана байна, тэнд хууль байна. Хууль хаана байна, тэнд эрх чөлөө байна. Хууль үгүй бол эрх чөлөө үгүй. Хуулийн зорилго нь эрх чөлөөг үгүйсгэх буюу хязгаарлахад бус, харин эрх чөлөөг хадгалах, өргөтгөхөд оршино”⁹⁰ гэжээ. Эрх чөлөөний талаарх ойлголтыг мөрдөгчийн чиг үүргийн зорилготой уялдуулж зөв оновчтой зохицуулалтыг хийх нь чухал. Хэн нэгний заавар, тушаалаар аливааг хийх нь гэмт хэрэг илрүүлэх үйл явцыг саармагжуулах талтай. Мэдээж энэ нь мөрдөгчийн хүсэл сонирхол, итгэл үнэмшилтэй холбогдож тайлбарлагдана. Иймд Монгол Улсын

⁸⁷ Сэлэнгэ, Х. Эрх зүйн философи: Онол- арг зүйн асуудал. -Уб.,2018. 42 дахь тал.

⁸⁸ Нерсисянц, В.С. Эрх зүйн гүн ухаан. Орч. Д.Батаа. -Уб.,1996. 45-50 дахь тал; Лүндээжанцан, Д. Эрх зүйн философи. -Уб.,2014. 35 дахь тал.; Сэлэнгэ, Х., Агар-Эрдэнэ, Г. Эрх зүйн философи. -Уб.,2013. 55-71 дэх тал; Гомбосүрэн, Ц. Философи. -Уб.,2014. 448-451 дэх тал; Барсайхан, Д. Эрх зүйн онол. -Уб.,2016. 24-38 дахь тал.

⁸⁹ Очирбат, Т. Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй, зохион байгуулалтын асуудал. Гарын авлага. -Уб.,2019. 107 дахь тал.


⁹⁰ Локк. Дж. Сочинения в трех томах. -М.,1988. С.293.

ЭХХШТХ нь мөрдөгчийн хувьд “эрх чөлөө”-г агуулаагүй хууль төдийгүй, “хуулийн зорилго нь эрх чөлөөг үгүйсгэх буюу хязгаарлахад бус, харин эрх чөлөөг хадгалах, өргөтгөхөд оршино” гэсэн Джон Локкийн үзэл баримтлалтай зөрчилдөж байна.

Эрх чөлөөний хүрээ, хязгаар нь эрх зүйн хэм хэмжээгээр буюу хуульд бэхжихдээ хүний эрх, эрх чөлөөг хооронд нь зөрчилдүүлэлгүй адил тэгш байдлаар илрэх ёстой тул эндээс хүний эрх, эрх чөлөөний тэгш байдлын ойлголт бий болж байна. Мөрдөн тогтоох чиг үүргийн эрх зүйн зохицуулалтын тэгш байдал нь хэргийн бодит байдлыг тогтоох үүргээ хэрэгжүүлэхэд ижил боломж, нөхцөлтэй байхаас эхэлнэ. Өөрөөр хэлбэл, хэрэг шалгаж буй мөрдөгч бүхэн нэг ижил боломж, нөхцөлтэй байх ёстой гэсэн үг. Гэтэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа салбарын хуулиар ЦЕГ, ТЕГ, АТГ-ын мөрдөгчид харилцан адилгүй орчин, нөхцөлд үүрэг гүйцэтгэдэг.


Тэгш байдлыг хангах асуудал эрүүгийн процессын оролцогчид хүртэл хамаарах ёстой. Мөрдөн тогтоох чиг үүргийн үндсэн шинж нь яллах болон цагаатгах талын бүхий л нотлох баримтыг эн тэнцүү цуглуулж бэхжүүлэхэд оршино. Гэвч одоогийн эрх зүйн тогтолцооны хүрээнд мөрдөгч бие даасан чиг үүрэгтэй субъект боловч прокурорын бүрэн хяналтын дор бүхий л үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байгаа нь үндсэндээ яллах чиг үүргийг хэрэгжүүлж буй байдалтай болсон. Өөрөөр хэлбэл, прокурор яллах чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор мөрдөгчийг удирдаж, өмгөөлөх талын хүсэл сонирхлыг хязгаарлах хэв шинж бүрджээ.

Зураг №4. Мөрдөн тогтоох чиг үүргийг тэгш байдлыг харуулав.



Дээрх зургаас яллах болоод өмгөөлөх талууд ЭХХША-д нэг түвшинд, ижил оролцоотой байх бөгөөд мөрдөн тогтоох чиг үүргийн хүрээнд тэгш байдлыг хангаж байна.

Зураг №5. Мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилт (одоогийн хууль тогтоомжоор)



Харин уг зураглалд мөрдөн тогтоох чиг үүрэг прокурорын удирдлагад хэрэгжиж, яллах болоод өмгөөлөх талууд ижил бус түвшинд харилцан адилгүй байдлыг илтгэнэ. Энэ утгаараа мөрдөн тогтоох чиг үүргийн хэрэгжилт тэгш байдлын зарчимд нийцэхгүй байгаа нь тодорхой байна. Энэ нь “мөрдөн тогтоох ба яллах чиг үүргийг ялган зааглах зарчим”⁹¹-тай зөрчилдөж байна.

Тэгш бус тогтолцооны үр дүн үргэлж шударга бус шинжийг өөртөө агуулж байдаг. Хэдийгээр шүүх хэргийг бүрэн, дүүрэн шийдвэрлэж болох ч бодит байдлыг тогтоох үйл явц нь тэгш бус байгаа тохиолдолд шүүхийн шийдвэр сонгодог утгаараа шударга ёсонд нийцэх боломжгүй. Энэ нь “зорилго-арга хэрэгслээ зөвтгөнө”⁹² гэсэн социалист бүтээн байгууллын үеийн үзэл баримтлал одоо ч эрүүгийн процесст агуулагдсаар байгааг илтгэнэ. Шударга байх, шударга ёс гэсэн ойлголтууд нь латины Jus, Justitia буюу тэнцвэртэй, зохистой, үнэн зөв, тогтвортой гэсэн утгыг илэрхийлэн хэрэглэгдэж иржээ. Эрх чөлөөний тэгш байдлын зарчим нь шударга ёсны санааг бий болгодог⁹³.

Нэрт философич В.С. Нерсисянц: “Эрх зүйд нийцэж, эрх зүйг тодорхойлж, эрх зүйг дагадаг зүйл л шударга байна. Үйл ажиллагааг шударгаар явуулна гэдэг бол түүнийг эрх зүйн дагуу, эрх зүйн түгээмэл, тэгш шаардлагуудад нийцүүлнэ гэсэн үг юм”⁹⁴ гэжээ. Мөрдөгчийн хэрэгжүүлж буй бүхий л үйл ажиллагаа хуульд нийцсэн байх ёстой. Тухайлбал, Монгол Улсын ЭХХШТХ-д заасан үндэслэл, журмыг зөрчиж авсан баримтат мэдээллийг нотлох баримтаар тооцохгүй⁹⁵ гэсэн хэм хэмжээ нь шударга ёсонд нийцэж байгааг харуулна.

Зарим тохиолдолд хуульд заасан боловч амьдралд хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүсдэг. Тухайлбал, сэжигтнийг шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах эрх мөрдөгчид бий, гэтэл тэрээр энэхүү эрхээ хэрэгжүүлж баасан гаригийн 18 цагт сэжигтнийг баривчилсан тохиолдолд, шүүх долоо хоногийн амралтын өдрүүдээр ажилладаггүйтэй холбоотойгоор 24 цагийн дотор шүүх баривчилсан асуудлыг шийдвэрлэх агуулга бүхий хуулийн заалт хэрэгжихгүй гажуудал 2017 оны 07 сарын 01-ний өдрөөс одоог хүртэл оршсоор байна. Энэ тохиолдолд мөрдөгчийн сэжигтнийг баривчлах ажиллагаа шударга ёсны заримтай зөрчилдөнө. Хуулийн холбогдох заалт

⁹¹ Kamisar., La Fave, I king. Modern criminal procedure. -W.,2005. P.118.

⁹² Италийн зохиолч, улс төрч Н.Макиавелли “Төрийн эрх” (1532) бүтээлдээ анх “fine giustifica i mezzi”- Зорилго арга хэрэгслээ зөвтгөнө гэсэн ойлголтыг бий болгосон. Энэхүү үзэл баримтлал нь: нийгмийн сайн сайхны төлөө, аливаа эрхийг зөрчих, хүчирхийлэл үйлдэхийг зөвтгөж болно гэсэн агуулгаар илэрхийлэгдэнэ.

⁹³ Очирбат, Т. Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй, зохион байгуулалтын асуудал. Гарын авлага. -Уб.,2019. 113 дахь тал.

⁹⁴ Нерсисянц, В.С. Эрх зүйн гүн ухаан. Орч. Д.Батаа. -Уб.,1996. 27 дахь тал.

⁹⁵ Монгол Улсын ЭХХШТХ-ийн 16.1 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг.

байгаа ч тэр болгон хэрэгжих боломжгүй байдаг. Энэ нь мөрдөгчөөс шалтгаалахгүй ч түүний сэжигтнийг баривчилсан үйл ажиллагааг шударга явагдсан гэж үзэх боломжгүй. Үүнээс, шударга ёсны зарчимд нийцээгүй тогтолцоо буйг мөрдөгч мэдсээр байж сэжигтнийг анхнаасаа баривчлах ёсгүй байсан гэсэн логик урган гарна. Баривчилсны дараа бус түүний өмнө сэжигтнийг баривчлахгүйгээр асуудалд хандах нь шударга ёсны зарчимд нийцнэ. Сэжигтнийг баривчлах ажиллагаа хууль ёсны боловч түүнийг баривчлах байрнаас гаргах процесс нь өөрөө хууль бус байгаа нь агуулгын хувьд шударга ёсонд нийцэхгүй. Сэжигтнийг баривчлахгүй байх шийдвэрийг гаргах нь мөрдөгчөөс хууль зүйн өндөр мэдлэг чадвар болоод ёс зүйг шаардана. Үүнээс шударга ёс нь ёс зүйтэй нягт холбоотойг харж болно. Энэ талаар О.Хёффе: “Шударга ёс нь мөн чанараараа ёс зүйн үүрэг”⁹⁶ гэсэн нь тохиолдлын хэрэг биш юм. Иймд мөрдөгч аливаад позитивист хандлагаар бус, харин эрх зүйн үнэт зүйлийн үнэлэмжээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд эрмэлзэх ёстой.

Дүгнэн үзэхэд, “эрх чөлөө, тэгш байдал, шударга ёс нь эрх зүйн агуулгыг тодорхойлж, эрх зүйн үнэт зүйлийн илрэл болж байдаг тул эрх зүйн тогтолцооны үндэс юм”⁹⁷ гэсэнтэй бид санал нийлж байна. Мөрдөгчийн мөрдөн тогтоох чиг үүргийн зохицуулалтын хэм хэмжээнд эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зармыг баримтлах нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үндсэн суурь нөхцөл мөн.

Мөрдөн тогтоох чиг үүргийн танин мэдэхүй. Эрх зүйн танин мэдэхүйн зорилго нь эрх зүйн мөн чанар, бодит нөхцөлийг судалж, эрх зүйн тухай үнэн мэдлэгт хүрэх явдал юм. Эрх зүйн танин мэдэхүй нь эрх зүйн онтологи, аксеологитой шууд холбоотой. Эрх зүйн гносеологийн талаар эх сурвалжуудыг⁹⁸ судлах явцад позитив болон позитив бус гэсэн хоёр хандлага зонхилдог болох нь тодорхойлогддог.

Позитив хандлагын онцлог нь эрх зүйн эх сурвалжийг хүний эрх, эрх чөлөөний үнэт зүйл, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим, стандартаас бус, зөвхөн эрх мэдлээс эрж хайдагт оршино. “Энэ үндсэнд бүх хууль, захиргааны акт, шүүхийн шийдвэр буюу төрийн засаглалын зэрэг бүхий л актуудыг эрх зүйн хэмжээ гэж ойлгодог”⁹⁹.

Мөрдөн тогтоох чиг үүргийн зохицуулалтын хэм хэмжээг позитив хандлагаар авч үзвэл, ТАТХ, ЭХХШТХ, ЦАТХ, УЕП-ын МША-тай холбоотой тушаал, ЦЕГ-ын алба хаагчийн эрх зүйн байдалтай холбоотой бүхий л хэм хэмжээний акт нь мөрдөн тогтоох чиг үүргийн зохицуулалтыг бүрдүүлж байна гэж ойлгож болно. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж, актууд нь эрх зүйн аксеологи талаас нь урьд нь авч үзсэн билээ.

Позитив бус хандлага эрх зүй, хууль хоёр агуулгаараа ялгаатай бөгөөд эрх зүй нь тэргүүлэх шинжтэй, хуульд хэлбэршинэ. Гэхдээ агуулгаараа зөв байх ёстой гэж үзнэ. Хууль агуулгаасаа хамаарч эрх зүйн дагуу бус, дур зоргын байж болно гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Тийм хууль хэзээ ч эрх зүйн гэсэн нэр алдрыг хүлээхгүй гэдэг. Энэ чиг хандлагын онцлог нь танин мэдэхүйн хүрээнд эрх зүйн үнэнд хүрэхийг эрмэлздэг тул эрх зүйг ямар байх ёстой вэ? гэсэн байх ёстой зүйлийн хүрээнд, эрх зүйн мөн чанар, агуулгыг судалдагт оршино. Мөрдөгчийн мөрдөн тогтоох чиг үүргийн эрх зүйн зохицуулалт ямар байх ёстой вэ гэдгийг позитив бус хандлагын үүднээс авч үзэхэд, гадаад улсын туршлага, мөрдөгчийн үйл ажиллагааны онцлог, ажлын ачаалал, бусад тулгамдаж буй асуудалд суурилсан хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэгдэнэ. Өөрөөр хэлбэл, хуульд заасан хэм хэмжээ нь хүний эрхийг зөрчихөөр тохиолдолд, мөрдөгч бие даан хүний эрхэд суурилсан мөрдөх ажиллагаа явуулах байдлаар

⁹⁶ Агар-Эрдэнэ, Г., Банзрагч, Л. Эрх зүйн философи. –Уб., 2013. 63 дахь тал.

⁹⁷ Агар-Эрдэнэ, Г., Банзрагч, Л. Дурдсан бүтээлд. 64 дэх тал.

⁹⁸ Агар-Эрдэнэ, Г., Банзрагч, Л. Дурдсан бүтээлд. 66 дахь тал., Нерсесянц, В.С. Эрх зүйн гүн ухаан. Орч. Д.Батаа. –Уб., 1999. 66 дахь тал., Лүндээжанцан, Д. Эрх зүйн философи. –Уб., 1998. 45 дахь тал., Лүндэндорж, Н. Эрх зүй судлал: философи, онол. –Уб., 17 дахь тал., Нарангэрэл, С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. –Уб., 2001. 49 дэх тал.

⁹⁹ Агар-Эрдэнэ, Г., Банзрагч, Л. Эрх зүйн философи. –Уб., 2013. 67 дахь тал., Лүндэндорж, Н. Эрх зүй судлал: философи, онол. –Уб., 17 дахь тал.

илэрхийлэгдэнэ. Эдгээрийг судалсны үндсэн дээр мөрдөн тогтоох чиг үүргийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох хэрэгцээг бий болгоно.

Дүгнэлт

Мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанарыг нээн харуулахын тулд үндэсний эрх зүйн тогтолцооны онцлогийг харгалзан, эрх зүйн философийн категориудад тулгуурлаж, герменевтикийн онол арга зүйгээр тайлбарлахыг зорив. Энэ хүрээнд Монгол Улс дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн эрүүгийн процессын холимог загварын тогтолцоотой бөгөөд мөрдөн тогтоох чиг үүрэг голлох байр суурийг эзэлдэг болох нь тодорхой болов.

Мөрдөн тогтоох чиг үүрэг нь хэргийн бодит байдлыг тогтоох гэх эрүүгийн процесс хуулийн зорилтос урган гарах бөгөөд мөрдөгчийн үнэнийг тогтоох гэсэн эрмэлзлээр илэрхийлэгдэж, хууль зүйн хүрээнд хэрэгждэг зүй тогтолтой. Мөрдөн тогтоох чиг үүрэг нь шүүхийн өмнөх шатанд гагцхүү мөрдөгч хэрэгжүүлдэг бөгөөд энэхүү чиг үүргийн хэрэгжилт нь мөрдөгчийн эрх зүйн байдалтай шууд хамааралтай юм.

Эрх зүйн философийн категорируудын тусламжтайгаар авч үзсэн нь мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанарын талаар бүрэн, бодитой дүгнэх, танин мэдэх боломжийг олгосон. Мөрдөн тогтоох чиг үүрэг гэмт хэрэг үйлдэгдсэн тохиолдолд гарцаагүй хийгдэх ажиллагаа бөгөөд зохих журмыг баримтлан, хараат бусаар, бие даан хэрэгжүүлэхийг шаарддаг зүй тогтолтой байх аж. Энэхүү зүй тогтол хангагдаагүй тохиолдолд мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанар алдагдаж, улмаар нийгэмд шударга ёс тогтох боломжгүй болно.

Мөрдөн тогтоох чиг үүрэг нь шүүх эрх мэдлийн хүрээнд бие даасан онцлог шинж боловч яллах чиг үүргийг хэрэгжүүлэгч прокурорын бүрэн хяналт дор оршсоор байгаа нь нэгэнт тогтсон эрх зүйн философийн категориудтай зөрчилдөж байна. Эрх зүйн философийн категориуд нь ямагт хүний эрх эрх чөлөөг хангахад чиглэсэн, олон жилийн эрх зүйн ахуйн зөв шийдэл байдаг тул эдгээртэй зөрчилдсөн аливаа эрх зүйн үзэгдэл нь хүний эрхийн зөрчлийг ямагт бий болгоно гэж үзэж байна. Иймд мөрдөн тогтоох чиг үүргийн мөн чанарыг танин мэдэх замаар эрх зүйн зохицуулалтыг оновчтой боловсруулах нь хүний эрх, эрх чөлөөг хангах урьдач нөхцөл мөн.

Ашигласан материал

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. 2017
3. Агар-Эрдэнэ, Г., Банзрагч, Л. Эрх зүйн философи. –Уб., 2013
4. Барсайхан, Д. Эрх зүйн онол. -Уб., 2016
5. Баярсайхан, Д. Эрүүгийн процессын эрх зүй. -Уб., 2020
6. Баярсайхан, Д. Эх газрын эрх зүйн тогтолцооны эрүүгийн процессын мөн чанар, чиг хандлага // Эрүүгийн процессын эрх зүйн тулгамдсан асуудлыг харьцуулан судлах нь сэдэвт илтгэлийн эмхтгэл. -Уб., 2019
7. Бекария, Ч. Гэмт хэрэг ба ялын тухай. Орч. Эрдэнэбат, Г. -Уб., 2021
8. Бямбаа, Ж., Эрхэсхулан, Ж. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. -Уб., 2018
9. Гомбосүрэн, Ц. Философи. -Уб., 2014
10. Головкин, Л.В. Альтернативы уголовному преследованию в современном праве. -СПб., 2008
11. Гегель, Г. Философия права. –М., 1990
12. Лукич, Р. Методология права. –М., 1981
13. Лүндээжанцан, Д. Эрх зүйн философи. -Уб., 2014
14. Локк, Дж. Сочинения в трех томах. -М., 1988
15. Лүндэндорж, Н. Эрх зүй судлал: философи, онол. -Уб., 2017
16. Нерсисянц, В.С. Эрх зүйн гүн ухаан. –М., 1999. //орч. Батаа, Д. Бүрнээ, Т.
17. Нарангэрэл, С. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. -Уб., 2001.

18. Очирбат, Т. Шинжлэн магадлахуйн онол, эрх зүй, зохион байгуулалтын асуудал. Нэг сэдэвт бүтээл. -Уб.,2019
19. Сэлэнгэ, Х. Эрх зүйн философи: онол, арга зүйн асуудал. -Уб.,2018.
20. Ханс Кельзен. Хэм хэмжээний ерөнхий онол. Орч. Хатанбаатар,М., ред. Амарсанаа, Ж. -Уб.,2013
21. Цогтбаатар, Б. Ашигт малтмал хууль бусаар олборлох гэмт хэргийг нотлох ажиллагаа. Хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл.- Уб.,2021
22. Эрхэсхулан, Ж. Шүүхийн мэтгэлцээн ба шүүмжлэлт рационализм// Эрх зүй сэтгүүл. -Уб.,2011. №1
23. “Эрх зүй” сэтгүүл. -Уб.,2014. №3.(39)
24. Rene David. Les grands sistemiemes de droit contemporains. Основные правовые системы современности. Перевод с французского языка д.ю.н. Туманов, В.А. - М.,1988
25. Yale Kamisar., Wayne R.Lafave, Nancy J.King. Modern criminal procedure. -W.,2005.
26. Criminal procedure. A worldwide study. Carolina. 2007.
27. Новая философская энциклопедия.(Философийн шинэ лавлах). <https://ru.wikipedia.org> Татаж үзсэн: 10.01.2023
28. Харитонов, Л. А. Герменевтический подход к толкованию правовых норм//КриминалистЪ. 2011. №1

ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ АВАХАД АНХААРАХ АСУУДАЛ

MEASURES TO AVOID POLICE IMPRISONMENT SOME ISSUES TO CONSIDER WHEN PURCHASING

Д.Бат-Эрдэнэ
*ДХИС-ийн Цагдаагийн сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн
тэнхимийн багш, цагдаагийн ахмад*

Товч агуулга: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангах, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд, ял оногдуулах, эрүүгийн процессын ажиллагааг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цаг алдалгүй явуулах, яллагдагчид цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авах, уг арга хэмжээг авахад тулгамдсан асуудлыг тодорхойлох, санал дүгнэлтийг дэвшүүлээ.

Abstract: To meet the objectives of criminal proceedings, to impose punishment on the person guilty of a crime, to conduct the criminal process without delay in accordance with the grounds and procedures stipulated by the law, to take preventive measures for the accused, and to take such measures. study the problem and put forward the opinion.

Түлхүүр үгс: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, сэжигтэн, яллагдагч, цагдан хорих, оргон зайлах, эрэн сурвалжлах ажиллагаа

Keywords: criminal procedure, preventive detention, suspect, accused, detention, fugitive, investigation

Оршил

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зорилт нь гэмт хэргийг шуурхай бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн хуулийн этгээдийг олж тогтоох, шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршино.

Эрүүгийн процессын ажиллагааг нэг талаас төрийг төлөөлж буй оролцогчид хэрэгжүүлдэг бөгөөд нөгөө талаас эрх ашиг сонирхол нь хөндөгдсөн этгээдүүд буюу хохирогч, сэжигтэн, яллагдагч оролцдог бөгөөд хуульд заасан үндэслэл журмын дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг мөрдөн байцаалтын шатанд хэрэгжүүлдэг онцгой албадлагын арга хэмжээний нэг юм.

Хуулийн алдаа хийдэл, практикт ажиллаж байгаа мөрдөгч, прокурорууд мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан яллагдагчийг шөнийн цагаар болон амралтын өдрүүдэд олж тогтоосон даруйд цагдан хорих талаар шүүгчийн захирамж гараагүй л бол яллагдагчийг хууль бусаар хорих, нөгөөтэйгүүр мөрдөгчийн амь нас, эрүүл мэндэд ноцтой хохирол учруулж болзошгүй байгаа учир тухайн сэдвийг хөндөх хэрэгцээ, шаардлага тулгарч байна.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний ойлголт

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дэх хэсэгт “Хүн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл журмаар гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно”.¹⁰⁰

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын фактад “Хүн бүр эрх чөлөөтэй байх болон халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчилж

¹⁰⁰ Монгол улсын үндсэн хууль, 1992 он

буюу цагдан хорьж болохгүй. Хуулиар тогтоосон үндэслэл, журмаас бусад тохиолдолд хэнийг хорьж болохгүй.”¹⁰¹

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх албадлагын арга хэмжээ гэдэгт уг ажиллагааг хэрэгжүүлэх явцад үүсэж болох бүх төрлийн сөрөг үйлдэл, үр дагаврыг даван туулах, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, оролцогчдын үүрэг хариуцлага, зохистой зан үйлийг төлөвшүүлэхийн тулд хуулийн дагуу хэрэглэж буй бүх төрлийн албадлагын чанартай арга, хэрэгслийг ойлгоно.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны албадлагын арга хэмжээг баривчлах, таслан сэргийлэх, шалгаж шийдвэрлэх ажиллагааны бусад албадлагын арга хэмжээ гэсэн үндсэн 3 бүлэг хуваадаг.

Эдгээр албадлагын арга хэмжээ нь өөр хоорондоо ялгаатай хэдий ч, дараах нийтлэг шинжийг агуулна. Тухайлбал,

- Албадлагын
- Хувь хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг тодорхой хугацаагаар хязгаарлах,
- Зөвхөн төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэрийг үндэслэсэн байх
- Зөвхөн хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу хэрэгжүүлэх
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч талын зохистой зан үйлийг хангахад чиглэх
- Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны зорилтыг хангахад чиглэх зэрэг болно.¹⁰²

Таслан сэргийлэх арга хэмжээ гэдэг нь хуульд заасан үндэслэл, журмын дагуу мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий байгууллага болон шүүхээс дуудсан цагт хүрэлцэн ирэх нөхцөлийг хангах, хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээр хэрэглэж буй эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагааны албадлагын арга хэмжээний тогтолцоог ойлгоно.

Таслан сэргийлэх арга хэмжээг дотор нь нийтлэг ба тусгай шинжтэй гэж ялгана. Нийтлэг шинжтэй арга хэмжээ хэмжээнд:

- Хувийн баталгаа гаргах,
- Барьцаа авах,
- Хязгаарлалт тогтоох,
- Цагдан хорих,

Тусгай шинжтэй таслан сэргийлэх арга хэмжээнд

- Өсвөр насны сэжигтэн, яллагдагчийг хянан харгалзах,
- Цэргийн ангийн удирдлагын мэдэлд хянан харгалзуулахаар шилжүүлэх зэрэг болно.¹⁰³

Цагдан хорих гэдэг нь мөрдөгчийн санал, прокурорын тогтоолыг үндэслэн яллагдагчийг шүүгчийн зөвшөөрөл хуульд заасан тодорхой хугацаагаар нийгмээс тусгаарлаж, эрх чөлөөг нь хязгаарлаж байгаа албадлагын арга хэмжээг хэлнэ.¹⁰⁴

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь яллагдагч, шүүгдэгчийн хувийн эрх, эрх чөлөөг ихээхэн хязгаарладаг тул түүнийг хэрэглэх тусгай нөхцөлийг хуулиар тогтоосон. Тухайлбал энэ арга хэмжээг зөвхөн шүүгчийн зөвшөөрлөөр авна.¹⁰⁵

Шүүх дор дурдсан үндэслэлийн аль нэг нь байвал цагдан хорих шийдвэр гаргана. Үүнд:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан,

¹⁰¹ Хүний эрх “Олон улсын гэрээ хэлэлцээрүүдийн эмхэтгэл” УБ., 1998. 12 дахь тал

¹⁰² Нямбаатар.Х. Оюунчимэг.Т.Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа. УБ.,2020. 85 дахь тал

¹⁰³ Нямбаатар.Х. Оюунчимэг.Т.Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа. УБ.,2020. 87 дахь тал

¹⁰⁴ Лхагварачаа.Б. Эрдэнэбаатар.П. Эрүүгийн процессын эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/. 2021. УБ.

¹⁰⁵ Нямбаатар.Х. Оюунчимэг.Т.Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа. УБ.,2020. 89 дахь тал

2. Шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа,
3. Гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт байгаа,
4. Урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн хорих ялын доод хэмжээг 8 жил түүнээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэргийн яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч болно.¹⁰⁶

Мөн манай улс цагдан хорих ажиллагаатай холбогдсон олон улсын дараах гэрээг соёрхон баталж, үндэсний хууль тогтоомжоо нийцүүлсэн.

-Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт /1968 оны 01 сарын 05-ны өдөр гарын үсэг зурж, 1975 оны 11 сарын 18-ны өдөр соёрхон баталсан/

-Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц /2000 оны 11 сарын 02-нд нэгдэн орсон/ тус тус болно.¹⁰⁷

Монгол Улсын Үндсэн хуулийн 47 дугаар зүйлийн 1-д “Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.”

Шүүн таслах ажиллагааг гагцхүү үндсэн хуулийн дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлэх зарчим нь Үндсэн хуульд заасан “шударга шүүхээр шүүлгэх” хүний эрхээс үүдэлтэй. Эл эрх нь хүний эрх эрх чөлөө, нэр төр, хууль ёсны ашиг сонирхлыг шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаанаас хамгаалах чухал хэрэгсэл юм.

Үндсэн хуулийн дагуу байгуулагдсан шүүх гэдэг нь тэгш эрх, шударга ёсыг үндсэн зарчмаа болгосон, хэрэг маргааныг хөтөлбөргүй тогтоогдсон нотлох баримт, мэтгэлцээний үр дүнд тулгуурлан шийдвэрлэх чадвартай шүүх юм.

Шүүх бүрэлдэхүүн бол эрүүгийн хэргийг талууд ба бусад оролцогчдын оролцоотойгоор цугларсан баримтад тулгуурлан шүүх хуралдаанаар шийдвэрлэх онцгой эрхтэй шүүгч буюу шүүгчид юм.

33 дугаар зүйл. Шүүхийн бүрэн эрх

33.1.3 сэжигтэн яллагдагч, шүүгдэгчид баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах,¹⁰⁸

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.1-д Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, гэдгийг үг зүй болон өгүүлбэр зүйн хувьд судлаачид өөрийн бүтээл туурвилдаа хэрхэн ямар байдлаар бичиж тайлбарласныг сийрүүлэе.

ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.36-д “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэж” гэж заажээ. ¹⁰⁹

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан нөхцөл, журмын дагуу тасралтгүй явагдах үйл явц төдийгүй тодорхой зорилго, чиглэлтэй хэрэгжих процесс байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь гэмт хэрэг гарсан талаарх хүн, албан тушаалтан, хуулийн этгээдээс гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авахаас эхэлж, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноор дуусгавар болдог,

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт, шүүн таслах ажиллагаанаас зориуд зайлсхийсэн гэдэг нь оршин суугаа газраасаа гадагш явж болохгүй баталгаа авах, батлан даалтад өгөх, эд хөрөнгө барьцаалах, цэргийн ангийн

¹⁰⁶ Баярсайхан.Д. Эрүүгийн процессын эрх зүй.УБ.2020. 164 дэх тал

¹⁰⁷ Гантулга.Н. Хүний эрх ба хорих ял”.УБ.2015. 189 дэх тал

¹⁰⁸ Бат-Эрдэнэ.Б. Жанцан.С. Монгол улсын эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ.2003.40 дэх тал

¹⁰⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ.2022. 117 дэх тал

удирдлагад хянан харгалзуулахаар өгөх зэрэг таслан сэргийлэх авагдсан сэжигтэн, яллагдагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхээс оргон зайлах, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүхээс дуудсан цагт ирэхгүй байхыг хэлнэ.¹¹⁰

Оргон зайлж болох үндэслэлтэй гэдгийг тодорхой эрхэлсэн ажилгүй, эсхүл ажлаасаа гарсан, оршин суух тодорхой хаяггүй, буюу оршин суух газраа өөрчилсөн болохыг ойлгоно.¹¹¹

Яллагдагч хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаас оргон зайлсан гэж яллагдагч зориуд санаатайгаар хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагад ирэхгүй, оршин суугаа газраасаа зайлсхийж, хаа байгаа газар нь мэдэгдэхгүй байгааг хэлнэ.

Оршин суугаа тодорхой хаяггүй гэдэгт Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тодорхой нэгжид харьяалагдсан тухай баримт байхгүй, тодорхой нэг газарт байнга оршин суудаггүй, хаана оршин суудаг нь тогтоогдохгүй байгаа байдлыг хамруулна.¹¹²

Шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа гэх үндэслэлийг яллагдагчаас хэрхэн амь насанд аюул занал учруулж байгаа эсэх, биечлэн, утсан харилцаа, бичвэр цахим харилцаа, түүнийг хэрхэн яаж нотлох баримтаар тооцох, Шүүхийн ерөнхий зөвлөлийн шүүн таслах ажиллагааны тайлангаас үзэхэд Нийслэлийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 25 удаагийн үйлдлээр дээрх үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна. Харин 72 удаа буюу нийт 30 цагдан хорьсон яллагдагчийн 30 орчим хувийг эзэлж байгаа нь энэ үндэслэлээр шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсаар байгааг харуулж байна.

-Гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа гэдэг нь тухайн хэргийн яллагдагч нь өөр газар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын гэмт хэрэгт шалгагдаж байгаа, энэ талаар хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн, талаарх лавлагаа баримт, мөн өөрийнх нь өгсөн мэдүүлгэн нотлох баримтыг үндэслэж, шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч байгаа талаар практик байгууллагын мөрдөгч нар энэ чиглэлийг баримталж цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ явуулж байна.

Гэмт хэрэг үйлдэж болох үндэслэлтэй гэдгийг гүйцэтгэх ажлын мэдээ, бусад гэмт хэрэгтнүүдтэй тогтоосон холбоо сүлбээ, үйлдсэн гэмт хэрэгтээ гэмшихгүй байгаа байдал, дахин гэмт хэрэгт холбогдсон, урьд өмнө нь ял шийтгэгдэж байсан сэргийг тогтоосон баримт сэлт, мэдээлэл байх гэдсэн утгаар ойлгож болох юм. Тухайлбал: хохирогч, бусад сэжигтэн, гэрч нарын мэдүүлэг, архивын лавлагаа, шийтгэх тогтоол г.м баримт бичигт тусгагдсан, тогтоол, захирамжид заагдсан, бодит үндэслэлтэй байна.¹¹³

Урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй гэх үндэслэлээр цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл нь заавал мөрдөгч, прокурор, шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээнээс өөр таслан сэргийлэх арга хэмжээ авсан бөгөөд яллагдагч уг арга хэмжээг зөрчих үндэслэл бүхий нөхцөл байдал үүссэн, шүүх прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүрэлцэн ирээгүй тохиолдолд цагдан хорих үндэслэл болдог.

Сэжигтнийг баривчлах арга хэмжээ: Монгол Улсын хэмжээнд 2023 оны эхний хагас жилд шүүх 167 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 152 сэжигтнийг буюу 91.01 хувьд нь баривчлах зөвшөөрөл олгож шийдвэрлэжээ.

¹¹⁰ Жанцан.С Монгол Улсын эрүүгийн эрх зүй. УБ.,2013. 630 дэх тал

¹¹¹ Ганболд.Б. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй УБ.2008. 326 дэх тал

¹¹² Бат-Эрдэнэ.Б. Жанцан.С. Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар. УБ.2003.273 дэх тал

¹¹³ Ганболд.Б. Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй. УБ., 2008. 326 дэх тал

Баривчлах зөвшөөрөл олгосон нийт 152 хүний 72 буюу 47.4 хувийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр, 80 буюу 52.6 хувийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр тус тус олгосон байна.

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1, 14.9 дүгээр зүйлд зааснаар 2023 оны эхний хагас жилд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахтай холбоотой давхардсан тоогоор 2221 материал хүлээн авснаас шүүхээс 723 хүнийг цагдан хорих зөвшөөрөл олгож, 177 хүнийг цагдан хорихоос татгалзаж, 1321 хүний цагдан хорих хугацааг сунгаж, 129 хүнд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, 14 хүнд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож тус тус шийдвэрлэсэн байна. 115 хүнд шүүхийн шатанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан байна.¹¹⁴

Англи Улсад прокурорын институт байхгүй учир цагдаагийн оролцоотой хийгдэх эрүүгийн процессын чиг үүрэг нилээд өвөрмөц бөгөөд өргөн хүрээнд хэрэгждэг. Цагдаагийн эрх бүхий албан тушаалтан 24 цаг хүртэл баривчлах эрхтэй бөгөөд тухайн хэрэгт холбогдсон этгээдийг цаашид үргэлжлүүлэн саатуулах шаардлагатай гэж үзвэл нийтдээ 96 цаг хүртэл баривчлах арга хэмжээ авна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын Эрүүгийн процессын хуулийн 70 дугаар зүйлд дараахь үндэслэл бий болсон тохиолдолд

- Тодорхой оршин суух хаяггүй бөгөөд оргон зайлахыг оролдсон,
- Зориуд санаатай худал мэдүүлэг өгөхийг завдсан буюу худал мэдүүлсэн,
- Нотлох баримтыг устгасан буюу устгахыг оролдсон,

Цагдаагийн бүрэн эрхийн дагуух цагдан хорих арга хэмжээ нь 10 хоног байх бөгөөд түүнийг мөн хугацаагаар дахин сунгаж, шаардлагатай үед 30 хүртэл хоногоор нэмж сунгана.

Франц Улсын Эрүүгийн процессын хуулийн 52 дугаар зүйлд Эрүүгийн гэмт хэрэгт сэжиглэгдэн шалгагдаж буй хүнийг хэн гэдгийг нь олж тогтоох, биеийн байцаалтын мэдээллийн үнэн зөв байдлыг нягтлан тогтоох шаардлагаар 4 цаг хүртэл хугацаанд баривчлах арга хэмжээ авна.

Цагдаагийн офицер, комиссар зэрэг мөрдөлт явуулах эрх бүхий албан тушаалтан уг арга хэмжээг авах эрхтэй бөгөөд түүнээс дээш болон 24 цаг хүртэл баривчлах тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгээр түүний хяналтанд хэрэгжинэ.

Мөрдөн мөшгих ажиллагааг үүсгэсэн тохиолдолд 48 цаг хүртэл хугацаатайгаар баривчлах арга хэмжээ авч болно. Зохион байгуулалттай үйлдэгдсэн гэмт хэргийн хувьд 96 цаг хүртэл сунгаж баривчлах арга хэмжээ авч болно.¹¹⁵

1. Та мөрдөн шалгах байгууллагад ямар ажил албан тушаалд ажиллаж байна вэ?


18 responses



¹¹⁴ Монгол Улсын шүүхийн 2023 оны эхний хагас жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ

¹¹⁵ Баярсайхан.Д "Гадаад орнуудын эрүүгийн процесс", УБ., 2015. 127 дахь тал

2. Та цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах саналыг прокурорт хүргүүлдэг вэ?
18 responses



3. Та мөрдөн шалгах ажиллагаа явуулахдаа ЭХХШТХ-ийн 14.9 зүйлийн 1.1-1.4, дэх заасан үндэслэлээс алийг сонгож цагдан хорих таслан ...гийлэх арга хэмжээ авахыг санал гаргадаг вэ?
18 responses



4. Мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан яллагдагчийг шөнийн цагаар болон амралтын өдрөөр олж тогтоосон тохиолдолд ямар арга хэмжээ авдаг вэ?
18 responses




5. Эрэн сурвалжлагдаж байсан яллагдагчийг ажлын байранд харж хонох, түүнийг шүүгчийн захирамж гарах хүртэлх хугацаанд ямар нэгэн эрсдэл учирч байсан уу?
18 responses



6. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад танд ямар бэрхшээл тулгарч байна вэ?


18 responses



- Хуульд заасан үндэслэл, журам нь цөөхөн санагддаг.
- зарим тохиолдолд яллагдагч нарыг өмгөөлөгчөөр хангах асуудал хэцүү байдаг
- прокурор, шүүхийн цагийн хуваарь төвөгтэй байдаг
- хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлага тулгарч байна.

7. Оргон зайлсан, эрэн сурвалжлагдаж байгаа яллагдагчийг олж тогтоосон даруйд хийгдэх арга хэмжээ ямар байвал боломжтой гэж үзэж байна вэ?


18 responses



- Шууд л цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авах
- амралтын өдөр прокурор, шүүхийг тойргийн журмаар ажиллуулах,
- ажлын өдрүүдийн цагдан хорионы шүүхийн шүүгчийн цагийн хуваарийг 22 цаг болгох
- шүүх, прокурор, мөрдөгчийн хамтын ажиллагааг нэмэгдүүлэх.

8.цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахад өмгөөлөгч, прокурор, шүүхийн оролцоо мөрдөгчид хүндрэл учруулдаг уу?

18 responses



- яллагдагчийг хариуцах / мөрдөгчид даалгах/
- төлбөрийн чадваргүй яллагдагчид өмгөөлөгч сонгох асуудал
- шүүхийн бие даасан, хараат байдал нь уг арга хэмжээг удаашруулах
- ажлын ачаалал ихтэй байдгаас шалтгаалдаг.

9. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаар тулгамдаж буй асуудлын талаар саналаа үлдээнэ үү.

- Прокурорын зөвшөөрлөөр баривчлах 2-3 хоног
- Амралтын өдөр тул мөрдөгчид саад ихтэй
- Хуульд заасан үндэслэл байсан хэдий ч хүний эрхийг дээдэлж байна гэж цагдан хорьдоггүй, мөн хуулийг нэг мөр ойлгож хэрэглэж чадахгүй байна. Иймээс дагнасан шүүгчтэй болж шаардлагатай бүх тохиолдолд мэдээлэл солилцсон шийдвэрлэдэг байх,
- ЭХХШТХ-н 14.9 дүгээр зүйл нь одоогийн нийгмийн нөхцөл байдалд уялдахгүй байгаа нь
- Үндэслэл байгаа тохиолдолд мөрдөгч заавал шүүх прокурорын зөвшөөрөлгүй цагдан хорих хэрэгтэй

- Хөнгөн хэрэг дээр оргон зугтсан ч хорьдоггүй. Хөнгөн хэрэг үйлдсэн мөртлөө Мөрдөн шалгах ажиллагаанд санаатайгаар саад учруулдаг тохиолдол их байна. Угаасаа Хөнгөн хэрэгт хорьж шалгана гэж байхгүй гээд дураараа алга болдог, санаатайгаар хайхрамжгүй ханддаг. Энэ нь мөрдөн шалгах ажиллагааг удаашруулдаг, хүчгүй болгодог.
- Шөнийн цагаар олж авчирсан тохиолдолд шуурхай таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилдөг болох, хөнгөн хэрэгт цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг байх хуулийн зохицуулалт хийх.
- Хүндрэлгүй шууд хоридог байх, нэг хүн хорих гэж мөрдөгч бараг ядаргааны стресс орж байна, тэрний оронд хориогүй байсан нь бидэнд амар байна ядаргаанд орж биегүй болж байснаас орговол оргоно л биз
- Амралтын өдрүүд буюу 5 дахь хагас сайн бүтэн сайнд шүүхийн зөвшөөрөлгүй баривчлахад хүндрэлтэй байдаг.
- Хойшлуулшгүй тохиолдолд 48 цаг саатуулахад 102-ын прокурорт танилцуулах нь хэцүү хүндрэлтэй байдаг. Мөн цагдан хорих шүүгчийн захирамж гарсан байхад 461 дүгээр ангид биеийн байдал өвддөг үзүүлж эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүл, үгүй бол авахгүй гэж хүндрэл учруулдаг, бөөстэй байна авахгүй гэх мэт

Дүгнэлт

Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхэнд халддаг хэдий ч гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, хуулиар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, яллагдагчийг дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хохирогчид учруулсан хохирлыг хэр хэмжээг багасгах, мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлах боломжийг хязгаарлах, хүний эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаас гадна нөгөө талаас эрүүгийн процессын ажиллагааг хэрэгжүүлэгч оролцогч мөрдөгчийн аюулгүй байдлыг хангах, ажил хийх нөхцөлийг нь бүрдүүлэх, эрх ашиг сонирхол нь зөрчигдсөн этгээдийн амь нас эрүүл, мэндийг хамгаалах, прокурор, шүүх нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг цаг алдалгүй, шуурхай бүрэн бодитой явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж өгөх хэрэгцээ, шаардлагатай байна.

Санал

- Практик байгууллагын мөрдөгч нарт тулгарч буй хүндрэл бэрхшээл мөрдөн байцаалтын шатанд хувийн баталгаа авах таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан яллагдагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлж, улмаар эрэн сурвалжлах ажиллагаа явуулж, амралтын өдөр болон ажлын бус шөнийн цагаар олж тогтооход түүнийг шууд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах боломжгүй тохиолдолд мөрдөгч нар тухайн хэргийн яллагдагчийг өрөөндөө хонуулж өөрийн болон бусдын амь насанд халдах эрсдэл үүсгэх нэг шалтгаан болж байгаа бөгөөд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан “Хууль бусаар баривчлах саатуулах” гэмт хэрэгт холбогдон шалгагдах боломжтой нөхцөл байдал үүсч байна.
- Шүүхээс цагдан сэргийлэх таслан сэргийлэх арга хэмжээ авахдаа хэрэг бүртгэлтийн хэргийн шатанд оргон зайлсан үндэслэл байсан бол түүнийг харгалзан үзэх, өөрөөр хэлбэл Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэдэг нь “хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, түүнд прокурор хяналт тавих, яллагдагчийг шүүхэд шилжүүлэх, эрүүгийн хэргийг анхан шатны, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх ажиллагааг” хэлнэ гэж заасан нь мөрдөн байцаалтын аль ч үе шатанд оргон зайлсан үндэслэл тогтоогдсон даруйд хэрэг бүртгэлтийн хэргийн шатанд дээрх үндэслэл байсан уу үгүй юу гэдгийг давхар тогтоогдох шаардлагатай гэсэн үг.

- Эрүүгийн процессын ажиллагааг хэрэгжүүлэгч оролцогч буюу мөрдөгч, прокурор, шүүгч, субъектүүдийн үйлдэл оролцоо, ажил үүргийн хуваарийг жигд тэнцвэртэй болгох, өөрөөр хэлбэл оргон зайлсан яллагдагчийг олж тогтоосон даруйд харьяалах газрын шүүх, шүүгч нь тойргийн журмаар ажиллаж, цагдан хорих асуудлыг нэн даруй шийдвэрлэх нь эрүүгийн процессын ажиллагааны зорилтыг хангаж, хүний эрх, ашиг сонирхлыг хамгаалах механизм болох юм.
- ЭХХШТХ-ийн 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх хэсэг Эрүүгийн хуулийн тусгай ангид бүх насаар нь хорих ял оногдуулж болох гэмт хэрэгт заавал өмгөөлөгч оролцуулах тохиолдолд төлбөрийн чадваргүй яллагдагчийн хувьд томилолтын өмгөөлөгч сонгох авах хэрэгцээтэй үед цаг хугацаа алддаг, бөгөөд цагдан хорих шүүх хуралдааны явцад өмгөөлөгч оролцуулж явуулах нь хуулийн заалтыг нэг мөр хэрэглэх, яллагдагчийн эрх зүйн байдлыг дээрдүүлж, цагдан хорих шүүх хурал явуулахад шүүхийн шатанд өмгөөлөгч сонгон авах боломж нөхцөлийг бүрдүүлэх.
- Мөрдөгч нараас судалгаа авсан дүнгээс үзэхэд мөрдөн байцаалтын шатнаас оргон зайлсан яллагдагчийг амралтын өдөр болон ажлын бус цагаар олж тогтоосон даруйд “мөрдөгч өөрөө ажлын байран дээрээ яллагдагчийг хариуцан хонодог” гэж судалгаанд оролцогчдын 88.9 хувь нь үзсэн байгаа нь мөрдөгчид эрсдэл учрах аюул занал байгааг харуулж байна.

Ашигласан материал

1. Сурах бичиг, гарын авлага

- Жанцан.С. “Монгол Улсын эрүүгийн эрх зүй”. УБ.2013
- Ганболд.Б. “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүй”. УБ., 2017.
- Нямбаатар.Х. Оюунчимэг.Т.”Эрүүгийн хэрэг шалгаж шийдвэрлэх ажиллагаа”
- Лхагварагчаа.Б, Эрдэнэбаатар.П нар. “Эрүүгийн процессын эрх зүй”. /сурах бичиг/. УБ., 2021.
- Гантулга.Н. “Хүний эрх ба хорих ял”. УБ., 2008
- Бат-Эрдэнэ.Б. Жанцан.С. “Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбар”. УБ., 2002

2. Цахим эх сурвалж

<https://mongoltoli.mn>

<https://shuukh.mn>

**ЭРХ МЭДЭЛ, АЛБАН ТУШААЛЫН БАЙДЛАА УРВУУЛАН АШИГЛАХ
ГЭМТ ХЭРГИЙГ НОТЛОХ АЖИЛЛАГААНД УЧИРЧ БУЙ ХҮНДРЭЛ, ТҮҮНЭЭС
ГАРАХ АРГА ЗАМЫН ТАЛААР ЯВУУЛСАН СУДАЛГААНЫ ҮР ДҮН**

ABUSE OF AUTHORITY AND OFFICE DIFFICULTIES CAUSED BY CRIMINAL
PROVING AND RESEARCH ON WAYS OUT OF THEM AND ITS RESULTS

Б.Ганхуяа
ДХИС-ийн докторант

Товч агуулга: Энэхүү судалгаагаар эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг нотлох ажиллагаанд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилгоор практик ажилтнуудаас авсан санал асуулгын үр дүнг танилцуулна.

Abstract: This study summarizes the opinions of practical staff about the problems and solutions to the problem of proving the crime of abuse of power and position.

Түлхүүр үгс: Оролцогчид, хүндрэл бэрхшээл, шийдвэрлэх арга зам.

Key words: Participants, difficulties, solutions.

Аливаа хэргийг мөрдөн шалгах, шүүхээр хянан хэлэлцэж шийдвэрлэх ажиллагаа нь болсон үйл явдал бүрийн сэдэл, шалтгаан, бодит байдал, түүний явц, хор уршиг бүрийг нэг бүрчлэн бүх талаас нь хангалттай нотлох баримтуудаар нотлох, уг ажиллагаа хууль ёсны байх, гэм буруутай эсэхийг гагцхүү шүүх тогтоох зарчим дээр үндэслэн явагддаг төдийгүй олон хүний хүч хөдөлмөр шингэсэн, олон хоног сарыг хамарсан, олон талын мэдлэг, туршлага, бүтээлч сэтгэлгээ, нягт нямбай ажиллагааны үр дүнд бий болдог.

Улсын хэмжээнд эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг мөрдөн шалгаж, хянан шийдвэрлэх эрх бүхий субъектүүдийн дунд энэ төрлийн гэмт хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхэд учирч буй хүндрэл бэрхшээлийг тодруулах, тэдний санал сэтгэгдлийг сонсох үүднээс судалгаа явуулав. Судалгаанд мөрдөгч, прокурор, шүүгч нийлсэн нийт 186 хүн оролцсон. Судалгаанд оролцогсдын 61,3%-ийг прокурор, 22,5%-ийг мөрдөгчид, 16,2%-ийг шүүгчид бүрдүүлж байна. Насны хувьд 25-30 насны 31, 30-35 насны 43, 35-40 насны 47, 40-45 насны 37, 45-50 насны 28 буюу 83,3 хувь нь нас тогтсон аливаа зүйлийн учрыг тунгаан бодож, дүгнэх чадвар суусан насныхан байна.

Судалгааны асуултад хариулсан байдал:

1. Авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах, шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлийг дурдана уу? гэсэн асуултад:

1. Эрх зүйн зохицуулалт боловсронгуй бус гэж 114 оролцогч буюу 61.3%;
2. Ажлын ачаалал их 80 буюу 43%;
3. Ажиллах боломж нөхцөл бүрэн хангагдаагүй /өрөө тасалгаа, техник хэрэгсэл/ гэж 11 буюу 6% оролцогч;
4. Эрх мэдэл бүхий албан тушаалтнаас ирэх дарамт их гэж 23 буюу 12.3% оролцогч

2. Эрх зүйн зохицуулалтаас хамгийн их хүндрэл учруулдаг хэм хэмжээ аль нь вэ? гэсэн асуултад:

1. Эрүүгийн хуулийн тодорхойгүй ерөнхий заалт, хуулиудын уялдаа холбоогүй байдал гэж 69 буюу 37% нь үзсэн бол,
2. ЭХХШт хуулийн зөвшөөрлийн хэм хэмжээ агуулсан болон хөөн хэлэлцэх хугацааны талаарх заалтууд гэж оролцогчдын 61 буюу 33% нь;
3. ЭХХШ ажиллагаа хэрэгжүүлэгч байгууллагын дотоод дүрэм, журам гэж 25 буюу 13% ;
4. Хариулж мэдэхгүй байна гэж 21 буюу 11.3% нь хариулжээ.

3. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг нотлоход учирч буй хүндрэл бэрхшээлийн талаар дурдана уу? гэсэн асуулгад:

1. Эрүүгийн хуулийн зарим зүйл заалт ойлгомжгүйгээс хэрэгжүүлэхэд хүндрэл учирдаг тухайлбал, нийтийн албан тушаалтан, төрийн албан тушаалтан гэх тодорхойлолт хуулиудад өөр өөр томъёолсон нь алийг нь баримтлах нь тодорхойгүй, бусад гэмт хэрэг болон зөрчлөөс ялгахад хүндрэлтэй,
2. Авлига, албан тушаалын гэмт хэргийн талаарх ойлголтын зөрүүтэй байдал нь ялангуяа шүүгч нарын гаргаж буй шийдвэрт нөлөөлдөг,
3. Шууд нотлох баримтаас гадна дамжмал нотлох баримтыг давхар шаарддаг нь цаг хугацаа алдах, хэргийн хугацаанд нөлөөлдөг,
4. Мөрдөн шалгах байгууллагын эрх хэмжээг хязгаарласан нь хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагааны явц, үр дүнд шууд нөлөөлөх болсон;
5. ЭХХШт хуулийн хамтран оролцогчоор тогтоох тухай заалтад албан тушаалтныг хамруулах зохицуулалт байхгүй нь гэмт хэргийг шуурхай мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх боломжийг алдагдуулдаг;
6. Үндсэн хуульд хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байх заалт хэрэгждэггүй. Тухайлбал, ЭХХШ ажиллагааны оролцогчийг дуудсан хугацаанд ирээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын хэм хэмжээ заагаагүйгээс оролцогчдын дийлэнх нь дуудсан цагт ирдэггүй;
7. Дотоодын шинжилгээний байгууллагуудын төрөл зүйл, хүчин чадал бага, шинжилгээ хийлгэхэд хугацаа их ордог, хүлээлт үүсгэдэг нь хэргийн хугацаанд нөлөөлдөг;
8. Төрийн албан тушаалтны үйл ажиллагааг зохицуулсан ажлын байрны тодорхойлолт хэт ерөнхий, гүйцэтгэх ажил тодорхойгүй, уялдаа холбоогүй нь албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх үндэслэл болж чаддаггүй;
9. Олон улсын хэмжээнд харилцан ажиллагаа хангалтгүй, ихэнх улс орон явуулсан бичигт хариу ирүүлдэггүйгээс энэ хугацаанд хэрэг шалгах ажиллагаанд гадны нөлөөлөл бий болох нөхцөл үүсдэг.

Дотоод нөхцөл байдлын талаар:

- ЭХХШ ажиллагаа хэрэгжүүлэгчдийн эрх зүйн мэдлэг /нотлох баримт, зүйлчлэлийн талаарх/ чадвар муу, эдийн засаг, санхүүгийн болон орчин үеийн техник технологи ашиглах хэрэглэх чадвар дутмаг;
- Ажлын ачаалал их, боловсон хүчний тоо цөөн;
- ЭХХШ ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангалтгүй;
- Эдгээр байгууллагын дотоод дүрэм, журам боловсронгуй бус зэрэг нь хэргийг шуурхай, бүрэн дүүрэн шалгах, хянан шийдвэрлэх боломжгүй байдалд хүргэдэг бол, боловсон хүчний тоо цөөн байгаа нь иргэдийн гомдол мэдээлэлд бүрэн хүрч ажиллах боломжгүй байдал үүсдэг байна.

5. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааг сайжруулахын тулд ямар зүйл хийх шаардлагатай вэ? гэсэн асуултад хариулсан байдлыг багцлан авч үзвэл,

Эрх зүйн зохицуулалтын тухайд: Хуулийн нэр томъёог оновчтой тодорхойлох, тухайлбал, нийтийн болон төрийн албан тушаалтны талаар, мөрдөгчид хэргийг бие даан шалгах бүрэн эрхийг олгох, зөвшөөрлийн болон ТСАХ болон баривчлах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хуулийн зарим зохицуулалтыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх, авлигын гэмт хэргүүдэд оногдуулах ялын бодлогыг чангатгах саналуудыг дэвшүүлсэн,

Хууль хэрэгжүүлэх талаар: Нотлох үйл ажиллагааг цаасан дээр бэхжүүлэхтэй холбоотойгоор цаг хугацаа их алдагдах байдлыг засах зарим зүйлийг

цахимжуулах, Тухайлбал, мөрдөгч аливаа арга хэмжээ зохион байгуулахдаа санал гаргадаг болсонтой холбоотойгоор прокурор зөвшөөрөл өгөхдөө тухайн ажиллагааг явуулахыг зөвшөөрснөө баталгаажуулж тусгайлсан бланк шийдвэрээ бичиж өгдөг. Энэ нь мөрдөгч, прокурор 2-ын аль алиных цаг хугацааг алдагдуулдаг.

Тиймээс мөрдөгч тухайн тодорхой ажиллагаа явуулах тогтоол бичээд прокурор нь чиг үүргийн дагуу хянаад хуульд нийцэж байвал тогтоолд гарын үсэг зуран баталгаажуулдаг байх эсхүл энэ ажиллагааг цахимжуулах, арилжааны банкнуудтай харилцан ажиллагааг боловсронгуй шуурхай болгох зохицуулалт хийх, авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх, прокурортой болгох, санхүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулах эрх бүхий эрх бүхий ажилтан, санхүүгийн шинжээч нарыг мэргэшүүлэх,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэрэгжүүлэгчид өөрсдийн талаар: Ажлын ачааллыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоох, хүний нөөцийг нэмэгдүүлэх, шүүгч, прокурор, мөрдөгчийн эрх зүйн мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, хууль хэрэглээний зөрүүтэй байдлыг арилгах буюу нэгдсэн ойлголт бий болгох, чадавхжуулах, авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах ур чадварыг дээшлүүлэх, өмгөөлөгч нарын ёс зүйн хариуцлагын талаар мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах шаардлагатай гэж үзжээ.

Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг нотлох ажиллагаанд Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн хийдэл, эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй орнуудтай харилцах гэхчлэн олон хүндрэл бэрхшээл байгаагийн зэрэгцээ төрийн албан тушаалтнуудын эрх зүйн байдлыг тодорхойлсон тушаал, заавар, журмууд ч ерөнхий байдлаар боловсруулагдсан нь мөн л хүндрэл бэрхшээлийг дагуулж байна гэж үзжээ.

Эдгээр хүндрэлийг даван туулах арга замыг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- 1) Эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож хуулиудын уялдаа холбоог сайжруулах,
- 2) Хуулийн зарим зохицуулалтыг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэх,
- 3) Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй орнуудтай гэрээ байгуулах,
- 4) Ажлын ачааллыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тогтоох, хүний нөөцийг нэмэгдүүлэх,
- 5) Авлигын гэмт хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүх, прокурорыг бий болгох.

MONEY LAUNDERING THROUGH CRYPTOCURRENCIES

Lkhagvatsend Tserensuren

Postgraduate student of the Criminal Law, Criminal Procedure and Criminalistics

Department of RUDN University

Abstract. The article discusses the problem of cryptocurrency regulation in the aspect of money laundering. In order to counteract the laundering of criminally obtained funds and the financing of terrorism, it is necessary to amend the relevant laws regulating transactions involving cryptocurrencies.

Keywords. Blockchain, crypto-currencies, crypto-economics, regulation, FATF.

Digital currency or digital money is defined as means of payment or exchange that occurs in electronic form, with transactions recorded electronically. The features of digital currency are similar to traditional currencies in that they can be used for payments when buying or selling physical goods and services, transferred across locations and stored in wallets or accounts. According to the classification of the Financial Crimes Enforcement Network (FinCEN), digital currencies are divided into two broad categories – virtual currencies and cryptocurrencies.

Virtual currencies are defined as digital representations of unregulated money that are not issued by a central authority and are not associated with a “fixed currency” (currency set by government regulations) and which are used and accepted among members of specific groups. Examples of virtual currencies are loyalty points, Facebook credits, coins Amazon or frequent flyer program points. Cryptocurrencies are a class of digital money that uses cryptography as means of protecting money interactions and monitoring the generation of cryptocurrency units. Some of the widely used cryptocurrencies are Bitcoin, Ethereum and Litecoin.

Money laundering using cryptocurrencies follows the general scheme of placement-leaking-integration, but with some special features:

Cryptocurrencies have been anonymous since their creation, so there is often no placement stage in the money laundering process.

Creating an account (“address”) takes only a few seconds, and it’s free. You can use each account only twice: to receive money, and then transfer it somewhere else.

There is a possibility of creating large-scale money laundering schemes with thousands of transfers at a low price and its implementation using a computer script.

Due to the rapid growth of exchange rates, when some cryptocurrencies show an increase of 10,000%, it is very easy to explain the unexpected enrichment due to cryptocurrencies.

To eliminate these risks, UNODC is implementing a project on cryptocurrency and money laundering.

Many jurisdictions currently already allow the use of virtual assets as means of settlement, an investment attraction tool, as well as for other purposes. So, the state of California in the USA was the first to legalize the use of cryptocurrency back in 2015. In Washington state, cryptocurrency is recognized as an object of money transfers, which implies the possibility of a company to carry out activities to transfer units of cryptocurrency only after obtaining a license from a transfer operator money. Since 2014, cryptocurrency

exchanges in Canada have been subject to registration with the relevant financial supervisory authority. Other states are also currently forming legislation regulating the market for the circulation of digital financial assets.¹¹⁶

The largest case of money laundering using the Internet in history is the activity of Liberty Reserve, which provided illegal money transfer and legalization services. During the criminal investigation, it was found out that about \$6 billion of proceeds from crime had been legalized.

One example is an investigation conducted in coordination with the investigative authorities of 20 countries, through which the creators and participants of the Darkode forum were arrested, through which illegal goods and services were traded using cryptocurrency.

There is also evidence that some terrorist groups use popular cryptocurrencies to disguise transactions. Thus, the established international practice indicates the need to develop such legal regulation that can prevent the laundering of criminally obtained funds using digital assets both at the national and international levels.

Currently, legislation on the regulation of digital financial assets in the Russian Federation is in its infancy. At the same time, attempts to regulate or set the direction for a rapidly developing new financial market have been made by both executive authorities and judicial acts of interpretation.

February 26, 2019 The Plenum of the Supreme Court of the Russian Federation adopted Resolution No. 1, according to which amendments were made to the Resolution of the Plenum of the Supreme Court of the Russian Federation dated July 7, 2015 No. 32 "On judicial practice in cases of legalization (laundering) of funds or other property acquired by criminal means, and on the acquisition or sale of property knowingly obtained by criminal means." Now, the subject of a group of crimes related to the legalization (laundering) of criminally obtained funds will also be funds converted from virtual assets (cryptocurrencies) acquired as a result of the commission of a crime.

Since June 19, 2003, the Russian Federation has been a member of the Financial Action Task Force on Money Laundering (FATF). Since February 2012, 40 FATF Recommendations have come into effect,¹¹ which are being consistently implemented in Russia. In particular, according to the Recommendations, financial institutions are prohibited from maintaining anonymous accounts or accounts opened in fictitious names. Financial institutions should take measures to properly verify identity and business relations of clients. An important provision is also the obligation of financial institutions to store transaction data for at least five years in order to ensure the ability to respond promptly to requests from competent authorities. It is also worth noting that, in accordance with the Recommendations of the participating countries, it is necessary to take measures aimed at licensing individuals and legal entities providing services for the transfer of funds or valuables, ensuring effective monitoring of their activities for compliance with legislation on countering the legalization of funds obtained by criminal means. The Recommendations also contain provisions according to which participating countries should identify and assess the risks of money laundering or terrorist financing that may arise in connection with the development of new technologies and products, as well as norms according to which countries need to ensure that financial institutions record accurate information about the sender and the necessary information

¹¹⁶ Virtual Currency Regulation. Washington State Department of Financial Institutions, 2014. URL: <https://www.irs.gov/newsroom/irs-virtual-currency-guidance> (accessed: 21.08.2023).

about the recipient in an electronic transfer and accompanying messages throughout the payment chain.

At the same time, the Recommendations rightly contain provisions (F) on regulation and supervision of financial institutions. In particular, financial institutions should undergo licensing or registration procedures, and their activities should be properly regulated and supervised or controlled, taking into account the risk of money laundering or terrorist financing in this sector.

The legislator's desire to counteract the legalization of proceeds from crime by forming a layer of legal norms regulating the digital financial assets market, as well as the issuance by the highest judicial authorities of relevant acts of interpretation, should certainly be evaluated positively. At the same time, regulatory provisions should be implemented in practice, because only in this case can we talk about the effectiveness of legal regulation.

Thus, summing up, we can conclude that the emerging market for the circulation of digital financial assets undoubtedly requires thorough legal regulation, because the long-term lack of legal regulation results in an increase in violations of the rights and legitimate interests of both individuals and public interests as a whole. The Russian Federation, as a member of the Financial Action Task Force on Money Laundering (FATF), is actively implementing the norms of the 40 FATF Recommendations on Countering the legalization of Proceeds from Crime and the financing of terrorism in draft laws, which will reduce criminal risks in the digital asset market in the future.

At the same time, the anti-money laundering regulations included in the draft laws on the circulation of digital financial assets should be implemented in practice, which requires careful study of the technological aspects of their implementation.

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ХОРИХООС ӨӨР ТӨРЛИЙН ЯЛААС ЗАЙЛСХИЙСЭН ЯЛТАНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

EGAL LIABILITY IMPOSED ON CONVICTS WHO EVADE PUNISHMENT IN THE
FORM OF PUNISHMENT OTHER THAN IMPRISONMENT

Я.Батгэрэл

*ДХИС-ийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
албаны сургуулийн Иргэний шийдвэр гүйцэтгэлийн
тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа*

Товч агуулга: Монгол Улсад өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хорих ялын үр нөлөө хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрч аль болох хорихоос өөр төрлийн ялыг сонгож, гэмт хэргийн шинж байдлаас шалтгаалан ялгамжтай оногдуулах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг гэр бүл, нийгэм, хамт олны дунд байлгаж, гэмт хэргийн нийгмийн хор аюулыг ухамсарлуулахад чиглэсэн ялын бодлогыг хуульчлан баталгаажуулсан билээ.

Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт, ял эдлэхээс зайлсхийсэн ялтны эдлээгүй үлдсэн ялыг хорих ялаар сольсон талаарх судалгааг хийж, ял эдлэхээс зайлсхийсэн ялтанд хүлээлгэх хариуцлагын эрх зүйн зохицуулалт, хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлыг нээн илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлохыг зорилоо.

Abstract: In the framework of the legal reforms in Mongolia, recognizing that the effectiveness of prison sentences is not very high, choosing punishments other than imprisonment as much as possible, imposing different punishments depending on the nature of the crime, keeping the person who committed the crime in his family and society, and reducing the social danger of crime. sentencing policy aimed at raising awareness has been legalized.

The aim is to investigate the implementation of other types of punishments, conduct research on the person who avoids serving the sentence and replaces the remaining sentence with imprisonment, and aims to identify the problems in the legal regulation and implementation of the responsibility of the person who avoids serving the sentence, and to determine the solution.

Түлхүүр үгс: Эрүүгийн хариуцлага, ял шийтгэл, ял эдлэхээс зайлсхийх, зөрчил гаргах, хариуцлага тооцох, ял солих, оргон зайлах, эрэн сурвалжлах.

Keywords: Criminal liability, punishment, avoid conviction, commit a violation, to punish, change of sentence, escape, to search, investigate

Хорихоос өөр төрлийн ял

Эрүүгийн хариуцлага гэж гэмт хэргийн бүх шинжийг агуулсан үйлдэл, эс үйлдэхүй хийж, гэм буруутай нь шүүхээр тогтоогдсон этгээдийн эрх зүйн байдалд хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын онцгой арга хэмжээ юм.¹¹⁷ Эрүүгийн хариуцлага нь Эрүүгийн хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ. Ял нь төрийн эрүүгийн бодлогыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн, Эрүүгийн хуульд заасан төрийн албадлагын хүчтэй хэрэгсэл юм.¹¹⁸

¹¹⁷ Гантөмөр, Г, Гантулга С. нар. Эрүүгийн эрх зүй ерөнхий анги. –Уб., 2020. 357 дахь тал

¹¹⁸ Жанцан, С. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. –Уб., 2014. 124 дэх тал

Эрүүгийн хууль¹¹⁹-д эрүүгийн хариуцлагын зорилгыг “Гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино” хэмээн тодорхойлж, “Эрүүгийн хариуцлага нь мөн хуульд заасан ял, албадлагын арга хэмжээнээс бүрдэнэ” хэмээн хуульчилжээ.

Эрүүгийн хуульд өсвөр насны хүнд оногдуулах ял, албадлагын арга хэмжээг тодорхойлж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ¹²⁰ нэмж хэрэглэж болохоор, хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэж, торгох ял оногдуулж, шаардлагатай гэж үзвэл эрх хасах албадлагын арга хэмжээ, татан буулгах албадлагын арга хэмжээ, хуулийн этгээдийн хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээ авахаар заасан.

Эрүүгийн хуульд гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ялын төрлийг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

1. Торгох ял;
2. Нийтэд тустай ажил хийлгэх ял;
3. Зорчих эрхийг хязгаарлах ял;
4. Хорих ял;
5. Эрх хасах ял.

Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, хорих ялыг үндсэн, эрх хасах ялыг нэмэгдэл ялаар хэрэглэнэ.¹²¹

Дэлхийн зарим улсын эрх зүйн практикт гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгмээс тусгаарлахгүйгээр хяналт, хязгаарлалт тогтоох замаар ял эдлүүлэх нь хамгийн түрүүнд сонгон хэрэглэвэл зохих ял шийтгэлийн үндсэн хэлбэр гэж үзэж байгаа бөгөөд хорих ялыг зөвхөн хохирогчийн аюулгүй байдалд заналхийлсэн, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн зэрэг цөөн тооны тохиолдолд хэрэглэх учиртай гэсэн үзэл, зарчим давамгайлж байна.¹²² Дэлхийн улсууд гэмт этгээдэд хорих ял оногдуулахаас аль болох татгалзаж, хорихоос өөр төрлийн ялыг ихэвчлэн оногдуулах болжээ.

НҮБ-аас 1990 онд “Хорихоос өөр төрлийн ялыг оноох, хэрэглэх наад захын жишиг дүрэм”-ийг баталсан. Үүнийг Токиогийн дүрэм гэж нэрлэдэг. Энэхүү дүрмийн дагуу ялтны эрхийг хамгаалж, эрх зүйн тодорхой зохицуулалтын дагуу хорихоос өөр төрлийн ялыг зохих ёсоор хэрэглэх, ялтан аль ч шатанд өөрийн эрхээ зөрчигдсөн гэж үзвэл албан ёсны тогтолцооны дагуу гомдол гаргах эрх зүйн баталгааг олгосон.

Токиогийн дүрэмд “Гишүүн орнууд нь хорих ялыг хэрэглэх явдлыг багасгах замаар бусад боломжийг хангах, эрхийн зөрчил гаргагчийг нийгэмд хэвийн амьдралд эргэж орох хэрэгцээ, нийгмийн шударга ёсны шаардлага, хүний эрхийг хангах зайлшгүй шаардлагыг харгалзан эрүүгийн байцаан шийтгэх салбар дахь бодлогыг

¹¹⁹ Эрүүгийн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. -УБ., 2016 он. №07

¹²⁰ Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ: Эрүүгийн хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор мөн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргийг хүлээлгэнэ.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садангийн хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно.

¹²¹ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл №07.

¹²² Алтангэрэл, Б. нар. Пробацийн үйл ажиллагаа: Эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судлал. Судалгааны тайлан. -УБ., 2019. 9 дэх тал.

оновчтой болгох зорилгоор өөрийн эрх зүйн системийн хүрээнд хорихоос өөр төрлийн арга хэмжээг боловсруулна¹²³ хэмээн заасан байдаг.

Хорихоос өөр төрлийн ялыг “Гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхийн тулд юуны өмнө ял шийтгэлийн хэлбэрийг боловсронгуй болгох шаардлагатай. Учир нь өнөөг хүртэл гэмт хэрэг үйлдсэн хүнийг залхаан цээрлүүлэх, тарчлаан зовоох хэлбэрийн арга барил хууль сахиулах болон шүүхийн практикт бат бөх оршсоор байна. Иймд олон нийтийн зүгээс өнөөдөр эрүүгийн ял шийтгэлийн бодлогыг илүү хүнлэг, энэрэнгүй, ардчилсан хэлбэрт шилжүүлэх арга замыг тууштай эрэлхийлж эхэлсэн. Эдгээр арга замын нэг нь нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл буюу хорихоос өөр төрлийн ял юм”¹²⁴ гэж тодорхойлоод “дэлхийн улсуудад хэрэглэгдэж буй нийгэм-олон нийтэд суурилсан ял нь тухайн улсын ялын бодлого, эрүүгийн эрх зүйн зохицуулалт, түүнчлэн хүн ам, нийгэм эдийн засгийн үзүүлэлт, ажил хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээл болон нийгмийн халамжийн бодлого зэргээс хамааран харилцан адилгүй нэршил бүхий төрөл хэлбэрээр хэрэгжиж байгаа ч нийтлэг байдлаар дараах тогтолцооны идэвхтэй хэлбэрүүд үйлчилж байна”¹²⁵ гэж үзсэн байдаг. Үүнд:

- Цалин хөлсгүй ажил;
- Түр баривчилгаа;
- Хөл хорио тогтоох;
- Эрх хасах;
- Цахим хяналтын хэрэгсэл зүүх;
- Албадан эмчилгээ, хөтөлбөрт хамруулах;
- Хохирогчоос уучлалт гуйлгах;
- Эвлэрүүлэн зуучлах;
- Шүүхийн тусгайлсан захирамж, /архи согтууруулах ундаа хэрэглэх, зарим хүмүүстэй уулзахыг хориглох г.м/;
- Тодорхой төрлийн алба хаагчийн тогтмол хяналтад байлгах;
- Бие мах бодийн шийтгэл гэсэн хэлбэрүүд үйлчилж байна.

Манай орны хувьд Монгол Улсын Их хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр Эрүүгийн хуулийг шинэчилсэн найруулгыг батлан, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөж байна. Эрүүгийн хуульд хорихоос өөр төрлийн ялын төрлийг торгох ял, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ял, эрх хасах ял гэсэн 4 төрөлтэй байхаар хуульчилсан.

Торгох ял: Гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хуулийн тусгай ангид заасан торгуулийн нэгжтэй тэнцүү хэмжээгээр мөнгөн төлбөр оногдуулахыг торгох ял гэнэ¹²⁶. Торгох ялын хэмжээ нь дөрвөн зуун тавин нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байх бөгөөд нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна.

Шүүх ялтны хөрөнгө, цалин хөлс, бусад орлого олох боломжийг харгалзан торгох ялыг гурван жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлөхөөр тогтоож болно. Ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

Эрүүгийн хуульд заасан тохиолдолд арван мянган нэгжээс дөрвөн зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр хуулийн этгээдэд торгох ял оногдуулна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял: Гэмт хэрэг үйлдсэн хүнийг шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр хийлгэхийг

¹²³ Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм. 1.5 дахь заалт. Ерөнхий Ассемблейн 1990 оны 10-р сарын 14-ний 45/110-р тогтоолоор батлагдсан.

¹²⁴ Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. -Уб., 2018. 14 дэх тал

¹²⁵ Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. -Уб., 2018. 21 дэх тал

¹²⁶ Эрүүгийн хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07

нийтэд тустай ажил хийлгэх ял гэнэ.¹²⁷ Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт наймаас дээшгүй цагаар, нийт хоёр зуун дөчөөс долоон зуун хорин цагаар тогтооно.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулна. Шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно. Шүүх нийтэд тустай ажил хийлгэх ял дээр нэмж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүнд, биеийн эрүүл мэндэд шууд нөлөөлөхүйц нийтэд тустай ажил хийлгэх ялыг жирэмсэн эмэгтэй, тавин таваас дээш насны эмэгтэй, жараас дээш насны эрэгтэй хүнд оногдуулахгүй.

Ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

Зорчих эрхийг хязгаарлах ял: Гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад өөрийн оршин суух газраас явахыг хориглох, тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгөөр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг зорчих эрхийг хязгаарлах ял гэнэ.¹²⁸

Шүүх тухайн гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан ялтныг бусдад аюул учруулах эрсдэлтэй гэж үзвэл тодорхой хүнтэй, бусадтай харилцахыг хориглож болно.

Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино.

Шүүх эрүүгийн хуулийн тусгай ангид зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд мөн хуулийн 5.5 дугаар зүйлд заасан журмаар тусгай ангид заасан зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулж эдлэх ялыг хоёр дахин багасгана.

Эрх хасах ял: Гэмт хэрэг үйлдсэн хүний нийтийн албанд ажиллах, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг нэг жилээс найман жил хүртэл, эсхүл эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд нийтийн албанд ажиллах эрхийг бүх насаар хориглохыг эрх хасах ял гэнэ.¹²⁹

Шүүх гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно. Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах ялыг заавал оногдуулна. Шүүх эрх хасах ялыг хорих ял дээр нэмж оногдуулсан бол уг ялыг эдэлж дууссаны дараа, эсхүл торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял дээр нэмж оногдуулсан бол ял оногдуулсан үеэс, эсхүл хорих ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол албадлагын арга хэмжээ авсан үеэс хугацааг тоолно.

Гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдлыг харгалзан шүүх эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг хүүхдийн эсрэг, эсхүл 16 дугаар бүлэгт заасан гэмт хэргийг үйлдсэн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид оногдуулсан үндсэн ял дээр нэмж эрх хасах ялыг оногдуулж болно.

¹²⁷ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07

¹²⁸ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07

¹²⁹ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07

Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт


Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа нь эрүүгийн хэргийн талаарх шүүхийн шийтгэх тогтоолыг гүйцэтгэх ажиллагааны дагуу явагдах бөгөөд энэ төрлийн харилцааг 1995 оноос анх удаа “Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг хэрэгжүүлэх тухай” хуулиар зохицуулж эхэлсэн байна¹³⁰.

Хорихоос өөр төрлийн ялыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль¹³¹, “Хорихоос өөр төрлийн ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаанд хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх, ашиглах журам¹³²”-д заасан арга, журмын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэх бөгөөд прокурор хяналт тавина.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдийг хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн хамт хүлээж авч шүүхийн тогтоол, магадлалыг тоо бүртгэлд оруулан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэх тухай тогтоол гаргаж, ажлын 3 өдрийн дотор тойрог хариуцсан шийдвэр гүйцэтгэгчид хуваарилж, энэ тухай прокурорт мэдэгдэнэ.

Шийдвэр гүйцэтгэгч тогтоолыг хүлээн авсан даруйд ял эдлүүлэх ажиллагааг эхлүүлэх бөгөөд ялтан тус бүрд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэрэг нээж, ялтанд ял эдлүүлэх журам, эрх, үүргийг нь тайлбарлаж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна.

График 1. Хорихоос өөр төрлийн ялын хэрэгжилт:



Шүүхийн сүүлийн 7 жилийн ял оногдуулсан байдалд дүн шинжилгээ хийж үзэхэд хорих ял оногдуулах байдал 25%, хорихоос өөр төрлийн ял оногдуулах байдал 75% байна. Хорихоос өөр төрлийн ял дотроос торгох ялыг 69%, эрх хасах ялыг 8%, нийтэд тустай ажил хийлгэх ялыг 15%, зорчих эрх хязгаарлах ялыг 8%-д оногдуулсан байна.

¹³⁰ Жанцан, С. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол. -УБ., 2014. 160 дахь тал

¹³¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

¹³² Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий прокурорын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А-234/А/103 дугаар хамтарсан тушаалын хавсралт

График 2.Шүүхээс ял оногдуулсан судалгаа

График 3. Шүүхээс хорихоос өөр төрлийн ял оногдуулсан судалгаа




Судалгаанаас харахад шүүхээс хорихоос өөр төрлийн ял оногдуулахдаа торгох ялыг түлхүү оногдуулж байгааг харж болно.

Торгох ялын хэрэгжилт: Шүүхээс хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд, хугацаа тогтоогоогүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, ялтан торгох ялыг биелүүлэх үүрэгтэй. Торгуулийн ялыг биелүүлэх хугацаа дуусгавар болоход ялтан торгуулийг төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч торгуулийг төлж барагдуулаагүй шалтгаан нөхцөлийг судалж, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж болно.

Шийдвэр гүйцэтгэгч торгох ялыг төлөх хугацааг сунгахдаа ялтны саналыг харгалзан уг хугацаанд торгуулийг төлж барагдуулах хуваарь тогтооно. Ялтанд тогтоосон хугацаанд торгох ялыг биелүүлээгүй тохиолдолд торгох ялыг хорих ялаар солих тухай сануулж, тэмдэглэл үйлдэн гарын үсэг зуруулна. Сунгасан хугацаа дуусмагц торгох ялыг хорих ялаар солиулах саналаа прокурорт даруй хүргүүлнэ.

Торгох ял шийтгүүлсэн хуулийн этгээд дээрх хугацаанд шүүхээс оногдуулсан торгуулийг төлөөгүй тохиолдолд эд хөрөнгөөс албадан гаргуулна.

График 4. Торгох ялын хэрэгжилт:



Судалгаанаас харвал шүүхээс хуулийн этгээдэд торгох ял оногдуулах байдал тасралтгүй өссөн байгааг харж болно.

График 5. 2023 оны торгох ялын хэрэгжилт:



Ялтан шүүхээс оногдуулсан торгох ялыг тогтоосон хугацаанд бүрэн төлж барагдуулах үүрэгтэй бөгөөд торгуулийг бага хэмжээгээр төлсөн, шийдвэр гүйцэтгэгчийн дуудсан цагт ирсэн зэрэг нь ял эдэлж байгаа хэрэг биш бөгөөд төрийн албадлагын арга хэмжээ болох торгох ялыг ялтны хүсэл сонирхолд захирагдалгүй нэг мөр хэрэгжүүлэх нь зүйтэй.¹³³

Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт: Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд эрүүгийн хуулийг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбогдуулан нийтэд тустай ажил хийлгэх ялыг мөн энэ өдрөөс оногдуулж эхэлсэн.

Ахлах шийдвэр гүйцэтгэгч ялтныг нийтэд тустай ажил хийлгэх байгууллагыг тогтоох бөгөөд шийдвэр гүйцэтгэгч ажиллуулах байгууллагатай ялтны нэг өдөрт ажиллах цаг, гүйцэтгэх үүрэг, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа, ажлын хувцсаар хангах, ажиллах нөхцөлийг урьдчилан тохиролцож,

¹³³ Жанцан, С. Монгол улсын эрүүгийн эрх зүйн онол. -УБ., 2014. 148 дахь тал

гэрээ байгуулж шүүхийн шийдвэр, ажил хийлгүүлэх тухай мэдэгдлийн хамт ажил хийлгэхээр тогтоосон байгууллагад биечлэн хүлээлгэж өгнө.

Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилтийг ял шийтгэл гарцаагүй байх зарчмын хүрээнд бүрэн биелүүлэх шаардлага шийдвэр гүйцэтгэгч төдийгүй ял эдлүүлж байгаа байгууллагад өндрөөр тавигдах болсныг эрх зүйн зохицуулалтаас бүрэн харж болохоор байна.


Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас аймаг, нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 33 байгууллага, сум, дүүргийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд 17 байгууллага, аймаг, нийслэл, сум дүүргийн төрийн өмчит үйлдвэрийн газар, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудад ажиллуулах жагсаалтыг баталсан.

Эрүүгийн хуульд байгаа тодорхойлолтоос харахад шүүхээс тогтоосон нийтийн ашиг сонирхолд тустай ажлыг цалин хөлс олгохгүйгээр өдөрт бага цагаар удаан хугацааны турш хийлгэх нь гэмт этгээдэд үзүүлж буй ялын цээрлэл мөн юм.

Нийтэд тустай ажил хийлгэх хугацаа нь насанд хүрсэн хүнд амралтын өдөр болон үндсэн ажил, хичээлээс чөлөөтэй өдөр 4 цагаас ихгүй, ажлын өдөр ажил болон хичээлээс чөлөөтэй үед 2 цаг, эсхүл өөрөө зөвшөөрсөн тохиолдолд 8 цагаас ихгүй, 7 хоногт 10 цагаас багагүй байхаар, өсвөр насны хүнд өдөрт 3 цагаас дээшгүй хугацаагаар хийлгэхээр хуульд заажээ.

Эрүүгийн хуульд энэ төрлийн ялыг өсвөр насны хүнд оногдуулж болохоор хуульчилсан бөгөөд “гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, хүүхдийн сэтгэцийн хөгжилд харшлахгүй нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулна”¹³⁴, “шүүх өсвөр насны хүнд нийтэд тустай ажил хийлгэх ялыг өдөрт гурваас дээшгүй цагаар, нийт нэг зуун хориос гурван зуун жаран цагаар тогтооно”¹³⁵ гэж тус тус заасан байдаг.

График 6. Нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт:




Харьцуулсан судалгаанаас үзэхэд, шүүхээс энэ төрлийн ялыг жилд дунджаар 1300 орчим насанд хүрсэн хүнд оногдуулж байгаа бол өсвөр насны хүнд энэ төрлийн ял оногдуулах байдал буурсан үзүүлэлттэй байна.

¹³⁴ Эрүүгийн хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07

¹³⁵ Эрүүгийн хууль. Уб., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07

График 7. 2023 оны нийтэд тустай ажил хийлгэх ялын хэрэгжилт:



Зорчих эрхийг хязгаарлах ялын хэрэгжилт: Монгол Улсын хувьд Эрүүгийн хуульд шинээр заасан зорчих эрхийг хязгаарлах ялыг 2021 оноос хэрэгжилтийг цахим хэлбэрээр явуулах нөхцөлийг бүрдүүлсэн. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага 2021 оноос зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ ялыг хэрэгжүүлэх арга журмыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд тусгаж өгсөн бөгөөд эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, техник хяналтын ажилтан ялын биелэлтэд биечилсэн болон цахим хяналтыг тасралтгүй тавин ажиллаж байна.

Шийдвэр гүйцэтгэгч нь зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтны дэлгэрэнгүй бүртгэлийг хөтөлж, хувийн баталгаа гаргуулан авч, цахим бугуйвчийг ялтанд зүүж, техникийн зааварчилгаа өгөн, хяналтын цахим программд бүртгэж, шүүхийн шийдвэрт заасан зөвшөөрсөн болон хориглосон бүс, явах чиглэлийг тогтоож хяналтдаа авна. Зорчих эрхийг хязгаарлах ял эдлэх хугацааг цахим бугуйвч зүүсэн өдрөөс эхлэн тоолно.

График 8. Зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилт:



Мөн 2021 онд шүүхээс 6, 2022 онд 18, 2023 онд 11 өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулсан бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хүлээн авч хяналт тогтоон ажилласан байна.


График 9. 2023 оны зорчих эрх хязгаарлах ялын хэрэгжилт:



Эрх хасах ялын хэрэгжилт: Шийдвэр гүйцэтгэгч эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа үүсгэснээс хойш 5 хоногийн дотор ялтныг төрийн албанд томилсон, сонгосон, мэргэжлийн үйл ажиллагаа явуулах болон шүүхээс хориглолт, хязгаарлалт тогтоосон бусад эрх, зөвшөөрлийг олгосон байгууллага, албан тушаалтанд шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх тухай мэдэгдлийг хүргүүлнэ.

Тодорхой ажил, үйлчилгээ гүйцэтгэх, үйл ажиллагаа явуулах эрх, зөвшөөрөл олгох чиг үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан шүүхийн шийдвэр, мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор ялтанд олгосон эрх, зөвшөөрлийг хүчингүйд тооцох, энэ тухай ялтанд мэдэгдэх, мэргэжлийн үйл ажиллагаанд нь хяналт тавих, шүүхийн шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

График 10. Эрх хасах ялын хэрэгжилт:



Хорих анги эрх хасах нэмэгдэл ялаар шийтгүүлсэн хоригдлыг ялын хугацаа дуусаж суллагдахаас 7 хоногийн өмнө, бусад үндэслэлээр суллагдсан бол суллагдсанаас хойш 7 хоногийн дотор суллагдсан талаарх мэдэгдлийг шүүхийн шийдвэр, мэдэгдэх хуудасны хамт түүний оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлнэ.

График 11. 2023 оны эрх хасах ялын хэрэгжилт:



Шийдвэр гүйцэтгэгч эрх хасах ял шийтгүүлсэн ялтанд дараах байдлаар хяналтыг хэрэгжүүлж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулан ялтны хувийн хэрэгт хавсаргана.

- Эрх хасах ял шийтгүүлсэн ялантай 30 хоног тутам урьдчилан сэргийлэх ярилцлага хийж, шүүхийн шийдвэрийн биелэлтийн талаар тайлбар авч, шаардлагатай тохиолдолд ялтны ажлын байр, үйл ажиллагааг биечлэн хянаж, тэмдэглэл үйлдэх;
- Хассан эрхийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байр, барилга байгууламж, агуулах савыг битүүмжлэх;
- Эрх, зөвшөөрөл олгосныг нотлох баримт бичгийн эх хувийг хураах;
- Эрх, зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагад олгосон эрх, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай мэдэгдэл хүргүүлэх, ялтны мэргэжлийн үйл ажиллагаанд хяналт тавихыг даалгах;
- Эрх хасах ял эдэлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан хугацааг шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс, ялтан хорих ангиас суллагдсан өдрөөс эхлэн тоолно. Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх арга, хэрэгсэл нь энд зааснаар хязгаарлагдахгүй.

Хорихоос өөр төрлийн ялаас зайлсхийсэн ялтанд хүлээлгэх хариуцлага

Ял эдлүүлэх ажиллагааны буюу гүйцэтгэлийн бодлого нь ялын зорилгыг хангахад чиглэгдсэн зохион байгуулалт, эрх зүй, нийгэм хамгаалал зэрэг цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэх үзэл баримтлал юм.¹³⁶ Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино.¹³⁷

Ял шийтгүүлсэн этгээдэд тухайн ялыг бүрэн эдлүүлэх, ялтныг нийгэмшүүлэх нь ялын зорилгыг хангах үндэс болно. Иймд хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн этгээдээр ялыг бүрэн эдлүүлэх, ял эдлэхээс зайлсхийсэн тохиолдолд заавал хууль зүйн хариуцлага хүлээлгэх шаардлагатай.

Эрүүгийн хуулийн 5.3 дугаар зүйлийн 5дахь хэсэгт “ялтан торгох ялыг шүүхээс тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол шүүх биелэгдээгүй торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгийг нэг хоногоор тооцож хорих ялаар солино”, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино”, 5.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг

¹³⁶ Алтангэрэл, Б. Ялын бодлого, олон улсын чиг хандлага. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. -УБ., 2018 он

¹³⁷ Эрүүгийн хууль. УБ., 2016. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №07


биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино”, 5.6 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт “Торгох, нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн бол ял шийтгүүлсэн гэмт хэрэгт нь хорих ял оногдуулахаар заасан эсэхээс үл хамааран эдлээгүй үлдсэн ялыг энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу сольж хорих ял оногдуулна”, гэж ял эдлэхээс зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон.

Хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих: Ялтан хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солихоор заасан зөрчил гаргасан эсхүл төлбөл зохих торгуулийг хугацаанд нь бүрэн төлж барагдуулаагүй тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч зөрчил гаргасан, эсхүл торгуулийг төлж барагдуулбал зохих өдрөөс хойш 5 хоногийн дотор хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих тухай саналаа эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.

Прокурор шийдвэр гүйцэтгэгчийн саналыг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор үндэслэлийг хянаж, хорихоос өөр төрлийн ялыг хорих ялаар солих тухай дүгнэлт үйлдэн эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны хувийн хэргийн хамт шүүхэд хүргүүлж шийдвэрлүүлнэ. Шийдвэр гүйцэтгэгчийн санал нь үндэслэлгүй, шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн нь хангалттай нотлогдоогүй бол прокурор саналыг хүчингүй болгож, ажлын 3 өдрийн дотор санал гаргасан шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст буцаан хүргүүлнэ.

Торгох ял шийтгүүлсэн ялтан торгох ял оногдуулсан шийдвэрт өөрөөр заагаагүй бол тухайн шийдвэрийг хуулийн хүчин төгөлдөр болсноос хойш 90 хоногийн дотор, хэрэв хэсэгчлэн төлөхөөр тогтоосон бол тогтоосон хугацаанд биелүүлэх үүрэгтэй. Заасан хугацаа дуусгавар болоход ялтан торгуулийг төлөөгүй бол шийдвэр гүйцэтгэгч торгуулийг төлж барагдуулаагүй шалтгаан нөхцөлийг судалж, ахлах шийдвэр гүйцэтгэгчийн зөвшөөрснөөр шийдвэрийг сайн дураар биелүүлэх хугацааг 30 хүртэл хоногоор сунгаж, ялтны саналыг харгалзан уг хугацаанд торгуулийг төлж барагдуулах хуваарь тогтоож болно. Сунгасан хугацаа дуусмагц торгох ялыг хорих ялаар солиулах саналаа прокурорт даруй хүргүүлнэ.

График 12. Торгох ялыг хорих ялаар сольсон ялтны судалгаа:




Нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтан ял эдлэх явцдаа дараах зөрчлийг гаргавал нийтэд тусгай ажил хийлгэж байгаа байгууллага энэ тухай шийдвэр гүйцэтгэгчид даруй мэдэгдэх үүрэгтэй бөгөөд зөрчил үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд ялтны эдлээгүй үлдсэн нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар солино. Үүнд:

- Ялтан хуурамчаар өвдсөн,
- Эмнэлгийн магадалгаа, зохих баримтыг хуурамчаар бүрдүүлсэн,
- Бие эрхтэн, эрүүл мэнддээ санаатайгаар гэмтэл учруулсан,
- Чөлөөний баримт, материалыг хуурамчаар бүрдүүлсэн,
- Зөрчил гаргаж шийтгүүлсэн,

- Нийтэд тустай ажил хийлгэж байгаа байгууллагын дотоод журмыг зөрчсөн,
- Ял эдлүүлэх нийт хугацаанд ажлаа дур мэдэн орхисон,
- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан,
- Архи, согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ ажилд ирсэн,
- Нийтэд тустай ажил хийхтэй холбоотойгоор хөдөлмөр аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, журам, ажил олгогчоос тавьсан хууль ёсны шаардлагыг удаа дараа биелүүлээгүй.


График 13. Нийтэд тустай ажил хийлгэх ялыг хорих ялаар сольсон ялтны судалгаа:



Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтан дараах тохиолдолд эдлүүлэх журмыг ноцтой зөрчсөнд тооцдог бөгөөд зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солино. Үүнд:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан хэрэгжүүлэх үүргээ ялтан 3 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа биелүүлээгүй;
- Гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн;
- Хяналтын тоног, төхөөрөмжийг устгасан, гэмтээсэн, хэвийн ажиллагааг сарниулсан, техникийн болон биечилсэн хяналтаас 24 цагаас илүүгүй хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн зөрчлийг давтан гаргасан
- Шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан, хүч хэрэглэн эсэргүүцсэн, шийдвэр гүйцэтгэгчийн амь нас, эрүүл мэндэд хохирол учруулсан, хохирол учруулахаар заналхийлсэн;
- Техникийн, эсхүл биечилсэн хяналтаас 24 цагаас илүү хугацаагаар санаатайгаар зайлсхийсэн.

График 14.Зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар сольсон ялтны судалгаа:



Эрх хасах ял оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэхээс зайлсхийсэн ялтанд шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт байхгүй бөгөөд Зөрчлийн тухай хууль¹³⁸-д заасан хариуцлага хүлээлгэнэ. Тухайлбал, Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.27.1-д ...эрх хасах ял шийтгүүлсэн этгээд шүүхээс хүлээлгэсэн үүргийг зөрчсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно, 14 дүгээр зүйлийн 14.7.1-д ...тээврийн хэрэгсэл жолоодох эрх нь дуусгавар болсон хүн тээврийн хэрэгсэл жолоодсон бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно..., 14 дүгээр зүйлийн 14.7.1-д ...жолоодох эрх нь дуусгавар болсон хүн согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон, эсхүл зохих журмын дагуу шалгуулахаас зайлсхийсэн бол албадан сургалтад хамруулж 7-30 хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна гэж зохицуулсан байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийж, зөрчил гаргасан, оргон зайлсан, торгуулийн ял биелүүлээгүй торгох ял шийтгүүлсэн ялтны 1.2%, нийтэд тустай ажил хийлгэх ял шийтгүүлсэн ялтны 12.4%, зорчих эрхийг хязгаарлах ялаар шийтгүүлсэн ялтны 9.5%-д эрүүгийн хариуцлага хүлээлгэж хорихоос өөр төрлийн ялыг зохих хууль журмын дагуу ял хорих ялаар сольсон байна. Харин эрх хасах нэмэгдэл ял шийтгүүлсэн этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлага нь Зөрчлийн тухай хуульд заасан торгох шийтгэлээр хязгаарлагдаж байгаа нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын хэрэгжилт энэ төрлийн ялын биелэлтэд төдийлөн хангалтгүй байна гэж судлаачийн зүгээс харж байна.

Дүгнэлт

Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, хэрэгжилт, ял эдлэхээс зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцооны талаар судлан дараах дүгнэлтийг гаргаж байна.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн хүчин төгөлдөр шийдвэр биелүүлэхээс зайлсхийж, хорихоос өөр төрлийн ялаас оргон зайлсан ялтанд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авах хуулийн зохицуулалт байдаггүй, ялтан олон хоног, сар, жилээр эсхүл удаа дараа оргон зайлж хорихоос өөр төрлийн ял эдлэхээс зайлсхийсэн байсан ч түүнд энэ үйлдэлд нь ял шийтгэл оногдуулах эрх зүйн зохицуулалт огт байхгүй байгаа нь ялтан этгээдэд оргох нөхцөл боломж олгож байна.

Хэдийгээр хорихоос өөр төрлийн ялаас оргон зайлсан ялтны үйлдэл нь Эрүүгийн хуульд заасан “оргон зайлах” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг бүрэн хангаж байдаг боловч Эрүүгийн хуулийн 21.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Баривчлагдсан,

¹³⁸ Зөрчлийн тухай хууль. УБ., 2017. Төрийн мэдээлэл эмхэтгэл. №24.

цагдан хоригдсон яллагдагч, цагдан хоригдсон шүүгдэгч, эсхүл хорих ял шийтгүүлсэн ялтан оргон зайлсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байдгаас гэмт хэрэгт тооцогдохгүй байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад буюу хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд сэжигтэн, яллагдагч нь оргон зайлахыг завдсан, оргон зайлсан тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт заасны дагуу цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авдаг болно. Шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ялаас оргон зайлсан ялтанг олж тогтоон, ял солих хугацаанд тухайн ялтан этгээдийг дахин оргуулж алдахгүйн тулд албан өрөөндөө байрлуулах, өөрөө хамт байх зэрэг нөхцөл байдал үүсдэг. Энэ нь ялтныг үндэслэлгүй хорьсон, хүний эрх, эрх чөлөөнд халдсан гэх нөхцөл байдал үүсгэдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд эрх хасах ял шийтгүүлсэн ялтан ял эдлэхээс оргон зайлах, нас барсан гэж зарлагдах эсхүл сураггүй алга болсонд тооцогдох, хорих ял эдэлж байгаа үед болон гамшиг, аюулт үзэгдэл, ослын улмаас шүүхийн шийдвэрт заасан эрх хасах ялыг хэрэгжүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн үед эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх үндэслэл тусгагдаагүй байдаг. Иймд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн нөхцөл байдал арилсан тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээж явуулах эрх зүйн зохицуулалт алга байна.

Эрх хасах ялаар шийтгүүлсэн ялтан ял эдлэхээс зайлсхийсэн, оргон зайлсан, шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн, шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлага байхгүй байгаа нь эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмыг хангахгүй байна.

Санал

Дээрх судалгаа, дүгнэлтдээ үндэслэн хорихоос өөр төрлийн ялаас зайлсхийсэн этгээдэд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог тодорхой болгох, ялтныг ажиллуулж байгаа байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, ялын хэрэгжилтийг нэг мөр ханган биелүүлэх талаар дараах саналыг гаргаж байна.

1. Эрүүгийн хуулийн 21.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Баривчлагдсан, цагдан хоригдсон яллагдагч, цагдан хоригдсон шүүгдэгч, эсхүл хорих ял шийтгүүлсэн ялтан хорихоос өөр төрлийн ялаар шийтгүүлсэн ялтан ял эдлүүлэх ажиллагаанаас оргон зайлсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж өөрчлөх;
2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад хуульд шийдвэр гүйцэтгэгч хорихоос өөр төрлийн ялаас оргон зайлсан ялтанг олж тогтоон баривчилсан бол “цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг” байх эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгуулах;
3. Шүүхээс ял оногдуулахдаа гэмт этгээдийн гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, зан үйл, ёс суртахууны төлөвшлийг мэргэжлийн байгууллагаар тодорхойлуулж байж энэ төрлийн ялыг сонгон оногдуулах; Энэ нь нэг талаас, тухайн гэм буруутай этгээдийн нийгэмд аюултай үйлдэлд, эс үйлдэхүйд тохирсон ял шийтгэлийг хүлээлгэх үндэслэл болдог, нөгөө талаас түүнийг дахин энэхүү гэмт үйлдлийг хийхгүй байх зан үйлийг суулгаж өгөх ба ингэснээрээ ялыг оновчтой оногдуулах, эсхүл ял завшихаас сэргийлж чадна.
4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон холбогдох бусад хуульд шийдвэр гүйцэтгэгч зорчих эрхийг хязгаарлах ялаас оргон зайлсан ялтанг олж тогтоон баривчилсан бол “цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авдаг” байх эрх зүйн зохицуулалтыг шинээр тусгуулах.
5. Эрх хасах ял эдлэхээс зайлсхийсэн, оргон зайлсан, шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн, шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй үйл ажиллагаа явуулсан тохиолдолд ялтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэх

эдлээгүй үлдсэн ялыг хорих ялаар солих эрх зүйн зохицуулалтыг эрүүгийн хуульд тусгах.

Ашигласан материал

Хууль тогтоомж:

- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль 2017 он
- Эрүүгийн хууль 2015 он
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 он
- Зөрчлийн тухай хууль 2017 он
- Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын Ерөнхий Прокурорын 2017 оны 09 дүгээр сарын 07-ны өдрийн А-234/А/103 дугаар хамтарсан тушаалын хавсралт
- Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм. Ерөнхий Ассемблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоолоор баталсан.

Ном гарын авлага:

- Г.Гантөмөр, С.Гантулга нар. Эрүүгийн эрх зүй: Ерөнхий анги /сурах бичиг/. УБ., 2020 он
- С.Жанцан. Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2014 он
- Б.Алтангэрэл. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа. УБ., 2018 он
- Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллагаанд дагаж мөрдөх хууль тогтоомжийн эмхэтгэл. УБ., 2022 он
- Алтангэрэл.Б Ялын бодлого, олон улсын чиг хандлага. Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа: эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. УБ., 2018 он
- Д.Бадам. Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүй тайлбар толь. УБ., 2018 он
- Б.Алтангэрэл нар. Пробацийн үйл ажиллагаа: Эрх зүйн зохицуулалт, харьцуулсан судлал. Судалгааны тайлан. УБ., 2019 он

Цахим эх сурвалж:

- <https://www.criminology.mn>
- <https://www.legalinfo.mn>
- <https://cd.gov.mn/>

Бусад эх сурвалж:

- Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх албаны мэдээ, тайлан.
- Legal liability imposed on convicts who evade punishment in the form of travel restriction

ШҮҮХЭЭС ӨСВӨР НАСНЫ ХҮНД ХОРИХ ЯЛ ОНОГДУУЛСАН ШҮҮХИЙН ШИЙТГЭХ ТОГТООЛ БИЕЛҮҮЛЭХИЙГ ХОЙШЛУУЛАХ ЭРХ ЗҮЙНЗОХИЦУУЛАЛТЫН ШИНЭЧЛЭЛ

UPDATE OF LEGAL REGULATION TO DELAY ENFORCEMENT OF COURT SENTENCES OF JUVENILE PERSONS

С.Бямба-Эрдэнэ

*ДХИС-ийн Эрх зүй, нийгмийн ухааны
сургуулийн багш, ахлах дэслэгч*

Товч агуулга: Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах эрх зүйн зохицуулалт, өсвөр насны хүний эрх зүйн байдлыг Эрүүгийн хуульд ялтан гэж томъёолж, ял эдэлж байгаа гэсэн эрх зүйн дагаврыг бий болгосон. Өсвөр насны ялтанг ерөнхийд нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хяналтад даатган орхиж байгааг өөрчлөх, Хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын¹³⁹ оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчинг хэрхэн бүрдүүлэх талаар санал боловсруулсан.

Abstract: The legal regulation of delaying the execution of the sentence of the court that sentenced the juvenile to imprisonment, the legal status of the juvenile is formulated as a convict in the Criminal Code, and the legal consequences of serving the sentence have been created. Conclusions and suggestions are expressed on how to change the fact that juvenile convicts are generally left under the control of the Court's enforcement agency, and how to reflect the participation of the state organization responsible for children's issues in the legal environment.

Түлхүүр үг: Өсвөр насны хүн¹⁴⁰, гэмт хэрэг¹⁴¹, Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага¹⁴², Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо¹⁴³, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар;

¹³⁹ Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2015 он., 8.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "...Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ..." гэжээ.

¹⁴⁰ Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2015 он. 6.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "...Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэглэж болно..." гэж.

Мөн хуулийн 6.2.4 дэх хэсэгт "...Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан өсвөр насны хүн сэтгэцийн хөгжлийн хоцрогдлын улмаас өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн хууль бус шинж, түүний улмаас учрах хор уршгийг бүрэн хэмжээгээр ухамсарлах чадваргүй бол ял оногдуулахгүй байж болно..." гэжээ.

¹⁴¹ Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2015 он. 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "...Энэ хуулийн тусгай ангид заасан нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцно..." гэж заажээ.

¹⁴² Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2015 он. 8.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлэх сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нөхцөлийг хуулиар тогтооно..." гэж, мөн хуулийн 8.5.3 дахь хэсэгт "...Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад ял эдэлж байгаа өсвөр насны хүнд ерөнхий, мэргэжлийн боловсрол, хөдөлмөрлөх, амьдрах ухааны дадал олгох сургалт зохион байгуулна. Хорих ял эдэлж байгаа өсвөр насны хүнээр хөдөлмөр эрхлүүлэхгүй..." гэж тус тус заажээ.

¹⁴³ Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хууль, УБ., 2016 он., 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт зааснаар "...Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо" гэж гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэргийн гэрч, хохирогч болсон, гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээг авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий орон нутгийн нэгжийг..." хэлнэ.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/190, А/280 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар "Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны бүрэлдэхүүн, зохион байгуулалт, үйл ажиллагааны журам"-ыг баталсан.

Хууль зүйн хороо, түүний Ажлын алба нь Хүүхэд хамгааллын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, энэ журамд заасан үүргээ хэрэгжүүлэхдээ хүүхдийн эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзаж хүүхдийн нас биед тохирсон, хүсэл сонирхолд нийцсэн зөвлөгөө, туслалцаа, дэмжлэг үзүүлж, үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн хор уршгийг нь ухамсарлуулах, бусдад учруулсан хохирол, гэм хорыг

Keywords: Adolescent, crime, special training and education organization, legal committee for children's rights, child, family and youth development department;

Удиртгал

Монгол Улсад 2022 онд 14-17 насны нийт 1,540 хүүхэд гэмт хэрэгт холбогдсон бол 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 14-17 насны хүүхдээс гэмт хэрэгт 346 хүүхэд холбогдож, 14-17 насны 499 хүүхэд хохирч, гэмт хэргийн улмаас нийт 767 хүүхэд гэмтсэн талаарх мэдээллийг Цагдаагийн ерөнхий газраас өгсөн.¹⁴⁴

“Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, бие махбодын шийтгэл, сэтгэл санааны дарамт, үл хайхрах болон мөлжлөгийн аливаа хэлбэрээс нийгмийн бүх орчинд хамгаалагдах эрхтэй” гэж Хүүхдийн эрхийн тухай хуульд¹⁴⁵ заасан боловч шүүхээс хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүнийг хамгаалах, хүмүүжүүлэхэд Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газар, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны оролцоог Монгол Улсын Эрүүгийн хуульд тусгайлан зааж өгөөгүйгээс хүүхдийн эрх ноцтой зөрчигдөж байна.

Мөн “Хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэдэг нь хэн нэг этгээд өөрийн хүч, эрх мэдэл, бие махбодын болон бусад давуу байдлаа ашиглан хүүхдийн халдашгүй дархан байх эрх, эрх чөлөөг зөрчиж, гэм хор учруулсан, эсвэл учруулахаар завдсан, түүнийг хамгаалах болон урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй үйлдэл эс үйлдэхүйг хүүхдийн эсрэг хүчирхийлэл гэнэ”¹⁴⁶ гэж тодорхойлсноор бол эцэг, эх салах¹⁴⁷, хараа хяналт муу тавих, бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, боловсролын хувьд үл хайхрах байдал гарган анхаарал бага тавьснаас өсвөр насны хүүхдүүд гэмт хэрэг үйлдэж, ял шийтгүүлэх явдал түгээмэл байна.

Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “...Эрэгтэй, эмэгтэй хүний гэрлэх, гэрлэлтийн гэрээ байгуулах, өөрчлөх, гэрлэлтээ сайн дураараа цуцлуулах, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн харилцаанд оролцох зэрэг хүний эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглоно.” гэж заасан. Гэвч хүүхдүүдийн өссөн

арилгахад хүүхдийг оролцуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн шалтгаан нөхцөлийг арилгах, сөрөг нөлөөнөөс тусгаарлах зэрэг арга хэмжээг хууль тогтоомжид заасан хүрээнд нийцүүлэн авна.

Хууль зүйн хороо нь аймаг, дүүрэгт гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж сэжиглэгдэж, мөрдөн шалгагдаж байгаа, эсхүл гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн, албадлагын арга хэмжээ авагдсан, зөрчил үйлдэж шийтгэгдсэн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулна. Мөн Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд хамаарахгүй хүүхдэд энэ журамд заасны дагуу тусалцаа үзүүлэн, зөвлөгөө өгч, эрх ашгийг нь хамгаална.

Хууль зүйн хорооны дарга нь тухайн аймаг, дүүргийн Засаг даргын орлогч байна.

Хууль зүйн хорооны гишүүнээр дараах алба хаагч, иргэн ажилладаг. Үүнд:

1. Аймаг, дүүрэг дэх шүүхийн Тамгын газрын дарга;
2. Аймаг, дүүргийн Прокурорын газрын ерөнхий прокурор;
3. Аймаг, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга;
4. Аймаг, дүүргийн хууль, эрх зүйн асуудал хариуцсан нэгжийн дарга;
5. **Аймаг, дүүргийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;**
6. Аймаг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга;
7. Аймаг, дүүргийн боловсролын асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;
8. Аймаг, дүүргийн эрүүл мэндийн асуудал хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;
9. Аймаг, дүүргийн хөдөлмөр, халамжийн үйлчилгээ хариуцсан газар /хэлтэс/-ын дарга;
10. Аймаг, дүүргийн Цагдаагийн газар /хэлтэс/-ын дарга;
11. **Аймаг, дүүргийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар /хэлтэс/-ын дарга;**
12. Хүний эрхийн Үндэсний комиссын орон нутаг дахь ажилтан;
13. Өмгөөлөгчдийн холбооны аймаг, дүүргийн салбар зөвлөлийн дарга /зөвшилцсөнөөр/;
14. **Аймаг, дүүрэгт гэр бүл, хүүхдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын төлөөлөл /зөвшилцсөнөөр/;**
15. Аймаг, дүүргийн хүүхдийн элч /зөвшилцсөнөөр/.

¹⁴⁴ <https://police.gov.mn/a/6556>;

¹⁴⁵ Монгол Улсын Хүүхдийн эрхийн тухай хууль.,УБ.,2016 он. 7 дугаар зүйлийн 7.1 дахь хэсэг;

¹⁴⁶ Ю.Бадамханд.Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл.,УБ.,2016 он

¹⁴⁷ <http://www.nisilel.cd.gov.mn/page/1466.shtml?sel=1657> Нийслэлийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2016-2018 оны 3 жилийн мэдээгээр Монгол Улсад жилд 15000 гэрлэгч гэр бүлээ цуцлуулсан.

гэр бүлийн орчин, амьдарч байгаа газар, найз нөхөд, эцэг, эх нь салсан, үл хайхрах байдлыг анхаарах хэрэгтэй.

Нийслэлийн хэмжээнд 2022 оны 12 сарын байдлаар хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан нийт 74 ялтан, үүнээс 38 хүүхэд, 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар нийт 56 ялтан, үүнээс 32 өсвөр насны ялтан хяналтад байна.¹⁴⁸

Үүнээс хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дууссан 2022 онд 18 хүүхэд, 2023 оны 4 дүгээр сарын байдлаар 10 хүүхдийн хяналтын хугацаа дууссан байна.¹⁴⁹

Мөн 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял эдэлж байгаа өсвөр насны нийт 32 хоригдол байгаагаас 15 эрэгтэй, 1 эмэгтэй өсвөр насны хоригдол анх удаа гэмт хэрэг үйлдэж шүүхээс оногдуулсан хорих ялыг зан нөлөөлөх сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэхгүй хойшлуулсан хугацаанд¹⁵⁰ дахин гэмт хэрэг үйлдэж хорих ялыг биечлэн эдэлж байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо 21 аймаг, 9 дүүрэгт үйл ажиллагааг нийт хүүхдэд хүртээмжтэй явуулах ёстой боловч зөвхөн тэнссэн, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны этгээдэд чиглэсэн арга хэмжээг Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газраар дамжуулан тасралтгүй явуулж, анх удаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд тухайн өсвөр насны хүнд нөлөөлөх ажил сургалт явуулдаггүй, анхаарч үздэггүйг анхаарах цаг ирсэн.

Тус хорооны үйл ажиллагаа хангалтгүй, хорооны гишүүдээс шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага Монгол Улсын хэмжээнд Их үйлсийн бүтээмж сургалтын төв төрийн бус байгууллагатай хамтран хорих ял хойшлогдсон өсвөр насны хүнд сургалтыг нэр төдий явуулж байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүн Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газраас анх удаа гэмт хэрэг үйлдэж, хорих ял хойшлогдсон өсвөр насны хүнийг тоодоггүй, анхаарч арга хэмжээ авдаггүй. Монгол Улсын Эрүүгийн хуульд зааснаар хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг зөвхөн хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлэхээр тусгайлан зааж, өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах хугацаанд зөвхөн шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавихаар зааснаас болоод анх удаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүүхдүүд мэргэжлийн байгууллагын тусламж дэмжлэггүй үл хайхрагдаж байна.

Шүүхээс анх удаа гэмт хэрэг¹⁵¹ үйлдсэн өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг хойшлуулах болон өсвөр хүнд оногдуулсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээний Эрүүгийн хуульд заасан зарим төстэй боловч хүүхдийн эрхийг зөрчиж ялгаварласан шинжтэй хуулийн заалтуудыг нэг бүрчлэн дурдаж харьцуулан судалж, хуульчлах шаардлагатай тулгамдсан асуудлыг хэрхэн шийдвэрлэх талыг илэрхийлнэ.

Мөн хорих ял хойшлогдсон хяналтын хугацаанд дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, хүмүүжил, төлөвшилд нь эергээр нөлөөлөхөд гэр бүлийн орчин, тэднийг шагналын хоногоор урамшуулах, олон улсын жишиг дүрэм, журам,

¹⁴⁸ <http://www.niislel.cd.gov.mn/page/1466.shtml?sel=1715> Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн мэдээ, тайлан 2023 он;

¹⁴⁹ <http://www.niislel.cd.gov.mn/page/1466.shtml?sel=1715> Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн мэдээ, тайлан 2023 он;

¹⁵⁰ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын нийгмийн ажил, сэтгэл зүйн албанаас авсан 2023 оны судалгаа;

¹⁵¹ Эрүүгийн хуулийн 6.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн энэ хуулийн тусгай ангийн 10.1/Хүнийг алах/, 11.1/Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах/, 12.1/Хүчиндэх/, 17.1/Хулгайлах/, 17.2/Дээрэмдэх/, 17.8/Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 20.7/Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах/, 20.16/Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 26.1/Цахим мэдээлэлд хууль бусаар халдах/, 26.2/Кибер орчинд хууль бусаар халдах программ, техник хэрэгсэл бэлтгэх, борлуулах/, 26.3/Хор хөнөөлт программ хангамж бүтээх, ашиглах, тараах/, 29.8/Террор үйлдэх/-т заасан гэмт хэрэг үйлдсэн бол түүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.” гэж заасан.

зөвлөмжийг ашиглах нь чухлыг тодорхойлж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Хүүхэд, гэр бүл залуучуудын хөгжлийн газар¹⁵², Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны уялдаа холбоог тодорхойлж энэ талаар баримталж буй бодлого, түүний хэрэгжилт болон олон улсын зарим туршлагыг судлан тодорхой санал дэвшүүлэхийг эрмэлзэв.

Үндсэн хэсэг

Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэсэн байна.¹⁵³

2015 оны Эрүүгийн хуулийн агуулга нь 2002 оны Эрүүгийн хуулиас ялгаатай нь гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгэгдсэн хүүхдэд оногдуулсан ялыг аль болох биечлэн эдлүүлэхгүй байхад чиглэсэн онцлог хууль болсон билээ.

Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэгт зааснаар гэмт хэрэг үйлдсэн хүнд 5 төрлийн ял оногдуулах, мөн хуулийн 6 дугаар бүлэгт зааснаар 3 төрлийн албадлагын арга хэмжээ оногдуулж болохоор хуульчилж өгсөн. Үүнээс өсвөр насны хүнийг үйлдсэн гэмт хэргийн байдлаас хамааран нийтэд тустай ажил хийлгэх, зорчих эрхийг хязгаарлах, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих гэсэн үндсэн 3 төрлийн ялыг оногдуулах зохицуулалттай. Ял нь ял шийтгүүлснээс үүсэх ялтай байдал гэсэн эрх зүйн үр дагаврыг бий болгох ба Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан хугацаанд хадгалагдана.

Эрүүгийн хуулийн 7.6 дугаар зүйлийн 1-т “...Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг¹⁵⁴ үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.” гэж заасан.

2002 оны Эрүүгийн хуулийн 69 дүгээр зүйлд “Насанд хүрээгүй этгээдэд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх талаар зааж, мөн хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэгт “Хөнгөн буюу хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд ял оногдуулахгүй байх нь зохистой гэж шүүх үзвэл түүнд дор дурдсан хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ оногдуулж болно.” гэж заасан байдаг. Үүнд:

1. Зургаан сараас нэг жил хүртэл хугацаа тогтоож засарч хүмүүжихийг даалгах;
2. Арван зургаан насанд хүрсэн этгээд бие дааж орлого олдог бол хохирлыг өөрийн хөдөлмөрөөр арилгах үүрэг хүлээлгэх;
3. Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садны хүний хяналтад өгөх;
4. Хамт олон буюу төрийн бус байгууллага, түүнчлэн тодорхой иргэний хяналтад байлгахгаар тэдний хүссэнээр буюу зөвшөөрснөөр шилжүүлэх, шаардлагатай гэж үзвэл хүмүүжүүлэгч томилох.

2002 оны Эрүүгийн хуулийн 62.1 дэх хэсэгт “...Анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн насанд хүрээгүй этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан түүнийг нийгмээс тусгаарлахгүйгээр хүмүүжүүлэх боломжтой гэж шүүх үзвэл хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол

¹⁵² Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 20.6 дахь хэсэгт “...Залуучуудын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь орон нутаг дахь залуучуудын хөгжлийн төвийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллана...” гэж заасан.

¹⁵³ Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2015 он., 8.1 дүгээр зүйлийн 2 дахь заалт;

¹⁵⁴ Монгол Улсын Эрүүгийн хууль, УБ., 2015 он., 2.7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид зааснаар хорих ялын дээд хэмжээг 5 жил, түүнээс доош хугацаагаар оногдуулахаар тогтоосон, эсхүл хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэнэ” гэж заасан.

биелүүлэхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Ийм тогтоол гаргасан үед нэмэгдэл ял биелүүлэхийг нэгэн адил хойшлуулна.” гэж заажээ.

Мөн хуулийн 62.3 дахь хэсэгт “...Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан этгээд шүүхээс тогтоосон хугацаанд даалгасан үүрэг биелүүлээгүй буюу захиргааны шийтгэл хүлээсэн бол шүүгч цагдаагийн байгууллагын саналыг үндэслэн хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай захирамж гаргана.” гэж тусгайлан заасан.

Харин 2015 оны Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 1-т “Шүүх анх удаа энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.” гэжээ.

Мөн хуулийн 8.7 дугаар зүйлийн 1-т “Энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учруулсан хохирол, хор уршгийн шинж чанар, хувийн байдлыг харгалзан ял оногдуулахыг тэнсэж нэг жилээс гурван жил хүртэл хугацаагаар хянан хүмүүжүүлэхээр шийдвэрлэж болно.”

Дээрх хуулиудын зохицуулалтыг харьцуулбал 2002 болон 2015 оны Эрүүгийн хуульд анх удаа гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах талаар заасан. Мөн 2015 оны Эрүүгийн хуульд шүүхээс үйлдсэн гэмт хэргийн хувьд энэ хуулийн тусгай ангид хорих ялын дээд хэмжээг найман жил, түүнээс доош хугацаагаар тогтоосон, эсхүл энэ хуулийн тусгай ангид хорих ял оногдуулахаар заагаагүй гэмт хэрэг үйлдсэн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авсан өсвөр насны этгээд эсхүл анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны ялтанд нэгэн адил хамаарахаар хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 2-т “Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргийг хүлээлгэнэ.” гэж зааснаараа хорих ял хойшлогдсон, тэнссэн өсвөр насны хүнд хүлээлгэх хариуцлага төстэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 14.1-т “...Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш эрхтэй” гэж заасныг зарим талаараа зөрчсөн.

Учир нь Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 3-т “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ.” гэж тусгайлан заасан, хорих ял авч ял хойшлогдсон өсвөр насны ялтныг хүүхдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хариуцах талаар хуулинд тусгайлан заагаагүй нь үл хайхарч, хуулийн өмнө эрх тэгш байх хүүхдийн эрхийг зөрчсөн.

Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны хүүхдүүдийг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар мэргэжлийн нийгэм сэтгэл албаараа дамжуулан агентлаг хоорондын тусгайлан гаргасан журмын¹⁵⁵ дагуу сургалтад хамруулж, сар бүр сургалтын үр дүнгийн талаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тайлагнаж, үр дүнтэй ажил явагддаг.

¹⁵⁵ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын дарга, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга нарын хамтарсан 2017 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/170, А/0138 дугаар тушаал “Хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэгжүүлэх журам;

2002 оны Эрүүгийн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байх хугацаанд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан насанд хүрээгүй этгээдэд захиргааны хяналт тавьж, цагдаагийн байгууллага хяналт тавьж ажилладаг байсан.

Судлаачийн зүгээс 2015 оны Эрүүгийн хуульд зааснаар цагдаагийн байгууллага хяналт тавихгүй байхаар хуульчилж, хорих ял хойшлогдсон өсвөр насны ялтнуудад шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хяналтаа тавьж, төрийн бус байгууллагыг түшиглэн сургалтад хамруулдаг. Гэвч хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллагын оролцоог Эрүүгийн хуульд тусгайлан заагаагүйгээс энэ асуудалд хүүхдийн асуудал хариуцсан байгууллагын оролцоо байхгүй, үгүйлэгдэж байна.

Шүүх гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүний гэм бурууг нь ухамсарлуулах, хохирлыг нөхөн төлүүлэх, хөдөлмөрлөх, амьдрах зөв арга барилд сургах, гэмт хэрэг дахин үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор 4 төрлийн үүрэг хүлээлгэж, 4 төрлийн хязгаарлалт тогтоох талаар хуульд заасан байдаг.

Тэнсэж, хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны этгээд болон хорих ял хойшлогдсон өсвөр насны ялтан нэгэн адил шүүхээс Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2-т заасан 4 төрлийн үүргээс сонгон хүлээлгэж болохоор заасан хэр нь өсвөр насны ялтанд нэмж, Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 3-т заасан 4 төрлийн хязгаарлалт оногдуулахаар хуульчилсан.

Шүүх өсвөр насны ялтанд зарим үед үүрэг хүлээлгэхгүйгээр¹⁵⁶, ихэнх нь үед мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, согтууруулах ундаа хэрэглэхийг хориглох, оршин суух газар, ажил, сургуулиа өөрчлөх, зорчин явахдаа хяналт тавьж байгаа эрх бүхий байгууллагад урьдчилан мэдэгдэх зэрэг үүргийг хүлээлгэж хорих ялыг хойшлуулж байна. Ингэснээр өсвөр насны хүнд зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг оногдуулахгүй болохоор тэднийг зүгээр л бүртгэх ажил хийгдэж байгааг өөрчлөх хэрэгтэй.

Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлгийн 7.6.1-т зааснаар хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулахад өсвөр насны хүн анх удаа хөнгөн гэмт хэрэг /хорих ялын дээд хэмжээ 5 жил/ үйлдсэн байхаар нийтлэг зохицуулалтын хэмжээнд тусгасан. Мөн хуулийн 8 дугаар бүлгийн 8.6.1-т заахдаа "...Анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ялын дээд хэмжээг 8 жил эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэдэг нь хүнд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хамаарах онцлог бөгөөд тусгай зохицуулалт болсон. Гэвч хоёр өөр бүлэг байсан ч хуулийн нийтлэг болон тусгай зохицуулалт агуулга, мөн чанарын хувьд нэгэн адил төстэй байх шинжийг агуулж чадахгүй байна.

Гэтэл шүүхээс өсвөр насны хүн хөнгөн эсхүл хүнд гэмт хэрэг үйлдсэн эсэхээс үл хамааран хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэлх хугацаанд хойшлуулах боломжтой байхаар хуульд заасан хуулийн хийдэл байна.

Насанд хүрсэн хүн, өсвөр насны хүн хоёрын хооронд нас, боловсрол, нийгмийн байр суурь зэргээрээ өөр ялгаатай. Гэвч өсвөр насны хүн ганцаараа эсхүл насанд хүрэгчидтэй бүлэглэн шунахайн сэдэлтээр амар хялбар аргаар мөнгө олох зорилгоор дахин олон удаагийн үйлдлээр хулгай хийж, өөрийн үйлдлээ бүрэн ухамсарласан байдаг.

Хэрвээ өсвөр насны хүнийг хүнд гэмт хэрэг үйлдсэн ч одоогийн зохицуулалтаар хорих ял оногдуулж, хорих ялыг хойшлуулсаар байна гэвэл Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлэгт заасан хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах зохицуулалтад зарим нэг нэмэлт, өөрчлөлт оруулж, хуулийн хийдлийг арилгах хэрэгтэй.

¹⁵⁶2022 оны 5 дугаар сарын 01-ний өдөр Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн Баянзүрх дүүргийн хорих ял хойшлогдсон өсвөр насны хүнд холбогдох 6 хэргийг судалж үзэхэд шүүхээс үүрэг хүлээлгээгүй хорих ялыг хойшлуулсан байсан;

Сургалт-хүмүүжлийн байгууллага: Нийгэм-сэтгэл зүйн албатай учир нийгмийн ажилтан, сэтгэл зүйч нар төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллаж гэмт хэргийн хор уршгийг арилгах талаар арга хэмжээ авч хохирлоо барагдуулахгүй бол хугацааны өмнө тэнсэн суллагдах эрх үүсэхгүй гэдгийг ойлгуулахаас гадна зан үйлд нөлөөлөх, хөдөлмөрлөх дадал олгох сургалтад биечлэн бүрэн хамруулснаар эерэг үр дүнд хүрдэг. Мөн өсвөр насны хоригдлыг ерөнхий боловсролын сургалтад хамруулж, бичиг үсэггүй, хичээл завсардсан хүүхдүүдийн хүмүүжилд эерэг нөлөө үзүүлдэг.

Мөн тодорхой хүнтэй харилцахыг хориглох, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглож тогтмол байнгын биечилсэн хяналтыг тавьж, зөвхөн хувийн хэрэгт бүртгэлтэй гэмт хэрэг үйлдэхэд хамааралгүй хүнтэй эргэлт, уулзалтаар уулзахыг зөвшөөрөх, ар гэр рүү нь утсаар яриулах зэрэг нь дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлсэн үр дүнтэй ажил болдог.

Улсын хэмжээнд тэнссэн этгээд, хорих биечлэн эдэлж байгаа хоригдол, хорих ялыг хойшлуулсан ялтанд сургалтын ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2020 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар баталсан “Зан үйлд нөлөөлөх сургалт зохион байгуулах журам”-аар зохион байгуулж байна.

Дээрх журам нь Монгол Улсын хэмжээнд өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, 3 хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эхэд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, хорих ял биечлэн эдэлж байгаа, тэнссэн зэрэг хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээ авагдсан бүх хүнийг хамруулсан нийтлэг зохицуулалттай. Гэвч хяналтад байгаа этгээдүүдийг нас, хүйс, сэтгэл зүйн онцлогоор нь ялгаж тус тусад нь сургалт зохион байгуулах талаар зааж өгөөгүйг өөрчлөх шаардлагатай.

2022 оны 4 дүгээр сараас эхлэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас улсын хэмжээнд Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтэст сургалтад хамрагдах үүргийн биелэлтийг хариуцсан нэг мэргэжилтний орон тоог баталсан ч өнөөдрийг хүртэлх хугацаанд дахин орон тооны ажилтан баталж өгөөгүй. Энэ нь 21 аймаг, алслагдсан 3 дүүргийн хэмжээнд хуваан тооцоход хангалтгүй байна.

Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын хэмжээнд Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч, сургалт хариуцсан мэргэжилтний оролцуулж, зан үйлд нөлөөлөх сургалтыг Их үйлсийн бүтээмж сургалтын төвийн¹⁵⁷ багшаар 1 сард нэг удаа тогтмол сургалтад хамруулж байна. Шийдвэр гүйцэтгэгч нараас өсвөр насны ялтны сургалтын үр дүнг сургалт ороход байсан эсэхээс хамаарч зөвхөн бүртгэлээр дүгнэдэг.

Тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны ялтанд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч дор хаяж 1 хүн батлан даалтад авч хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн үүргээ биелүүлэх талаар шаардлага тавьж, шүүхийн шийдвэрээр тогтоосон хязгаарлалт, даалгасан үүргийг танилцуулж, биелэлтийг хангуулах ажлыг зохион байгуулдаг ч төдийлөн үр дүнд хүрдэггүй.

Жендерийн эрх тэгш байдлын тухай хуулийн 14.4 дэх хэсэгт зааснаар “...эцэг, эх хүүхдэдээ нийгмийн үүрэг, хариуцлага, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх хамтын эрх тэгш оролцоо болон жендерийн эрх тэгш байдлын тухай ойлголт, хүнийг ялгаварлах үзэл, зан үйлийг өөрсдийн үлгэр дуурайл, гэр бүлийн хүмүүжлээр олгох ёстой...” гэж заасан байдаг ч энэ заалт гэмт хэрэгт өртсөн хүүхдүүдийн хувьд зөрчигдөөд байна.

Учир нь эцэг, эх нь салсан тохиолдолд хүүхдээ өөр дээрээ авч өсгөж байгаа аав эсхүл ээж нь бусад харгалзан дэмжигчдийнх нь хамт батлан дааж авдаг. Батлан дааж аваагүй бол надад энэ хүүхэд хамаагүй гэсэн байдлаар ханддаг. Энэ нь Гэр бүлийн тухай хуульд заасан “Эцэг, эх нь салсан байсан ч үр хүүхдээ хүмүүжүүлэх,

¹⁵⁷ Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн хэмжээнд 2022 онд “Их үйлсийн бүтээмж” сургалтын төв төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж байна.

хамгаалах үүрэг нь дуусгавар болох үндэслэл болохгүй” гэдгийг тусгасантай зөрчилдөж байдаг.

Эрүүгийн хуулийн 8.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хянан хүмүүжүүлэх хугацаанд хараа хяналтдаа байлгаж хүмүүжүүлэх үүргийг тодорхой хамт олон, төрийн бус байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, сурган хүмүүжүүлэгч, ойрын төрөл, садны хүн, тодорхой иргэний хүсэлтээр нь, эсхүл зөвшөөрснөөр нь даалгаж болно.” гэж хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан өсвөр насны этгээдэд хамааруулж хуульчилсан боловч хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны ялтанд чиглэсэн ийм заалт байхгүй байна.

Мөн өсвөр насны ялтныг батлан даах баталгаа гаргасан асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс ерөнхий боловсролын сургалтад хамрагдаж байгаа эсэх, хичээлээ хийх, таслах, тэнэх үйлдэл гаргаж байгаа эсэхэд нэг бүрчилж, биечлэн хяналт тавих боломж байхгүй.

Шийдвэр гүйцэтгэгч өсвөр насны ялтныг уруу татаж болзошгүй насанд хүрэгчидтэй уулзаж, харилцахыг хязгаарлах, согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэхийг хориглож шүүхээс хязгаарлалт тогтоосныг хангуулахаар баталгаа авч тайлбар авах ажлыг сар бүр тогтмол хийсэн ч байнгын биечилсэн хяналт тавьж чадахгүйн улмаас яг хаана хэнтэй юу хийгээд явж байгаа эсэхийг мэдэх боломжгүй. Эцэг, эх нь батлан даалтад авлаа ч гэсэн ажил гэрийн хооронд явсаар өөрийн мэдэлгүй хүүхдээ үл хайхрах нь түгээмэл байна.

Анх удаа гэмт хэрэг үйлдэж шүүхээс оногдуулсан хорих ялыг хойшлуулсан өсвөр насны ялтныг байнгын хяналт тавьж хүмүүжүүлэхэд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага¹⁵⁸, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар¹⁵⁹ хорих ял хойшлогдсон өсвөр насны хүнд шүүхээс даалгасан үүрэг болох зан үйлээ засах сургалтад нь сэтгэл заслын үйлчилгээ, хүүхдийг үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалт, ухуулгуудыг Жендерийн үндэсний хорооны нэгжүүдтэй хамтран зохион байгуулах эрх зүйн орчин үгүйлэгдэж байна.

Өсвөр насны ялтныг ялаас чөлөөлөхдөө: Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 8 жил хүртэл эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд шүүхээс оногдуулсан хорих ялын хугацааг хоёрны нэгээр бодож, ялыг багасган биечлэн эдлэх хорих ялыг 2 жил хүртэл хугацаанд хойшлуулах боломжтой.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч тогтоолын биелэлтийг хойшлуулсан ялтны сахилга, засрал хүмүүжил, шүүхээс даалгасан үүрэг, тогтоосон хязгаарлалтын биелэлтийн талаар хяналтын хувийн хэрэгт 30 хоног тутам тэмдэглэл хийж, тухай бүр нь прокурорт танилцуулж хянуулдаг. Энэ үед прокуророос тавьж буй шаардлага нь зан байдлын тодорхойлолт, сургалтад хамрагдсан хугацаа, засрал хүмүүжилд хяналт тавьдаг. Хорих ялыг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн ялтанд албан бичгээр мэдэгддэг.

Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлийн 4-т “Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.” гэжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186 дугаар зүйлийн 2.6-т “...Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх” гэж зааснаас болоод практикт ял хойшлогдсон хугацаа дуусмагц шийдвэр гүйцэтгэх

¹⁵⁸ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага;

¹⁵⁹ Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар;

ажиллагааг дуусгавар болгож, прокурор ял хойшлуулсан шийдвэрийг шүүх хурлаар оруулж шийдвэрлэхгүй байгааг анхаарах шаардлагатай.¹⁶⁰

Бусдад учруулсан гэм хорын хохирлыг асран хамгаалагч болох хууль ёсны төлөөлөгч нь төлөхөөр шийтгэх тогтоолд заасан байдаг боловч "...гэмт хэргийн хор уршгийг арилгах" арга хэмжээний талаарх үүргийг хүлээлгэхгүй байгаа нь буруу байна. Учир нь гэмт хэрэг үйлдэж хорих ял авах үедээ 18 насанд хүрээгүй, хорих ял авч 2 жил хүртэл хойшлогдсон хяналтын хугацаа дуусах үед насанд хүрсэн, бусдад учруулсан гэм хорын хохирол төлөгдөөгүй байвал хорих ялыг биечлэн эдлүүлэх эсхүл хохирлыг нэн даруй төлсөн тохиолдолд ялаас чөлөөлөх асуудлыг шүүх хурлаар нэг мөр шийдвэрлэх нь чухал юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 188.1 дахь хэсэгт "...Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан, тэнссэн хугацаанд ялтан засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, сурлага, хөдөлмөрт үнэнч, шударга хандлагаараа харуулсан, шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлсэн, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн буюу гэм хорыг арилгасан ялтны хянан харгалзахаар тогтоосон хугацааны 50 хувиас багагүй хугацаа өнгөрсөн тохиолдолд шийдвэр гүйцэтгэгч ялтныг ялаас чөлөөлүүлэх саналыг прокурорт гаргаж болно..." гэж заасан. Тухайлбал, Шүүхээс 6 жилийн хорих ял оногдуулахаар гэмт хэрэг үйлдэж гэм буруутайн тогтоогдож, ял багасгуулж, 3 жилийн хорих ялаар шийтгүүлж, шүүхээс 2 жилийн хугацаанд ял хойшлогдон, эхний 1 дэх жилдээ, хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй, зөрчил гаргаагүй бол ялаас чөлөөлөгдөнө.

Хорих ялыг хойшлуулсан шийдвэрийг хүчин болгохдоо: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 187.2 дахь хэсэгт "...Ялтан тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл шүүхээс тогтоосон хориглолт, хязгаарлалтыг 6 сарын хугацаанд хоёр, түүнээс дээш удаа зөрчсөн, эсхүл хориглолт, хязгаарлалтыг зөрчсөний улмаас хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан эрх, ашиг сонирхолд хохирол учирсан¹⁶¹, эсхүл хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй бол шийдвэр гүйцэтгэгч тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгуулж, хорих ялыг биечлэн эдлүүлэх саналаа прокурорт хүргүүлнэ" гэжээ.

Шүүхээс хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрээ хүчингүй болгосноор өсвөр насны ялтны хяналтын хугацаа хэдэн сар, өдөр, хоног өнгөрсөн, сургалтад хамрагдсан хугацаанаас үл хамаарч хорих ялыг биечлэн эдлүүлж байгаа нь хүүхдийн эрх зүйн байдлыг дордуулж байна.

Тухайн өсвөр насны хүний хяналтын хугацаанд байсан өдөр, хоног, сарыг хорих ялыг эдэлсэн хугацаанд оруулан тооцож шаардлагатай. Тухайлбал, нийтэд тустай ажил хийлгэх ял, зорчих эрхийг хязгаарлах ялыг хорих ялаар солихдоо эдлээгүй үлдсэн ажлын цаг¹⁶², хяналтын хугацааг¹⁶³, шагналын хоногийг¹⁶⁴ хасаж үлдсэн хугацаанд ялын дүйцүүлж хорих ялаар сольдог.

Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүний эрх зүйн байдал нь Эрүүгийн хуулийн 7 дугаар бүлэгт "...ялтан..." гэж тусгайлан зааж томъёолсон тул сургалтад хамрагдсан байдал, сар өдрийг харгалзан үзэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 223, 224 дүгээр зүйлд заасантай нэгэн адил сургалтын ажлын бүтээмж, чанарыг үндэслэн 1 сард 10 хүртэл

¹⁶⁰ НШШГТ-ын Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх хэлтсийн архиваас 2021 онд дуусгавар болсон өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 100 хэргийг судлахад хяналтын хугацаа дуусахад прокурор дүгнэлт гаргаж, хорих ялаас чөлөөлөх асуудлыг шүүхээс оруулж, хэргийг шийдвэрлээгүй байсан;

¹⁶¹ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, УБ., 2017

¹⁶² Эрүүгийн хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4-т "...Ялтан нийтэд тустай ажил хийлгэх ялыг биелүүлээгүй бол нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагийн ажлыг нэг хоногоор тооцож хорих ялаар солино..."

¹⁶³ Эрүүгийн хуулийн 5.5 дугаар зүйлийн 3-т "...Ялтан зорчих эрхийг хязгаарлах ялыг биелүүлээгүй бол ялтны зорчих эрхийг хязгаарлах ялын эдлээгүй үлдсэн хугацааны нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцож хорих ялаар солино..."

¹⁶⁴ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, УБ., 2017 он, 175 дугаар зүйлд "...Зорчих эрхийг хязгаарлах ял шийтгүүлсэн ялтныг урамшуулах..." талаар заасан.

хоногийн шагналын хоног олгох, ялтанд олгох шагналын хоногийг нэг улиралд 30 хоногоос илүүгүй байхаар тогтоож өсвөр насны ялтныг урамшуулж, хорих ял хойшлогдсон хугацаа дуусаж хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шүүх шийдвэр гаргасан тохиолдолд шагналын хоног, сургалтад хамрагдсан хугацааг хасаж хорих ялыг биечлэн эдлүүлэх тогтолцоо заавал байх ёстой.

Анх удаа гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны ялтан хорих ял хойшлогдсон хугацаагаа дуусгаад дахин тодорхой хугацаанд хяналтад хорих ялыг завшуулахгүй нөгөө талаас гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ялыг биечлэн эдэлж байгаа хүүхдүүд шиг хүмүүжиж чаддаггүй. Хэрвээ хүүхдийн асуудал хариуцсан төрийн байгууллага хариуцаж байвал дахин гэмт хэрэг үйлдэх нь багасна. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад¹⁶⁵ ял эдэлж буй өсвөр насны хоригдлуудын ял шийтгэлийн байдал. 2023.05.12-ний өдрийн байдлаар.

Хүснэгт №2

Эрүүгийн хуулийн зүйл, анги	Гэмт хэргийн ангилал	
	Хөнгөн	Хүнд
11.1.Бусдын бие махбодод хүнд гэмтэл санаатай учруулах		3 хоригдол. 16-17 насны /4-5 жилийн хорих ялтай/ Анх удаа бүлэглэн
12.1.2.1, 12.1.2.2 Бусдын бэлгийн эрх чөлөөнд халдах	3 хоригдол. 16-17 насны /1-2 жилийн хорих ялтай/ Анх удаа бүлэглэн	
12.1.4 бусдын бэлгийн эрх чөлөөнд халдах /хүндрүүлэх нөхцөлтэй/		4 хоригдол. 15-17 насны /5-6 жилийн хорих ялтай/ Анх удаа
17.1.2.1 Хулгайлах	17 хоригдол. 14-16 насны 2-3 жилийн хорих ялтай /Анх удаа ял авсан 12, дахин шийтгэгдсэн 5/	
17.2.2. Дээрэмдэх		5 хоригдол. 15-17 насны 1-2 жилийн хорих ялтай дахин үйлдсэн .
Бүгд	20 хоригдол.	хоригдол.

Дээрх хүснэгтээс 15 өсвөр насны хоригдол анх удаа гэмт хэрэг үйлдээд 1-3 жилийн хорих ялаа биечлэн эдэлж байна. Энэ нь эцэг эхийн зүгээс тавих хараа, хяналт алдагдаж бүтэн буюу эцэг эх нь салж сарнисан хагас өнчрөлд орох нь өсвөр насны хүүхдүүдийг гэмт хэрэг үйлдэхэд нэг нөхцөл болж байна.

Профессор Н.Жанцан 52 жилийн өмнө 1971 онд Монголд гэр бүл салалтын улмаас өнчирсөн үл хайхрагдсан хүүхдүүдийн 12.6% нь гэмт хэрэг үйлдэж, 14.5% нь зөрчилд холбогдсон байгааг¹⁶⁶ тогтоосон байдаг. Насанд хүрээгүй хүмүүсийн үйлдэж буй хэргийн 60 гаруй хувь нь хулгайлах, үлдсэн хувь нь дээрэмдэх, хүчиндэх, танхайрах, зодоон бусад хэргүүд зонхилон эзэлдэг¹⁶⁷ гэдгийг судалгааны ажлаараа баталсан.

¹⁶⁵ Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын нийгэм, сэтгэл зүйн албанаас авсан 2022 оны 5 сарын судалгаа; ¹⁶⁶ Н.Жанцан, Ю.Цэвээннамжил, "Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье", УБ., 1975 он., 26 дахь тал

¹⁶⁷ Б.Наранзаяа. "Насанд хүрээгүй этгээдээс үйлдэгдэж буй хулгайн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ба криминологийн зарим асуудал" сэдэвт Цагдаагийн дээд сургуулийн дипломын ажил., УБ., 1999 он., 56 дахь тал

Гэр бүл салалт хүүхдэд сөрөг үр дагавар авчирдаг гэдгийг эрдэмтэн Н.Жанцан 1984 онд өөрийн бүтээлдээ "...гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй хүмүүсийн 400 хавтаст хэргийн материалд судалгаа хийж үзэхэд судалгаанд хамрагдагсдын 33.2% бүрэн биш гэр бүлд хүмүүжсэн, 4.6% нь эцэг эхгүй, 18.1% эцэгтэйгээ, 9.2% эхтэйгээ, 1.3% нь төрөл садныхантайгаа хамт амьдарч байсан байна¹⁶⁸..." гэж тэмдэглэсэн байна. Үл хайхрагдах байдал нь хүүхдийн хүмүүжилд чухал нөлөө үзүүлдэг гэдгийг 39 жилийн өмнө баталсан. Мөн 2013-2017 онд хорих ял авч хойшлогдсон 1273 хүүхэд, хорих ял биечлэн эдэлсэн 134 хүүхдийн ар гэрийн байдалд гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн зэргээс харж болно.

Олон улсын гэрээ, конвенц: Насанд хүрээгүй этгээдэд хорих ял оногдуулахыг аль болохоор зайлсхийж, харин нээлттэй "шорон" буюу нийгмээс тусгаарлахгүйгээр эрх чөлөөг нь түр хязгаарлах замаар нийгэмшүүлэх чиглэлийн олон сонголттой ялын төрлийг хэрэглэж, энэ нь "төр, иргэний байгууллага, гэр бүл"¹⁶⁹ гэсэн гурвалсан субьектийн хамтын хариуцлагын зарчмаар хэрэгжүүлэхээр зохицуулсан байдаг.

НҮБ-аас гаргасан жишиг дүрэмд¹⁷⁰ энэ талаар тодорхой тусгасан ба энэ нь шүүхээс хорихоос өөр төрлийн ялыг түлхүү хэрэглэх болсныг илэрхийлнэ. Хүүхдийн эрхийн конвенцод хүүхэд бүр эрхээ эдлэхийн тулд шаардлагатай бүхий л олон улсын конвенц болон үндэсний хуулийг хэрэглэх эрхтэй.¹⁷¹ Насанд хүрээгүй этгээдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тэдний насыг болон засарч хүмүүжихэд нь дэмжлэг үзүүлэхийг харгалзсан байна.¹⁷²

Олон улсад хэргийн нөхцөл байдал шаардахгүй бол насанд хүрээгүй нэг ч хүнийг эцэг, эхийнх нь хараа хяналтаас бүрэн буюу зарим хэмжээгээр гаргаж болохгүйг заасан байдаг боловч энэ журмын хэрэгжилт хангалтгүй байгааг Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газраас 2013 онд НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр "Ариусахуй ертөнц" сэтгэл зүйн төв, сэтгэл заслын эмнэлгээр "Насанд хүрээгүй хүн гэмт хэрэг үйлдэж байгаа шалтгаан нөхцөлийг судлах" чанарын судалгааг захиалан гүйцэтгүүлсэн¹⁷³ судалгааны жишиг үр дүнгээр дараах байдлаар тайлбарлаж болно.

Уг судалгаанд 2013 онд ял хойшилсон 40 хүүхэд, тэдний эцэг, эх болох 40 хүний хамруулсан байдаг.

Хүснэгт №3

40 хүүхдийн үйлдсэн гэмт хэрэг хувь, хэмжээ			Гэмт хэрэг үйлдсэн насны байдал	
Хулгайлах /ЭХ-н 17.1/	Дээрэмдэх /ЭХ-н 17.2/	Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах /ЭХ-н 11.1/	14 насны	15-17 насны гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн
/7/ 17%	/8/ 20%	/19/ 47%	Хулгайлах /ЭХ-н 17.1/	/ЭХ-н 17.2/ /ЭХ-ийн 11.1/
-	Үүнээс /28/ 70% бүлэглэн үйлдсэн		-	-

Судалгаанд хамрагдсан 40 хүүхдийн 47% нь дээрэмдэх, 20% нь хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах, 17% нь хулгайлах гэмт хэрэг, 70% нь өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн. Тэднээс 14-өөс доош насныхан нь ихэвчлэн хулгайн гэмт хэрэг үйлдсэн бол 15-17 насныхан нь танхайн гэмт хэрэг, дээрэмдэх гэмт хэрэг бүлэглэн үйлдсэн; 58% нь

¹⁶⁸Н.Жанцан."Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам".УБ.,1984. 85 дахь тал

¹⁶⁹"Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе".УБ., 2013 он., 34 дахь тал

¹⁷⁰НҮБ-ын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм./Токиогийн дүрэм/Ерөнхий Ассемблейн 1990 оны 10-р сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоол

¹⁷¹"Хүүхдийн эрхийн конвенц".НУ.,1989 он.,37(Б);

¹⁷²"Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт"., 1966 он.,14.4 дахь хэсэг

¹⁷³Хууль зөрчлсөн хүүхэдтэй ажиллах арга зүйн гарын авлага., Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар.,УБ.,2016 он., 9 дахь тал

эхийн, 17% нь эцэг, асран хамгаалагчдын асрамж халамжид амьдардаг хүүхдүүд гэмт хэрэг үйлдсэн байдаг¹⁷⁴.

Хүүхдийн эрхийн тухай хуульд заасан эцэг, эх асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүлээх зарим үүрэг¹⁷⁵-ийн хэрэгжилт хуульд нийцэхгүй, эцэг, эхийн хараа хяналт муу байна. Үүнд:¹⁷⁶

Хүүхдэд гэр бүлдээ аз жаргалтай, хайр халамжтай, бүхий л талаар хөгжих орчныг бүрдүүлэх, хүүхдээ хүмүүжүүлэх, харилцааны соёл төлөвшүүлэх, хүүхдийн хөгжил, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, хүүхдийг хууль тогтоомжид заасан нийгмийн үйлчилгээнд хамруулах; хүүхдийг хөгжиж, төлөвшихөд нь дэмжин туслах зэрэг тус тус хангагдаагүйтэй холбоотой гэж үзэж байна.

Гадаадын зарим орны туршлагаас үзэхэд: Оросын Холбооны Улсын Эрүүгийн хуульд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусахад шүүх хорих ялыг биечлэн эдлүүлэх шийдвэр гаргадаг. Хойшлуулсан хугацаанд сургалтад хамруулаад шагналын хоног олгох, сургалтад хамрагдсан өдөр, хоногийг хорих ялын хугацаанаас хасаж тооцдоггүй.

Босния Герцеговин Улсын “Чука” нөхөн сэргээх, сурган хүмүүжүүлэх төв туршлага авахад болохуйц үр дүнтэй гэж боддог. Түр байрлуулах төв нь ял хойшлогдсон хүүхдэд сургалт, хүмүүжлийн болон мэргэжил олгох сургалтыг зохион байгуулах, хүүхдийн харилцааны чадвар, эцэг, эхийн чадварыг нэмэгдүүлэх, биеийн тамирын арга хэмжээ, тоглоом, олон нийтийн клуб ажиллуулах, төрийн бус байгууллагатай хамтран ажилладаг. Уг төвд хүүхэд 6 болон 12 сарын хугацаанд 7 хоногийн 4 өдрийг тухайн төвд өнгөрүүлдэг ба 2 ажилтан хөтөлбөрт хяналт тавьж, сайн дурын 8 ажилтан /оюутан/ өдөр тутмын үйл ажиллагааг хариуцдаг. Хүүхдийн шүүх нь Чугакийн амжилтыг харгалзаж, хугацааг богиносгосон ба хорихын оронд хүмүүжлийн дээрх байгууллагад шүүхийн шийдвэрийг явуулдаг болсон.

Англо-Саксоны эрх зүйн тогтолцоотой, Америкийн Нэгдсэн Улсад насанд хүрээгүй этгээдийн эрүүгийн хэргийг насанд хүрсэн этгээдийнхээс ялгасан системийг төлөвшүүлэх нь эрүүгийн шүүхийн тогтолцоонд хамгийн зөв дэвшил юм гэдгийг АНУ-ын дээд шүүхээс тогтоосон байдаг. Насанд хүрээгүй этгээдүүдийн шүүхээр хэргийг тусад нь шийдвэрлэдэг¹⁷⁷.

Ийнхүү шүүхээр хэргийг хянан шийдвэрлэсний дараагаар нийгмийн ял болон баривчлах ял оноодог.

1. Нийгмийн ял нь гэмт хэрэгтнийг хорихгүйгээр шийтгэх ялын төрөл бөгөөд хэлэлцүүлэхээр шилжүүлэх, эцэг эхийн хүмүүжил олгох сургалтад суух, нөхөн төлбөр төлүүлэх арга хэмжээг авдаг.
2. Хэлэлцүүлэхээр шилжүүлэх нь: нутгийн холбоо, мөн залуучуудын хууль зүйн ажилчидтай хамтран хүүхдийн зан авир засах ажлын программд хамруулахыг зөвшөөрөх¹⁷⁸

Эх газрын эрх зүйн тогтолцоотой, ХБНГУ-д насанд хүрээгүй хүнийг тухайн процессын хууль нь Насанд хүрээгүй этгээдийн шүүхийн дүрэмтэй, Насанд хүрээгүй хүний шүүх ажилладаг онцлогтой.

¹⁷⁴“Монгол улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” сэдэвт судалгааны ажлын тайлан /2013-2017/, УБ., 2018 он., 44 дахь тал;

¹⁷⁵Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, УБ., 2016 он., 10 дугаар зүйл;

¹⁷⁶Мөн хуулийн 10.1.1, 10.1.2, 10.1.3, 10.1.5, 10.1.8, 10.1.10 дахь заалт;

¹⁷⁷ Ч.Болормаа. “Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хүлээлгэх ялын бус Эрүүгийн хариуцлагыг боловсронгуй болгох нь” сэдэвт илтгэл”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, /дугаар 4/, УБ., 2020 он., 263 дахь тал;

¹⁷⁸ Мөн тэнд 264 дахь тал;

Мөн насанд хүрээгүй этгээдэд хорих ялыг оногдуулахыг төдийлөн яардаггүй бөгөөд:

- Боловсролын хориг буюу насанд хүрээгүй этгээдийг заавал суралцах хичээл, заавал очиж оролцох ёстой нийгмийн үйл ажиллагаануудыг зааж өгдөг,
- Сахилгын арга хэмжээ /хичээл/ буюу тухайн гэмт хэрэг үйлдсэн насанд хүрээгүй этгээдэд тухайн үйлдсэн гэмт хэргийнх нь нийгмийн хор аюул, сэрэмжлүүлэг, хууль эрх зүйн хязгаарлалтын талаар албадан хичээл заадаг¹⁷⁹.

Манай улсад хүүхдийн тусгайлсан шүүх, хүүхдүүдийг байршуулан хүмүүжүүлэх тусгай төв ажилладаггүй.

Доктор Ю.Бадамханд “Насанд хүрээгүй хүмүүст зориулсан тусгайлсан шүүх тогтолцоо (juvenile justice)-ны гол зарчим нь ЭХХША-ны хамгийн дээд боломжит нэг бүрчилсэн ажиллагааг хангах явдал юм”¹⁸⁰ гэж тодорхойлсон.

Хорих ял хойшлогдсон өсвөр насны хүн болоод батлан дааж авсан эцэг, эх асран хамгаалагч руу нь чиглэсэн үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалтууд явагддаггүй. Иймд Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын оролцоог Эрүүгийн хуульд зөвхөн хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд оролцох байдлаар хязгаарлаж зохицуулсныг өөрчилж, хорих ял хойшлогдсон өсвөр насны хүний хяналтын хугацаанд хүмүүжүүлэхэд оролцох талаар тусгайлан зааж хуульд тусгайлан зааж өгөх шаардлага үүссэн.

Дүгнэлт

Хорих ялыг хойшлуулсан өсвөр насны хүнийг Чука нөхөн сэргээх, сурган хүмүүжүүлэх төв, АНУ, Герман Улс шиг хүүхдийг хэргийг хянан шийдвэрлэх тусгайлсан шүүхийг байгуулах, шүүхээс даалгасан үүргийг хэрэгжүүлэхдээ нийгэмшүүлэх нөхөн сэргээх, мэргэжил олгох, ажил сургуультай байлгах зэрэг тусгайлсан ажлыг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраар дамжуулан явуулах шаардлагатай байна.

Өсвөр насны ялтны эцэг, эх салсан байхаас үл хамаарч хянан хүмүүжүүлэх, хараа хяналтдаа байлгах үүргийг хүлээсэн батлан даагч эцэг, эх, харгалзан дэмжигчдийг өсвөр насны ялтны хамт үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалтад хамруулах шаардлагатай байна.

Шүүхээс хорих ял оногдуулсан шүүхийн тогтоол биелүүлэхийг хойшлуулах үедээ заримдаа өсвөр насны хүнд зан үйлээ засах сургалтад хамруулах үүргийг зааж өгөөгүйгээс зарим хүүхдүүд сургалтад хамрагдах боломжгүй болдог. Иймд сургалтад заавал хамрагдах үүрэг хүлээлгэж хорих ялыг хойшлуулах талаар хуульд тусгах хэрэгтэй.

Тогтоолын биелэлтийг хойшлуулсан хугацаанд өсвөр насны ялтны хорих ялыг хойшлуулсан хугацаа дуусгавар болж, ялаас чөлөөлөгдөхгүй эсхүл санаатай шинээр гэмт хэрэг үйлдэж хорих ялыг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шүүх шийдвэр гаргавал эдлээгүй үлдсэн хорих ялын хугацаанаас шагналын хоног, хяналтын бүртгэл, сургалтад хамрагдсан өдөр хоногийг хасаж, эдлээгүй үлдсэн хорих ялын хугацааг биечлэн эдлүүлэх нь хүүхдийн эрх зүйн байдлыг дордуулахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх боломжтой.

Санал

1. Эрүүгийн хуулийн 7.6 дугаар зүйлийн 1-т “Шүүх анх удаа гэмт хэрэг үйлдэж хорих ялын дээд хэмжээг 8 жил эсхүл түүнээс доош хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн...”, хөнгөн гэмт хэрэг үйлсэн жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хоёр жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина гэж өөрчлөлт оруулах,

¹⁷⁹ Мөн тэнд 265 дахь тал;

¹⁸⁰ Ю.Бадамханд, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үед насанд хүрээгүй хүмүүсээс байцаалт авахад тулгамдаж буй асуудал”, Хууль дээдлэх ёс сэтгүүл, /дугаар 3/ .УБ.,2017 он., 101 дахь тал

2.Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлд “Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны ялтныг хянан хүмүүжүүлэх асуудлыг хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ” гэж нэмэлт оруулах

3.Эрүүгийн хуулийн 8.6 дугаар зүйлд “Хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа заавал 7.3 дугаар зүйлийн 2.2-т заасан зан үйлээ засах сургалтад хамрагдах үүрэг хүлээлгэхээр тусгах

4.Эрүүгийн хуулийн 8.6¹-т, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186.2¹-т “...Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц сургалтад хамрагдсан, засарч хүмүүжсэн байдлаас хамаарч сард 10 хүртэл шагналын хоног олгож урамшуулах, сургалтад хамрагдсан өдөр, хоногийг хорих ялыг биечлэн эдлэх хугацаанаас хасаж тооцож болох...” талаар хуульчлах

6.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186 дугаар зүйлийн 2.6-т “Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаа дуусмагц энэ тухай прокурор, цагдаагийн байгууллага, хорих ял оногдуулсан шүүх болон ял шийтгүүлсэн этгээдэд бичгээр мэдэгдэх” гэж өөрчлөлт оруулах

5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 186.2-т “Хорих ял хойшлогдсон хугацаанд эцэг эх нь тусдаа амьдардаг салсан байхаас үл хамаарч хүүхдээ хоёул үл хайхрахгүй байж батлан дааж асран хамгаалах, үл хайхрах хүчирхийллийн эсрэг сургалтад хамрагдахад байлцах” талаар хуульчлах

6.Өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд зан үйлээ засах сургалтад хамрагдах үүргийг хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий хүүхдэд зааж чиглүүлсэн сургалтын журмыг боловсруулах

7.Өсвөр насны хүнийг хэргийг хянан шийдвэрлэх дагнасан шүүхийг байгуулах,

Ашигласан материал

1. Олон улсын гэрээ, конвенц:

- НҮБ-ын Хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрэм /Токиогийн дүрэм/ Ерөнхий Ассемблейн 1990 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45/110 дугаар тогтоол.
- 1989 оны Хүүхдийн эрхийн конвенц
- 1966 оны Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
- “Насанд хүрээгүй хүмүүсийн талаар шүүн таслах ажиллагаа явуулахтай холбогдуулан НҮБ-аас гаргасан стандартын наад захын журам”., /Бээжингийн журам/ 1985 оны 11 дүгээр сарын 29-ний Ерөнхий Ассемблейн 40/33 дугаар тогтоолоор баталсан./

2. Хууль тогтоомж, журам:

- Эрүүгийн хууль.,УБ.,2002 он;
- Хүүхдийн эрхийн тухай хууль.,УБ.,2016 он;
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль.,УБ.,2017 он;
- Эрүүгийн хууль.,УБ.,2017 он;
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль.,УБ.,2017 он;

3. Ном, сурах бичиг, судалгааны ажил, тайлан, сэтгүүл:

- Н.Жанцан, Ю.Цэвээннамжил, “Насанд хүрээгүй хүмүүсийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, УБ.,1975 он;

- Н.Жанцан.,”Насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэж байгаа гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам”,УБ.,1984 он;
- UNICEF.,Хууль зөрчсөн хүн хүүхдийн асуудал Монголд.,2002 он;
- Б.Наранзаяа. “Насанд хүрээгүй этгээдээс үйлдэгдэж буй хулгайн гэмт хэргийн эрүүгийн эрх зүйн ба криминологийн зарим асуудал” сэдэвт Цагдаагийн дээд сургуулийн дипломын ажил.,УБ.,1999 он;
- “Хүүхдийн эрх хүүхэд хамгаалал”,УБ.,2011 он;
- “Дэлхийн эрүүгийн загвар хууль ба орчин үе”,УБ., 2013 он;
- Хууль сахиулах үйл ажиллагаа, онол, практикийн тулгамдсан асуудал.,УБ.,2016 он.,/Д.Насанбат.,”Хорих байгууллагын ялтан болон хорих байгууллагаас суллагдсан хүмүүст явуулсан нийгэмшүүлэх ажлын үр нөлөө” илтгэл/;
- Хууль зөрчсөн хүүхэдтэй ажиллах арга зүйн гарын авлага., Нийслэлийн хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар.,УБ.,2016 он;
- Ю.Бадамханд.Жендерт суурилсан гэр бүлийн хүчирхийлэл.,УБ.,2016 он;
- Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан. УБ.,2017 он;
- Монгол Улсын БЗД-ийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн нэгдсэн тайлан.,УБ.,2018 он;
- “Монгол Улсад насанд хүрээгүй хүмүүсээс болон хүүхдийн эсрэг үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцөл” судалгааны тайлан /2013-2017/,УБ.,2018 он;
- Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ.,2020. №4

ЦАГДААГИЙН ЭРХ ЗҮЙН ОНОЛ, ПРАКТИКИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ

ЦАГДААГИЙН АЛБА ХААГЧИЙГ АЛБАН ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДУУЛАН ХАЛДАЖ БАЙГАА ҮЙЛДЭЛД ХҮЛЭЭЛГЭЖ БУЙ ХАРИУЦЛАГА БА
ОЛОН НИЙТИЙН ХАНДЛАГА

RESPONSIBILITY ACCEPTED BY POLICE OFFICER FOR OFFENSES RELATED
TO THE PERFORMANCE OF THEIR DUTIES AND
PUBLIC ATTITUDES

*Б.Баянмөнх
Цагдаагийн сургуулийн ЦЭЗТ-ийн эрхлэгч,
доктор (Ph.D), цагдаагийн дэд хурандаа
Дотоод хэргийн их сургууль,*

Товч агуулга. Улс орны нийгэм, эдийн засгийн байдал болон бусад хүчин зүйлтэй холбоотойгоор эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдал жил ирэх тусам хүндэрч, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн гаралт буурахгүй байгаа өнөө үед гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа хууль сахиулагчдын амь бие, эрүүл мэндэд халдах, халдахаар заналхийлэх явдал гарсаар байна.

Энэхүү илтгэлд цагдаагийн алба хаагчаас Монгол Улсын хууль, нийтээр дагаж мөрдүүлэхээр тогтоосон захиргааны хэм хэмжээний актын хэрэгжилтэд хяналт тавих, албан үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор халдах явдал улам нэмэгдэх хандлагатай болж байгаа нь тухайн үйлдэлд хүлээлгэж байгаа хариуцлага харьцангуй сул байгаатай холбоотой гэсэн судлаачийн байр суурийн талаар бичсэн болно.

Absract. Due to the social and economic situation of the country and other factors, the criminal and law enforcement situation is getting worse year by year, and the crime and legal violations are not decreasing. attacks and threats to attack people's health continue to occur.

In this report, it is written about the position of the researcher that the increasing tendency of assaults in connection with the performance of official duties and the supervision of the implementation of the acts of administrative norms established by the law of Mongolia and general compliance by police officers is due to the relatively weak responsibility of the act.

Түлхүүр үг. Цагдаагийн алба хаагч, жагсаал, цуглаан, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, техник хэрэгсэл

Key word. Police officer, demonstration, meeting, life, health, property, hardware

Үндсэн хэсэг

Монгол Улс бүс нутгийн болон бусад улс орнуудтай жишихэд харьцангуй аюулгүй, эрсдэл багатай улс гэсэн дүгнэлтийг Олон улсын аялал жуулчлалын байгууллагаас хийсэн байдаг. Энэ дүгнэлтийг бусад улс, тэр дундаа дотоодын зөрчил тэмцэлтэй орнуудын цагдаагийн байгууллагын алба хаагчдын аюулгүй байдалтай энгийн харьцуулалтын аргаар холбож үзэхэд манай улсын цагдаагийн байгууллагын алба хаагчдын аюулгүй байдал эрсдэл багатай. Гэвч нийгэм, эдийн засгийн тогтолцоонд өөрчлөлт орсон 1990-ээд он, цаашилбал 2000-аад оноос хойш нийгэмд багагүй сөрөг үзэгдэл, үйл явц өрнөсний дотор төрийн албаны нэр хүнд унаж, иргэдийн зүгээс шүүмжлэх, эсэргүүцэх явдал түгээмэл болсон.¹

¹ Энхболд Б. Хотжилт ба гэмт явдал. УБ. 2011. 58 дахь тал

Цагдаагийн алба хаагч хуульд заасан техник, тусгай хэрэгслээр бүрэн хангагдсан тохиолдолд түүнд учирч болох аюулгүй байдлын эрсдэлийн түвшин тэр хэмжээгээр буурах боломжтой юм. Гэвч нийгэм, эдийн засгийн тогтолцоонд өөрчлөлт орсон 1990-ээд он, тодруулбал, 2000-аад оноос хойш нийгэмд багагүй сөрөг үзэгдэл, үйл явц өрнөсний дотор төрийн албаны нэр хүнд унаж, иргэдийн зүгээс шүүмжлэх, эсэргүүцэх явдал түгээмэл болсон. Хуулиар хүлээсэн үүргийн дагуу цагдаагийн байгууллага, алба хаагч олон нийтийн аюулгүй байдлыг хангаж дэг журмыг сахиулахдаа шинэ тутам сорилт, эрсдэлтэй тулгарч ирлээ. Тухайлбал, 2008 оны 07 дугаар сарын 01-ний өдөр нийслэл хотын төвд УИХ-ын сонгуулийн дүнтэй холбоотой улс төрийн зөрчил, маргаанаас үүдсэн нийтийн эмх замбараагүй байдлыг таслан зогсоох үед цагдаагийн олон тооны алба хаагч халдлагад өртөж бие махбоди, сэтгэл санааны ихээхэн хохирол амссан явдлыг дурьдаж болно.

Болж өнгөрсөн дээрх үйл явдалд улс төр, хууль эрх зүй, нийгэм эдийн засгийн олон талаас үнэлэлт, дүгнэлт өгсний дотор цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд сургамж болох асуудлууд анхаарал татаж байна.

Цагдаагийн алба хаагчид олноороо бэртэж халдлагад өртөж амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ихээхэн хохирол амсахад нөлөөлсөн нэг хүчин зүйл бол шаардлагатай техник, тусгай хэрэгсэлийн хангамж хүрэлцээ хангалтгүй байсан явдал юм.¹⁸¹

Судалгааны явцад цугларсан мэдээллээс үзвэл албан үүргээ гүйцэтгэж байгаа цагдаагийн алба хаагчийн тавьсан хууль ёсны шаардлагыг үл биелүүлэх, эсэргүүцэх, доромжлох, хүч хэрэглэн бие, эрх чөлөөнд нь халдах, улмаар амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд нь хохирол учруулах явдал түгээмэл гэж хэлж болохоор байна.

Энэ нь алба хаагч өөрөө шалгуулахаас эмээж зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхээс зайлсхийх, биеийн хүч, тусгай мэх хэрэглэх, харилцааны ур чадвар сул, дуудлага, мэдээллийн дагуу очихдоо эрсдэлээ буруу тооцох, гэмт этгээд, зөрчил гаргагчийг зайнаас аюулгүй болгох тусгай хэрэгсэл дутмаг болон бусад олон зүйлээс шалтгаалж байна.

Мөн архи, согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн, албан тушаал, эрх мэдэл, танил тал, хөрөнгө мөнгө, хүч бяраар далайлгасан зарим иргэд цагдаагийн алба хаагчийн шаардлага, үйл ажиллагааг эсэргүүцэж, эрх чөлөөнд нь халдахаас буцахгүй хандлагатай, энэхүү үйлдлийнхээ үр дагаврыг мэддэггүй, мэдсэн ч давуу байдлаа ашиглан ял шийтгэлгүй үлдэнэ гэсэн сөрөг итгэл үнэмшилтэй байгаа нь алба хаагчийн аюулгүй байдалд учрах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Бидний хийсэн судалгаагаар цагдаагийн алба хаагч халдлагад өртсөн үйлдлүүдээс 185 үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж, 143 хэргийг шүүхэд шилжүүлж, 34 хэргийг хэрэгсэхгүй болгож, 6 хэргийн хэрэг бүртгэлтийг хааж тус тус шийдвэрлэсэн бөгөөд 2 хэргийг түдгэлзүүлсэн байна.²

Нийт 197 үйлдэлд Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулснаас 182 үйлдэлд торгуулийн, 12 үйлдэлд баривчлах шийтгэл тус тус оногдуулж, 3 зөрчилд эрх хасах нэмэлт албадлагын арга хэмжээ авчээ. Тээврийн цагдаагийн алба, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул, Багахангай дүүрэг, Төмөр зам дахь цагдаагийн газар, хэлтэс, Баянхонгор, Булган, Говь-Алтай, Говьсүмбэр, Дорнод, Өвөрхангай, Өмнөговь, Орхон, Завхан, Увс, Хэнтий аймаг дахь цагдаагийн газар, хэлтэст цагдаагийн алба хаагчид албан үүрэг гүйцэтгэх үедээ гэмт хэргийн шинжтэй нийт 41 халдлагад өртсөн боловч шалгах эрх бүхий албан тушаалтнууд шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахдаа хууль буруу хэрэглэж Зөрчлийн тухай хуулиар шийтгэл оногдуулж шийдвэрлэсэн нь удирдах албан тушаалтнуудын зүгээс хяналт сул байгааг харуулж байна.

¹⁸¹ Лхагвасайхан, Н. Цагдаагийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй байдал. -Уб., 2023. Хууль зүйн зэрэг горилсон бүтээлийн 43-44 дэх тал

² Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлын өнөөгийн байдал 2018-2019. Судалгааны тайлан. -Уб. 2019. 4 дэх тал

Цагдаагийн алба хаагчдын халдлагад өртөх явдал 2017 оноос хойш жил бүр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд Улаанбаатар цагдаагийн хүрээний анги, байгууллагаас Багануур дүүрэг дэх цагдаагийн хэлтэс, Төмөр зам дахь цагдаагийн газар, Тээврийн цагдаагийн алба, орон нутаг дахь цагдаагийн газар, хэлтсээс Увс, Баянхонгор, Дорнод, Сэлэнгэ, Өвөрхангай аймаг дахь цагдаагийн газрын алба хаагчид гэмт халдлагад олон өртсөн байна.

Албан үүргээ гүйцэтгэх явцдаа амь насаа алдсан алба хаагчдад тухайн байгууллагын Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комиссоос ослын шалтгаан нөхцөлийг судлан бүртгэж, үйлдвэрлэлийн ослын актыг эрх бүхий байгууллагаар баталгаажуулан Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.1 дэх хэсэгт зааснаар тэдний ар гэрт нөхөх олговор олгожээ.

Дээрх судалгааны дүнгээс харахад албан үүргээ гүйцэтгэх явцдаа бэртэж гэмтсэн нийт 165 тохиолдолд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”³-д заасны дагуу “Үйлдвэрлэлийн ослын акт” тогтоох шаардлагатай байснаас 29 тохиолдолд ослын акт тогтоож, 136 тохиолдолд ослын акт тогтоогоогүй орхигдуулж, алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчжээ. ЦЕГ-ын Аюулгүй байдлын хэлтэс үүн дээр анхаарлаа хандуулж, ослын акт тогтоогоогүй орхисон нь анхаарал татаж байна.¹⁸²

Мөн албан үүргээ гүйцэтгэж яваад гэмт халдлагын улмаас хүнд гэмтсэн 7 алба хаагчид Цагдаагийн албаны тухай хуулийн 86 дугаар зүйлийн 86.3 дахь хэсэг¹, Засгийн газрын 2017 оны 249 дүгээр тогтоолоор баталсан “Цагдаагийн алба хаагчид нөхөх олговор, мөнгөн тусламж олгох журам”-д тус тус заасны дагуу нөхөх олговор, мөнгөн тусламж олгоогүй нь “Байгууллагын үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус байнгын комисс”-ын үйл ажиллагаа хангалтгүй, комиссын гишүүд болон удирдах албан тушаалтнууд энэ чиглэлийн эрх зүйн актыг судлаагүй байгаатай холбоотой гэж үзэж байна.

Сүүлийн үед бүртгэлгүй жагсаал цуглаан зохион байгуулагдах явдал улам нэмэгдэж, төр, засгийн эсрэг бусдыг уриалан турхирах, нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг эвдэж гэмтээх, цагдаагийн алба хаагчдын хууль ёсны тавьсан шаардлагыг эсэргүүцэх, биед нь халдах, эд хөрөнгийн хохирол учруулах явдал улам нэмэгдэх хандлагатай болж байгаа. Зөвхөн 2022 оны 12 дугаар сард болсон жагсаал, цуглааны үеэр цагдаагийн алба хаагчдаас албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт хэргийн шинжтэй 21 үйлдэлд 30 алба хаагч өртөж хохирсон тохиолдол бүртгэгдсэн байна.

Хууль сахиулагчдын хууль ёсны тавьсан шаардлагыг эсэргүүцэх, биед нь халдах, эд хөрөнгийн хохирол учруулахтай холбоотой үйлдэлд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхтэй холбоотой дараах зохицуулалтууд байна. Тухайлбал:

Эрүүгийн хуулийн хорин гуравдугаар бүлэг /нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг/-ийн 23.1 дүгээр зүйлд “Хууль сахиулагчийг эсэргүүцэх”-тэй холбоотой үйлдэлд хүлээлгэх хариуцлагын талаар зохицуулалт орсон байна.

Уг хуулийн 23.1.1-д “Хууль сахиулагчийг албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”¹⁸³ гэж заажээ.

Харин гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдлыг хуулийн 23.2-д нарийвчлан зааж өгчээ. Тухайлбал, энэ гэмт хэргийг:

2.1.галт зэвсэг, зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж;

³ <https://legalinfo.mn/mn/detail/11263>. //Татаж үзсэн: 2022.09.10

¹⁸² Лхагвасайхан, Н. Цагдаагийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй байдал. -Уб., 2023. Хууль зүйн зэрэг горилсон бүтээлийн 127-128 дахь тал

¹ Төрийн мэдээлэл. 2017. №28. Цагдаагийн албаны тухай хууль

¹⁸³ Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/

2.2.хууль сахиулах албаны тоног төхөөрөмж, барилга, байгууламжид халдаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ¹⁸⁴ хэмээн эрүүгийн хариуцлагыг хүндрүүлж өгсөн байна.

Гэвч сүүлийн жилүүдэд цагдаагийн алба хаагчдын албан үүргээ биелүүлэхтэй нь холбогдуулан хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлж эсэргүүцсэн үйлдлийг Эрүүгийн хуулиар бус, ихэвчлэн Зөрчлийн тухай хуулиар зүйлчилж, хариуцлага тооцож байна.

Энэ нь эргээд цагдаагийн алба хаагчдын тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэж болдог юм байна, биед нь халдаж, техник хэрэгсэл, эд хөрөнгийг нь эвдэж гэмтээвэл торгуулаад өнгөрдөг юм байна гэсэн ойлголтыг нийгэмд өгч, тэр нь эргээд цагдаагийн алба хаагчдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгийн аюулгүй байдал алдагдах нөхцөлийг бий болгож байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд олон нийтийн цахим сүлжээнд иргэд хууль сахиулагчидтай харьцсан, хэл амаар доромжлох, биед нь халдах, эд зүйлийг эвдэж гэмтээх үйлдлийг гаргасан зураг, бичлэгээ тавих зэргээр нийтэд сөрөг нөлөө үзэж, цагдааг үзэн ядуулах, хийсэн бүтээсэн зүйлийг нь харлуулах зэрэг сөрөг үзэгдэл газар авах хандлагатай болж байна.

Цагдаагийн алба хаагчдын албан үүрэг гүйцэтгэхтэй холбоотойгоор биед нь халдах, эрүүл мэнд, эд хөрөнгө, нэр төрөөрөө хохирох явдал гарч байгаа талаар төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн 42 алба хаагчдыг түүврийн аргаар сонгон авч, судалгаа явуулж хандлагыг тодорхойлохыг чармайлаа.

Судалгаанд оролцсон алба хаагчдын насны байдлыг авч үзвэл 1 буюу 2.4% нь “18-24”, 8 буюу 19% нь “25-29”, 24 буюу 57.1% нь “30-34”, 8 буюу 19% нь “35-39”, 1 буюу 2.4% нь “40-44” настай алба хаагчид хамрагджээ. Хүйсийн байдлыг авч үзвэл 34 буюу 81% нь “эрэгтэй”, 8 буюу 19% нь “эмэгтэй” алба хаагчид байна.

Судалгаанд оролцогчдын боловсролын байдлыг авч үзвэл 33 буюу 78.6% нь “Дээд”, 3 буюу 7.1% нь “Тусгай дунд”, 6 буюу 14.3% нь “Бүрэн дунд” боловсролтой бөгөөд 13 буюу 31.7% нь “эрх зүйч”, 28 буюу 68.3% нь “эрх зүйч бус” алба хаагчид эзэлж байна.

Цагдаагийн байгууллагад ажилласан жилийг нь авч үзвэл 12 буюу 28.6% нь “4-6 жил”, 14 буюу 33.3% нь “7-10 жил”, 13 буюу 31% нь “11-15 жил”, 3 буюу 7.1% нь “16-20 жил” ажилласан алба хаагчид эзэлж байна. Судалгаанд оролцогчдын ажлын байрны харьяаллыг авч үзвэл 10 буюу 23.8% нь “НХЖХОНАБХА”, 2 буюу 4.8% нь “Эрүүгийн цагдаа”, 7 буюу 16.7% нь “Шуурхай удирдлага буюу жижүүрийн алба”, 7 буюу 16.7% нь “Замын цагдаагийн газар”, 5 буюу 11.9% нь “Захиргааны албан тушаалтан”, 11 буюу 26.2% нь бусад алба, нэгжид ажилладаг алба хаагчид байна.

Судалгаанд оролцогчдын төгссөн сургуулийг авч үзвэл 17 буюу 41.5% нь “Цагдаагийн академи, Дотоод хэргийн их сургууль”, 12 буюу 29.3% нь “Төрийн бусад их, дээд сургууль”, 12 буюу 29.3% нь “Хувийн их, дээд сургууль” төгссөн байна.


“Та албан үүрэг гүйцэтгэх явцдаа гэмт халдлагад өртөж байсан уу?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 20 буюу 47.6% нь “Тийм”, 22 буюу 52.4% нь “Үгүй”, 2 хүн асуултад хариулаагүй байна.

“Та албан үүрэг гүйцэтгэсний улмаас гэмт халдлагад өртөхдөө ямар хохирол амссан бэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 5 буюу 11% нь “Эрүүл мэнд”, 3 буюу 7% нь “Албаны техник хэрэгсэл”, 7 буюу 16% нь “Нэр төр, алдар хүнд”, 9 буюу 21% нь “Дүрэмт хувцас”, 12 буюу 27% нь “бусад” хохирол амссан гэсэн хариултыг өгч, 8 буюу 16% нь хариулт өгөөгүй байна.

Халдлагын хохирол. График №1.

¹⁸⁴ Төрийн мэдээлэл. 2016. №07. Эрүүгийн хууль

Та албан үүрэг гүйцэтгэсэний улмаас гэмт халдлагад өртөхдөө ямар хохирол амссан бэ



Судалгаанд оролцогчид “Цагдаагийн алба хаагчид албан үүрэг гүйцэтгэх явцад ямар халдлагад ихэвчлэн өртдөг вэ?” гэсэн асуултад 21 буюу 48% нь “Зүй бус харилцах, хэл амаар доромжлох”, 7 буюу 16% нь “Дүрэмт хувцас урж тасдуулах”, 6 буюу 14% нь “Биед халдаж эрүүл мэндээрээ хохирох”, 5 буюу 14% нь “Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан бичлэг хийж, цахим сүлжээнд тавин хувийн болон албаны нэр төрд халдах”, 3 буюу 7% нь “бусад зөрчил”-д өртөж хохирдог тухай хариулж, 2 буюу 4% нь хариулт өгөөгүй байна.


Дээрх хариултаас үзвэл цагдаагийн алба хаагчид албан үүрэг гүйцэтгэх явцдаа халдлагад өртөх явдал түгээмэл гарч, эрүүл мэнд, албаны эд хөрөнгөөрөө хохирох, улмаар албаны нэр төр, алдар хүнд олон нийтийн дунд унах нэг хүчин зүйл болох нөхцөл болсон байна.

Сүүлийн жилүүдэд иргэд хэрэг, зөрчил үйлдчихээд цагдаагийн алба хаагчдын албан үүрэг гүйцэтгэж буй үйл явдлыг бичлэг хийх замаар олон нийтийн цахим сүлжээнд тавьж нэр төрийг нь гутаах явдал түгээмэл гарч байгааг цаашид анхаарвал зохих асуудал гэж үзэж байна.

Цагдаагийн алба хаагчдын албан үүрэг гүйцэтгэх явцдаа халдлагад өртөж байгаа хэлбэрийг нь графикт оруулан харвал:

Халдлагын хэлбэр. График №2.

Цагдаагийн алба хаагчид албан үүрэг гүйцэтгэх явцад ямар халдлагад ихэвчлэн өртдөг вэ?



“Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан тан /цагдаагийн алба хаагч/-д халдсан этгээдэд хариуцлага хүлээсэн үү?” асуултад 40 алба хаагч оролцож хариулт

өгч, 4 алба хаагч хариултад оролцоогүй байна. Дээрхи асуултад судалгаанд оролцогчдын 16 буюу 36% нь “Үгүй”, 14 буюу 35% нь “Тийм”, 10 буюу 23% нь “Зарим тохиолдолд” гэсэн хариултыг өгч, 4 буюу 9% нь хариулт өгөөгүй байна.


Халдагчид хариуцлага хүлээсэн эсэх. График №3



Судалгаанд оролцсон алба хаагчдын өгсөн дээрх хариултаас үзвэл дийлэнх буюу 59% нь халдлагад их, бага ямар нэг хэмжээгээр өртөж байгаа нь цагдаагийн байгууллагын удирдлага анхааралдаа авч цаашдаа бодлогын хэмжээнд асуудал болгон авч үзэх шаардлага бий болжээ.

“Албан үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан тан /цагдаагийн алба хаагч/-д халдсан этгээдэд ямар төрлийн хариуцлага хүлээлгэж байна вэ?” асуултад 39 алба хаагч оролцож хариулт өгч, 5 алба хаагч хариултад оролцоогүй байна. Дээрх асуултад судалгаанд оролцогчдын 20 буюу 46% нь “Зөрчлийн хуулиар”, 3 буюу 7% нь “Эрүүгийн хуулиар”, 7 буюу 16% нь “Хохирлоо барагдуулаад торгох”, 1 буюу 3% нь “Мөнгө аваад зохицсон”, 8 буюу 18% нь “Бусад” буюу анхааруулж, сануулаад явуулсан” гэсэн хариултыг өгч, 5 буюу 11% нь хариулт өгөөгүй байна.

Халдагчдад хүлээлгэсэн хариуцлага. График №4




Дээрх хариултаас үзвэл цагдаагийн алба хаагчдын албан үүрэгтэй нь холбогдуулан халдсан этгээдэд ихэвчлэн Зөрчлийн хуулиар торгуулийн арга хэмжээ

авч байгаа нь харагдаж байгаа, нөгөө талаараа алба хаагчид хохирлоо барагдуулсны дараа арга хэмжээ авалгүй орхидог явдал түгээмэл байгаа нь алба, нэгжийн дарга нарын анхаарвал зохих асуудал гэж харж байна.

“Цагдаагийн алба хаагч албан үүрэг гүйцэтгэх явцдаа халдлагад өртөөд байгаа явдлыг та юу гэж үзэж байна вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 42 нь хариулж, 2 алба хаагч хариулаагүй байна. Судалгаанд оролцогчдын өгсөн хариултыг графикаар үзвэл:

Халдлагад өртөж буй учир шалтгаан. График №5



Судалгаанд оролцогчдын 17 буюу 41% нь “Цагдаагийн алба хаагчид халдсан этгээдийг шалгаж хариуцлага хүлээлгэх ажил хангалтгүй явагддаг”, 11 буюу 26% нь “Цагдаагийн алба хаагчид халдсан этгээдэд хүлээлгэх хариуцлага сул”, 1 буюу 2% нь “Цагдаагийн алба хаагчид дээд шатны даргадаа мэдэгдэхгүй орхидог”, 2 буюу 5% нь “Цагдаагийн алба хаагчдын хэнэггүй, хайхрамжгүй байдлаас болдог”, 6 буюу 14% нь “Цагдаагийн газар, хэлтэс, нэгжийн дарга нар алба хаагчдынхаа халдлагад өртсөн байдалд төдийлөн ач холбогдол өгдөггүй”, 4 буюу 10% нь “Цагдаагийн газар, хэлтэс дээр алба хаагчдынхаа аюулгүй байдалд анхаарал хандуулж, бүртгэл судалгаанд хамруулдаггүй”, 1 буюу 2% нь “бусад” гэсэн хариултыг тус тус хариултыг өгсөн байна.

Дээрх хариултаас үзвэл нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн газар, хэлтэс, тасаг, нэгжийн дарга нар алба хаагчдын аюулгүй байдалд анхаарал бага хандуулдаг, халдлага өртсөн тохиолдолд тухайн этгээдэд хариуцлага хүлээлгэх тал дээр хангалтгүй ажилладаг, бүртгэл судалгаанд дутуу хамруулдаг байдал түгээмэл байгаа нь анхаарал татаж байна. Түүнчлэн алба хаагчдын дунд аюулгүй байдлыг хэрхэн хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, халдлагад өртсөн тохиолдолд хэрхэн арга хэмжээ авах талаар сургалт дутмаг байгаатай холбон үзэж болохоор байна.

Судалгаанд оролцогчид “Цагдаагийн алба хаагчид албан үүрэг гүйцэтгэхдээ халдлагад өртдөг байдлыг бууруулах чиглэлээр ямар ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлбэл зохистой вэ? гэсэн асуултад 42 алба хаагч хариулт өгч, 2 алба хаагч хариулаагүй байна.

Гэмт халдлагыг бууруулах арга зам. График



Дээрх графикаас үзвэл судалгаанд оролцогчдын 19 буюу 45% нь “а. Халдсан этгээдэд хүлээлгэх хариуцлагыг нэмэгдүүлэх”, 7 буюу 17% нь “Халдлагад өртсөн тохиолдол бүрийг бүртгүүлж, халдсан этгээдийг шалгах арга хэмжээг авч хэвших”, 4 буюу 9% нь “Алба хаагчдын аюулгүй байдлаа хангах чадавхыг нэмэгдүүлэх”, 12 буюу 29% нь “Эрх зүйн хамгаалалтыг сайжруулах” гэсэн хариултыг тус тус өгчээ.

Энэ нь цагдаагийн алба хаагчид цаашид аюулгүй байдлаа хангахтай холбоотой ажил, арга хэмжээ авч хэрэгжүүлэх арга замын талаар өөрсдийн санаа бодлыг илэрхийлж байгаа нэг хэлбэр гэж үзэж болохоор байна.

Дүгнэлт

Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдал хэр сайн хангагдаж чадна, тэр хэмжээгээр ажил үүргээ хэвийн гүйцэтгэж, иргэд олон нийтийн аюулгүй байдал хангагдах нөхцөл бий болох учраас энэ асуудалд анхаарал хандуулах нь нэг талаараа алба хаагчийн аюулгүй байдал яригдана, нөгөө талаараа нийгмийн аюулгүй байдал давхар хөндөгдөх учир анхаарвал зохих асуудал гэж харж байна.

Цагдаагийн алба хаагчид хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх явцдаа гэмт халдлагад өртөж, эрүүл мэнд, эд хөрөнгөөрөө хохирох, албаны техник хэрэгслээ эвдүүлж өрөнд орох, халдлага хийсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхгүй орхих явдал түгээмэл гарч байгаа нь бидний хийсэн судалгаанаас харагдаж байна.

Цагдаагийн алба хаагчид албан үүрэг гүйцэтгэх явцдаа халдлагад өртөж байгаа нь а)Алба хаагчид өөрийн аюулгүй байдлаа хангах чадвар дутагдаж байгаа, б)Халдлага үйлдсэн этгээд хүлээлгэх хариуцлага сул, в)Бүртгэл судалгаанд дутуу хамруулдаг, г)Цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдалтай холбоотой эрх зүйн мэдлэг дутмаг, д)Нэгжийн дарга нарын хайхрамжгүй, анхаарал дутуу тавьдгаас үүдэлтэй гэж үзэж болохоор байна. Дээрх хүчин зүйлийг арилгах, халдлагыг бууруулах боломж бололцоо байгаа нь нэг талаараа нэгжийн дарга нарын идэвх санаачилга, нөгөө талаараа алба хаагчдын эрх зүйн мэдлэг, аюулгүй байдлаа хангах ур чадвараас хамааралтай байна.

Санал

Дээрх дүгнэлтэд үндэслэн дараах санал дэвшүүлж байна. Үүнд:

- Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага бүр цагдаагийн алба хаагчдын аюулгүй байдал, түүнийг хангах ур чадвар олгох арга зүйн сургалт болон өртсөн тохиолдолд авах арга хэмжээний талаар эрх зүйн сургалтыг жилд нэгээс доошгүй удаа явуулж байх;
- Цагдаагийн төв байгууллагын дотоод аюулгүй байдал хариуцсан нэгж жилд нэгээс доошгүй удаа нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага, алба, нэгж рүү очиж, алба хаагчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр явуулж буй ажил, арга хэмжээг шалгаж, бүртгэл судалгаанд хамруулж байгаа эсэхийг нягтлан шалгаж байх;
- Цагдаагийн алба хаагчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага болон алба, нэгжийн дарга санаачлагатай ажиллаж байгаа тал дээр хяналт тавих;
- Цагдаагийн алба хаагчдын албан үүрэг гүйцэтгэж байгаа үеийн бичлэгийг хийж, олон нийтийн цахим сүлжээнд тавьж, нэр төрд нь халдаж байгаа явдлыг таслан зогсоох чиглэлээр цагдаагийн төв байгууллагаас тодорхой ажил, арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

Ашигласан материал

Монгол Улсын хууль

- Монгол Улсын Үндсэн хууль
- Цагдаагийн албаны тухай хууль
- Эрүүгийн хууль

Ном, сурах бичиг, гарын авлага:

- Б.Энхболд. Хотжилт ба гэмт явдал. УБ. 2011.
- Б.Баянмөнх. Цагдаагийн байгууллагын олон нийтийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа. УБ. 2018.

Судалгааны ажил:

- Н.Лхагвасайхан, Цагдаагийн алба хаагчийн үүрэг гүйцэтгэх үеийн аюулгүй байдал. УБ. 2023. Хууль зүйн зэрэг горилсон бүтээл
- Цагдаагийн алба хаагчийн аюулгүй байдлын өнөөгийн байдал 2018-2019. Судалгааны тайлан. УБ. 2020.

Сонин, сэтгүүл:

- Төрийн мэдээлэл. 1992. №1.
- Төрийн мэдээлэл. 2016. №07.
- Төрийн мэдээлэл. 2017. №28

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ХАР ТАМХИТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

ANALYSIS ON CURRENT SITUATION OF HUMAN RESOURCES MANAGEMENT
(COUNTER NARCOTICS DEPARTMENT OF THE NATIONAL POLICE AGENCY)

Ц.Хишигбаяр
ДХИС-ийн Удирдлагын академийн
7081 дүгээр дамжааны суралцагч
Б.Эрдэнэдалай
Доктор (Ph.D)

Товч агуулга: Цагдаагийн байгууллагын Хар тамхитай тэмцэх газрын гадаад, дотоод орчныг алба хаагчдаар үнэлүүлэн байгууллагын хүний нөөцийн зохион байгуулалтын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлохын тулд PESTLE шинжилгээний арга зүйгээр судалж, үр дүнг нэгтгэв.

Abstract: In order to determine the current state of the Counter Narcotics Department's organizational arrangement of human resources the internal and external environment of the organization was evaluated by officers according to the questionnaire developed by the PESTLE analysis methodology, as a part of the research.

Түлхүүр үгс: Байгууллага, хүний нөөц удирдлага, нөлөөлөх хүчин зүйлс.

Keywords: Organization, human resources management, affecting factors.

УДИРТГАЛ


Судалгааны ажлын үндэслэл: Мансууруулах эм, сэтгэгцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэж буй олон улсын туршлагыг судлахад энэ төрлийн гэмт явдалтай амжилттай тэмцэх хүчин зүйлс нь боловсронгуй эрх зүйн орчин, чиг үүргийн байгууллагын хамтын ажиллагаа, шинжлэх ухаан, технологийн амжилт, ололтод түшиглэсэн мэргэшсэн үйл ажиллагаа, алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, өндөр ур чадвар, хандлага, тэдгээрийн ухамсар, хариуцлага, ёс суртахуун бөгөөд эдгээр хүчин зүйлд шинжлэх ухааны үндэслэлтэйгээр дүн шинжилгээ хийх зайлшгүй шаардлага үүсжээ.

Хар тамхитай тэмцэх байгууллагын үйл ажиллагаа, түүнд нөлөөлж буй гадаад, дотоод орчны хүчин зүйлийг онол, практик талаас нь өнөөг хүртэл цогц байдлаар судалсан судалгааны ажил цөөн байгааг дурдах нь зүйтэй.

Судалгааны арга зүй: PESTLE (P-Political-улс төр, E-Economic-эдийн засаг, S-Social-нийгэм, T- Technological-технологи, L-Legal-эрх зүйн орчин гэсэн утгатай үгсийн товчлол, томъёолол) шинжилгээ хийх арга зүйгээр судалж, үр дүнг нэгтгэн дүгнэсэн.

Судалгааны объект: Судалгаанд оролцсон алба хаагчид 100 хувь төрийн тусгай албан тушаалтай, ажилласан жилийн хувьд 1-3 жил ажилласан 6 алба хаагч, 3.1-5 жил ажилласан 12 алба хаагч, 5.1-10 жил ажилласан 15 алба хаагч, 10.1-15 жил ажилласан 17 алба хаагч, 15.1-20 жил ажилласан 5 алба хаагч, 20-оос дээш жил ажилласан 9 алба хаагч тус тус хамрагдсан.

График 1. Алба хаагчдын ажилласан жил ХТТГ-ын алба хаагчдын судалгаа



Үндсэн хэсэг

Хар тамхитай тэмцэх газрын үйл ажиллагааны тогтвортой байдал, удирдлагын шийдвэр, албан хаагчийг мэргэшүүлэх сургалт, дотоод шилжилт хөдөлгөөн, албан томилгоо зэрэг асуултуудад өгсөн үнэлгээг давуу болон сул тал, боломж болон аюул занал, хариулах боломжгүй хувилбараар нэгтгэн тоо болон хувийн харьцуулалтаар харуулав.

Тухайн байгууллагын хүний нөөцийн зохион байгуулалтын төлөв байдал, түүнд нөлөөлж буй магадлал бүхий улс төрийн хүчин зүйлийг илэрхийлэх таван асуултыг ажилласан жил, албан тушаалтай хамааруулан судалсан. Ийнхүү шинжлэхэд, албан тушаал албан томилгоо 0.837**, албан тушаал удирдах газрын шийдвэртэй 0.937**, удирдах газрын гаргах шийдвэр алба хаагчдыг мэргэшүүлэх сургалттай 0.873**, алба хаагчийн мэргэшүүлэх сургалт дотоод шилжилт хөдөлгөөнтэй 0.902** хамгийн их хамааралтай байна. Шинжилгээний үр дүнгээс албан томилгоо, удирдах газрын гаргаж буй шийдвэр нь алба хаагчдыг мэргэшүүлэх сургалт, дотоод шилжилт хөдөлгөөн ихээхэн хамаардаг гэсэн дүгнэлт өгөх боломжтой.

Хүснэгт 1. Улс төрийн хүчин зүйлийн үнэлгээ
ХТТГ-ын алба хаагчдаас авсан судалгаа

Үзүүлэлт	Үйл ажиллагаа тогтвортой байдал		Удирдах газрын гаргаж буй шийдвэр		Алба хаагчийг мэргэшүүлэх сургалт		Дотоод шилжилт хөдөлгөөн		Албан томилгоо	
Давуу тал	32	56.6%	30	52.8%	16	26.4%	10	15.1%	17	28.3%
Сул тал	8	11.3%	14	20.8%	22	35.8%	26	45.3%	19	30.2%
Боломж	16	24.5%	10	15.1%	18	30.2%	18	28.3%	19	30.2%
Аюул занал	3	1.9%	7	9.4%	3	1.9%	6	7.5%	9	11.3%
Мэдэхгүй	5	5.7%	3	1.9%	5	5.7%	4	3.8%	0	0
НИЙТ	64		64		64		64		64	

Хүснэгт 2. Ажилласан жил, албан тушаал ба улс төрийн хүчин зүйлийн хамаарал
ХТТГ-ын алба хаагчдаас авсан судалгаа

ҮЗҮҮЛЭЛТ	Албан тушаал	[a]	[p1]	[p2]	[p3]	[p4]	[p5]
Албан тушаал	1.000						
Ажилласан жил	0.127	1.000					
Үйл ажиллагааны тогтвортой байдал	.595**	0.053	1.000				
Удирдах газрын гаргасан шийдвэр	.623**	0.035	.937**	1.000			
Алба хаагчийг мэргэшүүлэх сургалт	.767**	0.179	.913**	.866**	1.000		
Дотоод шилжилт хөдөлгөөн	.718**	0.267	.877**	.873**	.902**	1.000	
Албан томилгоо	.837**	0.12	.705**	.741**	.746**	.714*	1.000
Нийт	64	64	64	64	64	64	64

Алба хаагчдаас авсан судалгаанд, байгууллагын хүний нөөцийн зохион байгуулалтын төлөв байдал, түүнд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйлийг шинжлэхэд, төсвөөс авдаг санхүүжилт, цол, тусгай албаны нэмэгдэл, удаан жил ажилласны нэмэгдэл нь давуу тал; улсын төсвөөс авах санхүүжилт сул тал; төсвөөс авдаг санхүүжилт, улсын төсвөөс гадуур санхүүжилт цол, тусгай албаны нэмэгдэл, хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдал, удаан жил ажилласны нэмэгдэл бүгд боломж гэдгийг алба хаагчид тодорхойлсон үр дүнтэй байна.

Албан тушаал, ажилласан жил нь эдийн засгийн хүчин зүйлтэй хэрхэн хамааралтай байгааг шалгахад, улсын төсвөөс авах санхүүжилтийг цол, тусгай албаны нэмэгдэлтэй 0.908**; төсвөөс авдаг санхүүжилт нь хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдалтай 0.901**; улсын төсвөөс гадуур санхүүжилт олох байдал нь хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдалтай 0.942**; цол тусгай албаны нэмэгдэл нь хамтын ажиллагаанд төсвөөс олгосон мөнгөн хуваарилах байдалтай 0.864** тус тус хамаарал өндөртэй үр дүн гарсан. Ажилласан жил болон удаан жил ажилласны нэмэгдэл авдаг байдал хамаарал бага ба -0.016 байгаа нь Хар тамхитай тэмцэх газар ажиллаж байгаа алба хаагчдын ажилласан жил харьцангуй бага байгааг илтгэсэн.

Шинжилгээний үр дүнгээс, тухайн байгууллага нь төсвөөс санхүүждэг тул төсвөөс олгож байгаа санхүүжилт нь цол, тусгай албаны нэмэгдэл, хамтын ажиллагаанд шууд зарцуулагддаг гэсэн дүгнэлтийг өгөх боломжтой.

Хүснэгт 3. Эдийн засгийн хүчин зүйлийн үнэлгээ

ХТТГ-ын алба хаагчдын судалгаа

Үзүүлэлт	Төсвөөс авдаг санхүүжилт		Улсын төсвөөс гадуур санхүүжилт		Цол, тусгай албаны нэмэгдэл		Хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдал		Удаан жил ажилласны нэмэгдэл	
Давуу тал	36	62.3%	27	45.3 %	41	71.7 %	23	37.7 %	35	60.4 %
Сул тал	13	17.0%	20	32.1 %	8	9.4%	20	32.1 %	8	9.4%
Боломж	9	13.2%	6	7.5%	12	17.0 %	12	17.0 %	18	28.3 %
Аюул занал	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мэдэхгүй	6	7.5%	11	15.1 %	3	1.9%	9	13.2 %	3	1.9%
НИЙТ	64		64		64		64		64	

Хүснэгт 4. Ажилласан жил, албан тушаал ба эдийн засгийн хүчин зүйлийн хамаарал

ХТТГ-ын алба хаагчдын судалгаа

ҮЗҮҮЛЭЛТ	Албан тушаал	[a]	[e1]	[e2]	[e3]	[e4]	[e5]
Албан тушаал	1.000						
Ажилласан жил	.127	1.000					
Төсвөөс авдаг санхүүжилт	.537**	.105	1.000				
Улсын төсвөөс гадуур санхүүжилт	.619**	.019	.913**	1.000			
Цол, тусгай албаны нэмэгдэл	.445**	.149	.908**	.883**	1.000		
Хамтын ажиллагаанд төсвөөс мөнгө хуваарилах байдал	.680**	.109	.901**	.942**	.864**	1.000	
Удаан жил ажилласны нэмэгдэл	.584**	-.016	.670**	.610**	.549**	.636**	1.000
Нийт	64	64	64	64	64	64	64

Алба хаагчдаас авсан судалгаанд, байгууллагын хүний нөөцийн зохион байгуулалтын төлөв байдал, түүнд нөлөөлж буй нийгмийн хүчин зүйлийг шинжлэхэд, аюулгүй байдал, байгууллагын үйл ажиллагааны гадаад хамтын ажиллагаа,

туршлагатай, багийн үйл ажиллагаа, мэргэшүүлэх сургалтад хамрагдалт, мэргэжлийн ур чадвар нь давуу тал, боломж болсон байна.

Албан тушаал, ажилласан жил нь нийгмийн хүчин зүйлтэй хэрхэн хамааралтай байгааг шалгахад, албан тушаалын ангиллаар мэргэшүүлэх сургалтад хамрагдах хамаарал 0.736**; аюулгүй байдал нь гадаад хамтын ажиллагаатай 0.540**; гадаад хамтын ажиллагаа ба мэргэшүүлэх сургалтад хамрагддаг байдал нь 0.841**; туршлагатай багийн үйл ажиллагаа нь мэргэшүүлэх сургалтад хамрагдах хамаарал 0.830**; гадаад хамтын ажиллагаа нь мэргэжлийн ур чадвартай 0.794**, мэргэшүүлэх сургалт мэргэжлийн ур чадварын хоорондын хамаарал 0.825** тус тус өндөр хамааралтай байна. Харин ажилласан жил аюулгүй байдал, байгууллагын үйл ажиллагааны гадаад хамтын ажиллагаа, туршлагатай, багийн үйл ажиллагаа, мэргэшүүлэх сургалтад хамрагдалт, мэргэжлийн ур чадвартай хамаарал бага -0.036-0.119 хооронд байгаа нь тусгай чиг үүргийн алба хаагчдад ажилласан жилийн ялгаа бага байгааг илтгэсэн. Энэ шинжилгээний үр дүнгээс, тухайн байгууллага нь туршлагатай, ур чадвартай алба хаагчидтай, гадаад хамтын ажиллагаа сайн, мэргэшүүлэх сургалтад хамрагддаг гэсэн дүгнэлтийг өгөх боломжтой.

Хүснэгт 5. Нийгмийн хүчин зүйлийн үнэлгээ
ХТТГ-ын алба хаагчдын судалгаа (N:53)

Үзүүлэлт	Аюулгүй байдал		Гадаад хамтын ажиллагаа		Туршлагатай, багийн үйл ажиллагаа		Мэргэшүүлэх сургалтад хамрагдалт		Мэргэжлийн ур чадвар	
Давуу тал	29	49.1 %	29	49.1 %	39	66.0 %	30	49.1 %	35	58.5 %
Сул тал	21	34.0 %	13	18.9 %	11	15.1 %	14	20.8 %	9	11.3 %
Боломж	11	15.1 %	19	30.2 %	14	18.9 %	20	30.2 %	20	30.2 %
Аюул занал	0	0	0	0	0	0	0	0	0	0
Мэдэхгүй	3	1.9%	3	1.9%	0	0	0	0	0	0
НИЙТ	64		64		64		64		64	

Хүснэгт 6. Ажилласан жил, албан тушаал ба нийгмийн хүчин зүйлийн хамаарал
ХТТГ-ын алба хаагчдаас авсан судалгаа

ҮЗҮҮЛЭЛТ	Албан тушаал	[a]	[s1]	[s2]	[s3]	[s4]	[s5]
Албан тушаал	1.000						
Ажилласан жил	.127	1.000					
Аюулгүй байдал	.662**	-.036	1.000				
Гадаад хамтын ажиллагаа	.704**	-.047	.840**	1.000			
Туршлагатай, багийн үйл ажиллагаа	.527**	-.025	.444**	.728**	1.000		
Мэргэшүүлэх сургалтад хамрагдалт	.736**	-.124	.664**	.841**	.830**	1.000	
Мэргэжлийн ур чадвар	.630**	-.119	.510**	.714**	.794**	.825**	1.000
Нийт	64	64	64	64	64	64	64

Алба хаагчдаас авсан судалгаанд, байгууллагын хүний нөөцийн зохион байгуулалтын төлөв байдал, түүнд нөлөөлж буй технологийн хүчин зүйлийг шинжлэхэд, мэдээллийн ил тод, нээлттэй байдал; санал, хүсэлт, өргөдөл,

шийдвэрлэлт цахим сургалт, уулзалтын боломж сүлжээний хамгаалалт нь давуу тал болсон ч мэдээллийн ил тод байдлыг сул тал гэж дүгнэхээр хариулттай үр дүн гарсан. Сүлжээний хамгаалалт сайн байгааг боломж үзүүлэлт илтгэж байна.

Албан тушаал, ажилласан жил технологийн хүчин зүйлтэй хэрхэн хамаарахыг шинжлэхэд, мэдээллийн ил тод, нээлттэй байдал нь сүлжээний хамгаалалттай 0.828**;
мэдээлэл алдагдах байдалтай 0.867**;
санал хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт нь сүлжээний хамгаалалттай 0.876**, цахим сургалт, уулзалт нь мэдээлэл алдагдах эрсдэлтэй 0.659**, сүлжээний хамгаалалт нь мэдээлэл алдагдах эрсдэлтэй 0.767** тус тус өндөр хамааралтай байна. Эндээс мэдээллийн ил тод хэдий чинээ их байна тэр хэмжээгээр мэдээлэл алдагдах боломж их, цахим сургалт уулзалтыг зохион байгуулснаар алба хаагчидтай холбоотой мэдээлэл алдагдах эрсдэл өндөр байна гэж дүгнэж байна. Мөн өмнөх асуулттай харьцуулахад ажилласан жил нь мэдээллийн ил тод байдал, нээлттэй байдал; санал, хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт цахим сургалт, уулзалтын боломж сүлжээний хамгаалалт; мэдээлэл алдагдах эрсдэлтэй 0.003-0.306* хүртэл хамааралтай байгаа нь технологийн хүчин зүйл бүх алба хаагчдад хүртээмжтэй байдаг гэх дүгнэлтэд хүргэж байна.

Хүснэгт 7. Технологийн хүчин зүйлийн үнэлгээ

ХТТГ-ын алба хаагчдын судалгаа (N:53)

Үзүүлэлт	Мэдээллийн ил тод, нээлттэй байдал		Санал, хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт		Цахим сургалт, уулзалтын боломж		Сүлжээний хамгаалалт		Мэдээлэл алдагдах эрсдэл	
Давуу тал	26	43.4 %	35	60.4 %	40	67.9 %	22	35.8 %	13	18.9 %
Сул тал	20	32.1 %	14	20.8 %	10	13.2 %	20	32.1 %	31	50.9 %
Боломж	12	17.0 %	12	17.0 %	14	18.9 %	12	18.9 %	10	15.1 %
Аюул занал	6	7.5%	0	0	0	0	6	7.5%	10	15.1 %
Мэдэхгүй	0	0	3	1.9%	0	0	4	5.7%	0	0
НИЙТ	64		64		64		64		64	

Хүснэгт 8. Ажилласан жил, албан тушаал ба технологийн хүчин зүйлийн хамаарал

ХТТГ-ын алба хаагчдаас авсан судалгаа

ҮЗҮҮЛЭЛТ	Албан тушаал	[a]	[t1]	[t2]	[t3]	[t4]	[t5]
Албан тушаал	1.000						
Ажилласан жил	.127	1.000					
Мэдээллийн ил тод, нээлттэй байдал	.713**	.003	1.000				
Санал, хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт	.549*	.090	.663*	1.000			
Цахим сургалт, уулзалтын боломж	.507*	.074	.632*	.604*	1.000		
Сүлжээний хамгаалалт	.730*	.119	.828**	.876**	.679**	1.000	
Мэдээлэл алдагдах эрсдэл	.666*	.306*	.867**	.638**	.659**	.767**	1.000
Нийт	64	64	64	64	64	64	64

Алба хаагчдаас авсан судалгаанд, байгууллагын хүний нөөцийн зохион байгуулалтын төлөв байдал, түүнд нөлөөлж буй хууль эрх зүйн хүчин зүйлийг шинжлэхэд, эрх зүйн орчин бүрдсэн байдал, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийг

хэрэгжилт, урамшууллын эрх зүйн хэрэгжилт, шагнал урамшууллын бодлого, тогтолцоо, хуулийн нэршил, нэр томьёоны хэрэгжилт нь давуу тал болсныг илтгэж байна. Энэ нь цагдаагийн байгууллагын онцлог, тусгай чиг үүрэг хэрэгжүүлдэг тул хууль сахиулах үйл ажиллагаа сайн хэрэгждэг гэж дүгнэв.

Албан тушаал, ажилласан жил технологийн хүчин зүйлтэй хэрхэн хамаарахыг шинжлэхэд, албан тушаал шагнал урамшууллын бодлого 0.748**, гадаад, дотоодын төсөл, нь урамшууллын эрх зүйн хэрэгжилттэй 0.949**, гадаад, дотоодын төсөл нь шагнал, урамшууллын бодлого тогтолцоотой 0.953**, хуулийн нэршил, нэр томьёотой 0.925**, урамшууллын эрх зүйн хүрээний хэрэгжилт нь шагнал урамшууллын бодлого, хэрэгжилттэй 0.924**, хуулийн нэршил, нэр томьёотой 0.869**, шагнал урамшууллын бодлого, хэрэгжилт нь хуулийн нэршил, нэр томьёотой 0.875** тус тус өндөр хамааралтай үр дүнтэй байгаа нь гадаадын төсөл хөтөлбөр хэрэгждэг, хөтөлбөрийн хэрэгжилтээс шагнал, урамшуулах үйл ажиллагаа хэрэгждэгийг харуулж байна.

Хүснэгт 9. Хууль эрх зүйн хүчин зүйлийн үнэлгээ
ХТТГ-ын алба хаагчдаас авсан судалгаа

Үзүүлэлт	Эрх зүйн орчин бүрдсэн байдал		Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийг хэрэгжилт		Урамшууллын н эрх зүйн хүрээний хэрэгжилт		Шагнал урамшууллын н бодлого, тогтолцоо		Хуулийн нэршил, нэр томьёоны хэрэгжилт	
Давуу тал	26	45.3 %	26	45.3 %	30	50.9 %	22	35.8%	27	45.3 %
Сул тал	13	18.9 %	17	26.4 %	13	18.9 %	21	34.0%	23	37.7 %
Боломж	18	30.2 %	14	22.6 %	17	26.4 %	16	24.5%	11	15.1 %
Аюул занал	5	3.8%	3	1.9%	2	1.9%	2	1.9%	3	1.9%
Мэдэхгүй	2	1.9%	4	3.8%	2	1.9%	3	3.8%	0	0
НИЙТ	64		64		64		64		64	

Хүснэгт 10. Ажилласан жил, албан тушаал, хууль эрх зүйн хүчин зүйлийн хамаарал
ХТТГ-ын алба хаагчдаас авсан судалгаа

ҮЗҮҮЛЭЛТ	Албан тушаал	[a]	[L1]	[L2]	[L3]	[L4]	[L5]
Албан тушаал	1.000						
Ажилласан жил	.127	1.000					
Эрх зүйн орчин бүрдсэн байдал	.747**	-.088	1.000				
Гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийг хэрэгжилт	.699**	-.049	.958**	1.000			
Урамшууллын эрх зүйн хүрээний хэрэгжилт	.671**	-.010	.927**	.949**	1.000		
Шагнал урамшууллын бодлого, тогтолцоо	.748**	.114	.921**	.953**	.924**	1.000	
Хуулийн нэршил, нэр томьёоны хэрэгжилт	.744**	-.096	.926**	.925**	.869**	.875**	1.000
Нийт	64	64	64	64	64	64	64

Дүгнэлт

Хар тамхитай тэмцэх газрын хүний нөөцийн зохион байгуулалтын өнөөгийн төлөв байдлыг үнэлэх судалгаанд 64 алба хаагчийг хамруулсан.

Судалгааны ажлыг үр дүнг нэгтгэн дүгнэвэл: Үүнд.

- Албан томилгоо, удирдах газрын гаргаж буй шийдвэр нь алба хаагчдыг мэргэшүүлэх сургалт, дотоод шилжилт хөдөлгөөн ихээхэн хамаарч байна;
- Эдийн засгийн хүчин зүйлийг шинжлэхэд, төсвөөс авдаг санхүүжилт, цол, тусгай албаны нэмэгдэл, удаан жил ажилласны нэмэгдэл нь давуу тал;
- Улсын төсвөөс авах санхүүжилт сул тал боловч төсвөөс авдаг санхүүжилт, улсын төсвөөс гадуур санхүүжилт, бусад нэмэгдэл нь боломж гэж тодорхойлсон байна;
- Тухайн байгууллага нь туршлагатай, ур чадвартай алба хаагчидтай, гадаад хамтын ажиллагаа сайн, мэргэшүүлэх сургалтад хамрагддаг гэсэн дүгнэлт гарч байна;
- Мэдээллийн ил тод, нээлттэй байдал, санал, хүсэлт, өргөдөл, шийдвэрлэлт цахим сургалт, уулзалтын боломж сүлжээний хамгаалалт нь давуу тал болсон ч мэдээллийн ил тод байдлыг сул тал гэж дүгнэхээр хариулттай үр дүн гарсан ч мэдээллийн ил тод хэдий чинээ их байна тэр хэмжээгээр мэдээлэл алдагдах боломж их, цахим сургалт уулзалтыг зохион байгуулснаар алба хаагчидтай холбоотой мэдээлэл алдагдах эрсдэл өндөр байна гэж дүгнэж байна.
- Эрх зүйн орчин бүрдсэн байдал, гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрийг хэрэгжилт, урамшууллын эрх зүйн хэрэгжилт, шагнал урамшууллын бодлого, тогтолцоо, хуулийн нэршил, нэр томьёоны хэрэгжилт нь давуу тал гэж дүгнэгдэж байна.

Ашигласан маатриал

- Лутчимэг Х. Удирдахуйн ухаан. УБ., 2015
- ЦЕГ-ын Хар тамхитай тэмцэх газар. Хар тамхитай тэмцэх газрын тайлан, нөхцөл байдлын мэдээ (2018-2022). УБ, 2022.
- Шуурав Я. Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь бичиг. У., 2020.
- G.Murugesan. Principles of Management. University Science Press. 2012.
- Kürschner, S. Empirical research on management control. Doctoral dissertation. 2013.
- Julikar Ali, M. R. Japanese and American Management: A Conceptually Study on Two Conceptions. Journal of Resources Development and Management. 2017.
- McClelland, K. Social structure and control. Science Direct. 2020.